Өмчлөх эрхийн хамгаалалт сэдвийн судлагдсан байдлын хувьд авч үзвэл энэ нь харьцангуй зргөн хүрээтэй ойлголт тул энэ асуудлыг судалсан судлаачдын бүтээл олон байгаа ч илтгэлд дурдсан асуудлыг хөндсөн судалгаа бараг байхгүй байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Энэхүү илтгэлийн зорилго нь практикт тулгамдаад байгаа асуудал гэхээсээ илүү өмчлөх эрхийг хязгаарласан, өмчийн халдашгүй байдлын зарчимд нийцээгүй заалтуудыг илрүүлэхэд чиглэж байгааг энд зориуд тэмдэглэмээр байна. Аливаа хуулийн алдаа мэдгийг мэдсээр байж практикт хэрэглэн улмаар нэг буюу хэд хэдэн хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөний дараа түүнийг тулгамдсан асуудал гэж үзэхээс илүү хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн хуулийн заалт байгаа нь өөрөө тулгамдаж буй асуудал гэж үзэж, хуулийн эдгээр заалтуудыг эргэн харж засаж залруулж байх нь зүйд нийцнэ.

2002 онд Иргэний хууль, 1998 онд Хоршооны тухай хууль батлагдсанаас хойш Иргэний хуульд багагүй хэмжээний нэмэлт өөрчлөлтүүд орж байсан төдийгүй Хоршооны тухай хуульд томоохон хэмжээний өөрчлөлт орсон байдаг. Гэвч эдгээр нэмэлт өөрчлөлтийн хүрээнд илтгэлд асуудал болгон тавьж буй заалтуудад гар хүрээгүй байдаг нь хачирхалтай. Энэ нь хуулийн тухайн заалтууд нь асуудалгүйдээ бус харин хууль тогтоогч өмчлөх эрхийн хязгаарлалт болохыг нь олж хараагүйд л учир бий. Ийнхүү хууль тогтоогч олж харахгүй байгаа нь эдгээр заалт нь практикт түгээмэл хэрэглэгдээд нэг буюу хэд хэдэн субъектын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэх гомдол дагуулахгүй байгаатай холбоотой байж болох юм.

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ ДАХЬ ӨМЧЛӨХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАСАН ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТ

Бүх хүнд нийтлэгээр заяасан дэлхий ертөнц дээр хүн бүр өөрийн гэсэн өмчтэй байдаг

- *Жон Локк*

Түлхүүр үг: Хувийн өмч, өмчлөх эрх, өмчлөх эрхийн хамгаалалт, өмчлөх эрхийн хязгаарлалт, нүцгэн эрх чөлөө

МОНГОЛ УЛС ДАХЬ ӨМЧЛӨХ ЭРХИЙН ТӨЛӨВШИЛ

Монгол улсын зарим хууль тогтоомж дахь өмчлөх эрхийг хязгаарласан зохицуулалт сэдвийг хүрээнд өмчлөх эрхийг хязгаарласан зохицуулалтуудыг хөндөнө. Иймээс тухайн улсад хувийн өмчид хандах хандлага, өмчлөх эрхийн төлөвшил ямар түвшинд байсан, одоо ямар түвшинд байгааг танилцуулах нь зүйтэй гэж үзлээ.

Өмчлөх эрхийн талаар олон зууны туршид сэтгэгчид оюун ухаанаа уралдуулан эргэцүүлсээр жам ёсны эрх гэж нэгэнт тогтсон төдийгүй хүний угаас заяасан туйлын эрх гэдгийг эртний Ромын эрх зүйгээс эхлэн томъёолсон юм.¹⁾

Өмчлөх эрх, хувийн өмчийг хүний эрх, эрх чөлөөний салшгүй хэсэг гэдэг утгаар нь өмчид хандаж, түүнийг төрөлх эрхийн онолын үүднээс тайлбарласан сэтгэгчдийн нэг нь Жонн Локк билээ. Тэрээр албадан хязгаарлаж болдог зарим эрхүүдийн дундаас өмчлөх эрхийг тусад нь салгаж, хязгаарлаж болдоггүй эрхүүдтэй нэгтгэх алхмыг хийжээ. Тодруулбал “**өмчлөх эрх бол амьд явах эрхтэй нэгэн адил үндсэн эрх болон бичигдэх ёстой.**” -гэж үзсэн. Харин Ф.Гегель хүний эрхийн үндэс нь өмчлөх эрх бөгөөд энэ нь юуны өмнө хувийн өмч эзэмших эрхээр илэрдэг.²⁾-гэсэн байна. Энэ мэтчилэн өмчлөх эрхийг жам ёсны

1) Совд.Г”Үндсэн хуулийн тайлбар УБ., 2000, 44 дахь тал

2) Агар-Эрдэнэ Г.”Хувийн өмчийн онол” УБ., 2009, 56 дахь тал

эрх хэмээн үзсэн сэтгэгчдийг цааш дурдаж болно.

Өмчлөх эрхийг жам ёсны эрх гэж үзэж буй үндэслэл нь нэг талаас хүн төрөхдөө ертөнц дээр шалдан ирдэг ч өөрийгөө өмчлөх эрхтэй гэдэг утгаараа хүн өмчтэй төрдөг. Тиймээс өмчлөх эрх нь төрөлх эрх юм. Нөгөө талаас өмч гэдэг бол хүний оршихуйн үндэс. Өмчгүй хүн гэж байхгүй, ямар нэгэн зүйлийн өмчлөгч байдаг нь үнэн. Ийнхүү өмчгүйгээр хүн оршин байх боломжгүй, хүн бүр өмчтэй байдаг гэдэг утгаар нь өмчлөх эрхийг төрөлх эрх гэж үздэг байна. Хэрэв энэхүү жам ёсны эрхийг нь хязгаарлан, өмчийг нь бүхэлд нь хураан авбал хүн оршиход бэрх болно. Энэ ч утгаараа Францын хүний ба иргэний эрхийн тунхаглалын арван долдугаар хэсэгт **“Өмчтэй байх нь халдашгүй, ариун эрх..”** гэж заажээ.

Жам ёсны эрх нь өөрөө өөрийнхөө үндэслэл баталгаа болдог³⁾ ч эрх зүйгээр хамгаалах зайлшгүй шаардлагатай байдаг төдийгүй өмчлөх эрхийг хамгаалаагүй тохиолдолд энэ эрх нь **“Нүцгэн эрх чөлөө”**⁴⁾ болдог байна. Хувийн өмчийг хамгаалах ёстой гэдэг нь нэгэнт тогтсон аксиом тул энэ талаар цааш нурушилгүй үндсэн асуудалд анхаарлаа хандуулья.

Өмчлөх эрх, хувийн өмчийн талаарх үзэл сэтгэлгээ Монгол улсад харьцангуй шинэ тутам бий болсон хэдий ч зохих хэмжээнд төлөвшиж байгаа гэж үзэж болно. Учир нь манай улс нийтийн эрх зүйг хувийн эрх зүйгээс дээгүүр үнэлж хүний жам ёсны эрх, хувийн өмчийг хуулиар хориглон хязгаарласан, нийгмийн харилцааг нам- улс төрийн удирдамж, горим журмуудаар зохицуулж ирсэн.⁵⁾ Харин 1990 оноос хувийн өмчид хандах үзэл сэтгэлгээ өөрчлөгдөн хувийн өмчийг хүлээн зөвшөөрөх хандлага бий болсон. Тодруулбал Улсын Бага Хурал 1991 онд Төрийн өмч хувьчлах тухай хууль гаргаж, хувийн өмчийн хэлбэрийг улам баталгаажуулж төрийн өмчийн хувьчлалын ажил эхэлж нийгэмд хувийн өмч өмчлөлийн харилцаа бий болж улмаар 1992 оны Үндсэн хууль батлагдан гарсанаар иргэдийн хувийн өмчийн хэлбэрийг тунхагласан эдийн баялгийн эрх жинхэнэ утгаараа үүсч хөгжих эхлэл тавигдсан.⁶⁾

1992 оны Монгол улсын Үндсэн хуулиар хувийн өмчийг хүлээн зөвшөөрсөн. Хэдийгээр хувийн өмчийг хүлээн зөвшөөрөх тухай ойлголт байх учиргүй⁷⁾ ч Монгол улсад хувийн

3) Дэвид Боаз., Либертарианизм 97 дахь тал

4) Агар-Эрдэнэ Г. “Хувийн өмчийн онол” УБ., 2009, 140 дахь тал

5) Должин.Д., Монгол дахь иргэний нийгмийн төлөвшлийн философи, улс төр, эрх зүйн асуудал “Иргэний нийгмийн төлөвшлийн эрх зүйн орчин” өгүүлэл 214 дахь тал

6) Жамбалдорж.О., Амарсайхан.Ж., Ариунзаяа.Ж. Монгол Улсын Иргэний эрх зүй УБ., 2006.18 дахь тал

7) Хүний жам ёсны эрхийг төр хүлээн зөвшөөрдөггүй, зөвхөн хамгаалах үүрэгтэй юм.

өмчийг хүлээн зөвшөөрдөггүй байсан төдийгүй хувийн өмчийг үгүйсгэх үзэл сэтгэлгээг халхад юуны өмнө хүлээн зөвшөөрөх нь тухайн үеийн нийгмийн шаардлагатай байсан биз ээ.

Иргэний хуулийг эргэн харвал Тухайлбал 1952 оны Иргэний хуулийн 31 дүгээр зүйлд “Бүгд Найрамдах Монгол Ард Улсад Улсын өмч, Хоршооллын ба бусад олон нийтийн байгууллагуудын өмч, ард иргэдийн амины өмч гэж байна.”-гэж заасан төдийгүй “Улсын өмчийн объект нь ямар ч эд хөрөнгө байж болно”-гэж заасан атлаа 32-р зүйлд “Ард иргэдийн амины өмчийн зүйл бол БНМАУ-ын үндсэн хуулийн 6-р зүйлд заасан эд хөрөнгө байна” гэж амины өмчийн хүрээг хязгаарлаж байжээ. Харин 1964 оны Иргэний хуулийн зарим заалтад 1990 онд өөрчлөлт орсноор “хувийн өмч” хэмээх нэр томъёог Монгол улсын хууль зүйн шинжлэх ухаанд хэрэглэх болсон. Иймээс тус улсын хувьд хувийн өмчид хандах үзэл сэтгэлгээнд томоохон өөрчлөлт гарсан гэж үзэхээс аргагүй юм.

ӨМЧЛӨХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАСАН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол улсын хувьд 2002 онд Иргэний шинэ хуулийг батласнаар эрх зүйн томоохон шинэчлэлт хийж, хувийн эрх зүй, нэн ялангуяа өмчийн эрх зүйн хөгжлийг тодорхойлсон. Тухайлбал, Иргэний хуульд анх удаа эд юмсын хязгаарлагдмал эрх болох бусдын газар дээр барилга байгууламж барих эрх, сервитут, узуфрукт болон хөршийн эрхийн зохицуулалтыг оруулж ирсэн.

Ийнхүү Иргэний хууль нь эд юмсын хязгаарлагдмал эрхүүдийн шинэлэг зохицуулалтыг агуулахаас гадна өмчлөх эрхийн баталгаа болсон суурь зарчим, хэм хэмжээг хуульчилсан. Иргэний хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2 дах хэсэгт “Иргэний хууль тогтоомж нь өмчийн халдашгүй байдлын зарчимд үндэслэнэ”- гэж заасан байна. Энэ нь зөвхөн Иргэний хууль бус бусад хувийн эрх зүйн хууль, хуульчилсан акт нь өмчийн халдашгүй байх зарчимд үндэслэх хууль зүйн шаардлагыг хангасан байх шалгуур тавьж буй явдал юм. Энэ зарчмын хүрээнд Иргэний хуулийн 101 дугаар зүйлд өмчлөх эрх, 106 дугаар зүйлд өмчлөгчийн шаардах эрхийн зохицуулалтууд тусгагдсан.

Иргэний хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1. дэх хэсэгт «Өмчлөгч нь бусад этгээдэд хууль

буюу гэрээгээр олгогдсон эрхийг зөрчихгүйгээр, хуулиар тогтоосон хэмжээ, хязгаарын дотор өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах бөгөөд аливаа халдлагаас хамгаалах эрхтэй.» гэж заажээ. Энэ заалт нь өмчлөгчийн эрхийг эерэг болон сөрөг байдлаар тодорхойлсон гэж үздэг.

Эерэг: Өмчлөгч нь өөрийн материаллаг болон материаллаг бус хөрөнгөө чөлөөтэй эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй байна.

Сөрөг: Өмчлөгч нь өөрийн хөрөнгийг аливаа этгээдээс хамгаалах, хэн нэгэн өөр этгээд хөрөнгийг нь ашиглахыг таслан зогсоох эрхтэй байна⁸⁾.

Иргэний хуулийн 106 дүгээр зүйлийн 106.1. дэх хэсэгт «Өмчлөгч хөрөнгөө бусдын хууль бус эзэмшлээс шаардах эрхтэй. « гэж заасан байна.

Монгол улсад өмчлөх эрхийн тухай ойлголт хувийн өмчийг хамгаалах үзэл сэтгэлгээ төлөвшсөн гэж үзэхээр байгаа боловч нийгмийн харилцааг зохицуулагч суурь хууль болох Иргэний хууль болон бусад хуульд өмчлөх эрхийн хамгаалалт хангалтгүй байна. Өмчийн халдашгүй байдлын зарчмын хүрээнд өмчлөх эрхийг эерэг болон сөрөг утгаар тодорхойлж, өмчлөгч хөрөнгөө бусдын хууль бус эзэмшлээс шаардах эрхтэй байх өмчлөгчийн шаардах эрхийг тусгаснаас дүгнэвэл Иргэний хууль нь өмчлөх эрхийг байх ёстой төвшинд хамгаалсан гэж дүгнэж болох хэдий ч өмчлөх эрхийг хамгаалах гэхээсээ илүү өмчлөгчийн эрхийг зөрчсөн дараах зохицуулалт амь бөхтэй байсаар байна.

Тухайлбал,

1. Иргэний хуулийн 237 дугаар зүйлийн 237.9 дэх хэсэг
2. Иргэний хуулийн 175 дугаар зүйлийн 175.4, 175.5 дах хэсэг
3. Хоршооны хуулийн тухай хуулийн 48 дугаар зүйл

Иргэний хуулийн 237 дуугар зүйлийн 237.1 дэх хэсэг:

Иргэний хуулийн хорьдугаар бүлэгт үүрэг дуусгавар болох үндэслэлүүдийг тогтоож өгсөн. Үүрэг дуусгавар болох эдгээр үндэслэлүүдээс үүргийн гүйцэтгэлийг хадгалалтад шилжүүлснээр үүрэг дуусгавар болох үндэслэл нь өмчийн халдашгүй байх зарчмын үүднээс судлаачдын анхаарвал зохих зохицуулалт гэж үзэж байна. Үүрэг гүйцэтгэгч хууль болон

8) Иргэний хуулийн тайлбар 176 дахь тал 2010

гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх гэтэл үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг хүлээн авах объектив болон субъектив боломжгүй нөхцөл байдал үүсч үүргийн гүйцэтгэлийг хугацаандаа хүлээн авахгүй тохиолдол бий болж болно. Энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэгчийн эрхийг хамгаалах шаардлага зүй ёсоор тавигдах бөгөөд энэ асуудлыг шийдвэрлэсэн чухал ач холбогдолтой зохицуулалт бол Иргэний зүйлийн 237 дугаар зүйл юм.

Иргэний хуулийн 237 дугаар зүйлийн 237.1.дах хэсэг

Үүрэг гүйцэтгүүлэгч нь үүргийн гүйцэтгэлийг хүлээн авах хугацааг хэтрүүлсэн, эсхүл түүний оршин суугаа /оршин байгаа/ газар нь тодорхой бус бол үүрэг гүйцэтгэгч нь үүргийн зүйлийг уул үүргийг гүйцэтгэвэл зохих газрын нотариатад, мөнгө буюу үнэт цаасыг нотариатаар дамжуулан банканд хадгалуулахаар шилжүүлэх үүрэгтэй.

Ийнхүү 237 дугаар зүйлд заасан үүргийг гүйцэтгэсэн тохиолдолд үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэсэнд тооцогдож, үүргээс чөлөөлөгдөнө. Энэ нь үүргийн эрх зүйгээр үүрэг гүйцэтгэгчийг хамгаалсан нэн чухал зохицуулалт боловч үүний зэрэгцээ өмчийн халдашгүй байдлын зарчимд нийцэхгүй төдийгүй өмчлөх эрхийг хамгаална гэхээсээ илүү ноцтой зөрчсөн гэж дүгнэхээр зохицуулалт Иргэний хуулийн 237 дугаар зүйлийн 237.9 дэх хэсэгт байна.

Иргэний хуулийн 237 дугаар зүйлийн 237.9 дэх хэсэгт

237.9 Нотариат, өөртөө хадгалуулахаар шилжүүлсэн зүйлийг гурав хүртэл жил хадгалах бөгөөд энэ хугацаанд үүрэг гүйцэтгүүлэгч уг зүйлийг хүлээн аваагүй бол энэ тухай үүрэг гүйцэтгэгчид мэдэгдэж хадгалуулсан зүйлээ буцааж авахыг түүнээс шаардана. Хэрэв тогтоосон хугацаанд уг зүйлийг буцааж аваагүй бол түүнийг төрийн өмчлөлд шилжүүлнэ»

Үүрэг гүйцэтгэгч нотариатын хадгалалтад шилжүүлж байгаа хөрөнгө нь хөдлөх хөрөнгөнд л хамаарахаар байна. Хадгалалтад шилжүүлж буй нь үүрэг гүйцэтгэгч үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хууль болон гэрээнд заасан хөрөнгийн шилжүүлэг хийх үүргээ биелүүлж байгаа явдал юм. Энэ утгаараа нотариатчид тодорхой хөдлөх эд хөрөнгийг шилжүүлсэн тохиолдолд хөдлөх хөрөнгийн өмчлөх эрх үүрэг гүйцэтгүүлэгчид шилжиж байгаа нь харагдаж байна. Үүнээс хархад Иргэний хуулийн 237.9 дэх хэсэг нь үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөх эрхэд халдсан зохицуулалт болсон байна.

Энд дараах асуудлыг анхаарах хэрэгтэй.

1. Үүрэг гүйцэтгэгч үүргийн зүйлийг нотариатчид шилжүүлснээр үүрэг гүйцэтгүүлэгчид өмчлөх эрх шилжсэн. Иймд үүрэг гүйцэтгүүлэгч 3 жил болход хөрөнгийг аваагүй нь үүрэг гүйцэтгэгчид буцаан шилжүүлэх үндэслэл болох учиргүй. Учир нь хууль болон гэрээнд заасан үүргээ гүйцэтгэж, хөрөнгийг шилжүүлснээр үүрэг гүйцэтгэгчийн өмчлөх эрх дуусгавар болж, харин үүрэг гүйцэтгүүлэгчид буюу шинэ өмчлөгчид өмчлөх эрх шилжсэн. Ийнхүү өмчлөх эрх шилжсэн байхад үүрэг гүйцэтгэгчид буцаан авах үүрэг хүлээлгэж байгаа нь ойлгомжгүй байна.
2. Үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг нотариатад хадгалуулснаас хойш 3 жил өнгөрөхөд хөрөнгийг ирж аваагүй гэдэг үндэслэлээр өмчлөгчийн /үүрэг гүйцэтгүүлэгчийн/ өмчлөх эрхийг дуусгавар болгож болохгүй. Өөрөөр хэлбэл өмчлөх эрхээсээ татгалзсан гэж үзэх боломжгүй юм. Өмчлөх эрхээсээ татгалзах хүсэл зориг байсан эсэхийг анхаарахгүйгээр төрийн өмчлөлд шилжүүлэх нь өмчлөгчийн өмчлөх эрхийг ноцтой зөрчсөн үйлдэл болох нь харагдаж байна.
3. Үүрэг гүйцэтгэгч үүргийн гүйцэтгэлд шилжүүлж, нотариатад хадгалуулсан зүйлийг үүрэг гүйцэтгүүлэгч хуульд заасан хугацаанд ирж аваагүйн улмаас үүрэг гүйцэтгэгч буцаан авсан тохиолдолд өмчлөх эрх буцаад үүрэг гүйцэтгэгчид шилжиж байгаа эсэх эсхүл үүрэг гүйцэтгүүлэгч үүрэг гүйцэтгэгчээс шаардах эрхтэй байх эсэх нь тодорхойгүй байна

Энэ нь өмчлөх эрхийг зөрчсөн төдийгүй эрх зүйн тодорхойгүй байдлыг бий болгож байна.

Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх шийдвэр гарснаар өмчлөх эрхээ алдах:

Үүргийн гүйцэтгэлийг хангах аргын нэг болох барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулах нь зүй ёсонд нийцэх төдийгүй энэ нь угаасаа барьцааны зорилго, чиг үүрэг юм. Нэн ялангуяа шүүхийн шийдвэрийн үндсэн дээр барьцаа хөрөнгийг худалдан борлуулах замаар үүргийн гүйцэтгэлийг хангуулдаг. Ийнхүү барьцааны зүйлийг албадан худалдах нь зүй ёсонд нийцэх боловч энэ тохиолдолд барьцаалуулагч эрх, хууль ёсны ашиг сонирхолыг нь зөрчих нэн ялангуяа өмчлөх эрхийг нь зөрчиж болохгүй нь тодорхой билээ. Гэтэл Иргэний хуульд барьцаалуулагчийн өмчлөх эрхийг хязгаарласан зохицуулалт 2002 онд Иргэний хууль батлагдах үеэс өнөөг хүртэл амь бөхтэй байсаар байна. Тодруулбал,

175 дугаар зүйлийн 175.4. дэх хэсэг

175.4. Үл хөдлөх эд хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах шийдвэр гарснаар үүрэг гүйцэтгэгч уг эд хөрөнгийн үр шимийг өөртөө үлдээх эрхээ алдана.»

175 дугаар зүйлийн 175.5. дэх хэсэг

175.5. Үүрэг гүйцэтгэгч ипотекийн зүйл болох байшин, эсхүл түүний тодорхой хэсэгт өөрөө буюу гэр бүлийн гишүүдийн хамт оршин сууж байгаа бол ипотекийн зүйлийг албадан худалдах тухай шүүхийн шийдвэр гарсан үеэс хөлслөгч болж, үүрэг гүйцэтгүүлэгчид орон сууц хөлсөлсний хөлсийг, тухайн үеийн ханшаар төлөх үүрэгтэй.

Иргэний хуулийн дээрх заалтуудаас харвал

1. Шүүхээс шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай шүүгчийн захирамж гарсанаар өмчлөгч хөрөнгийн үр шимийг хүртэх эрхээ алдах үр дагавартай
2. Шүүхээс шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай шүүгчийн захирамж гарсанаар өмчлөгч хөлслөгч болж хөлс төлөх үүрэгтэй болно.

Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх шийдвэр гарах нь өмчлөгчийн өмчлөх эрхийг дуусгавар болгож байгаа байдлаар зохицуулжээ. Иргэний хуулийн 110.1 дэх хэсэгт «Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх хэлцлийн үндсэн дээр нэг этгээдээс нөгөөд шилжиж байгаа бол уг хэлцлийг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар бүртгүүлснээр өмчлөх эрх шинэ өмчлөгчид үүсэж, өмнөх өмчлөгчийн өмчлөх эрх дуусгавар болно.» гэж заасны дагуу үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх дуусгавар болно. Гэтэл үл хөдлөх хөрөнгө шинэ өмчлөгчид шилжээгүй байхад үр шим хүртэх эрхгүй, улмаар орон сууцны хувьд хөлслөгч гэж тооцогдохоор заасан нь албадан гүйцэтгүүлэх шүүхийн шийдвэр гарснаар өмнөх өмчлөгчийн өмчлөх эрх дуусгавар болж байгаа байдлаар зохицуулсан гэж үзэж байна.

Жишээ нь:

А нь Б банкнаас 40 сая төгрөг зээлсэн боловч зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй тул шүүхээр шийдвэрлүүлэх болжээ. шүүх А-аас 40 сая төгрөгийг гаргуулж Б банканд олгохоор

шийдвэрлэж, тухайн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар газрыг барьцаалсан байсан тул А нь сайн дураар шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд барьцаа хөрөнгийг худалдан борлуулах замаар үүргийг гүйцэтгүүлэхээр шийдвэрлэжээ. Шүүхийн шийдвэр гарахаас 3 сарын өмнө А нь тухайн газар дээр хүнсний ногоо тариалсан байжээ. Мөн А нь шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй тул шүүхээс албадан худалдах тухай шийдвэр гарсан гэж үзье. Гэвч тухайн хөрөнгийг дуудлага худалдаа явагдсан боловч хэн ч худалдан аваагүй 5 сар болжээ.

Энэ тохиолдолд А нь Иргэний хуулийн 175 дугаар зүйлийн 175.4-г зааснаар тухайн тариалсан хүнсний ногоог хураан авах боломжгүй болно. Тэгвэл үл хөдлөх хөрөнгийг худалдан авах шинэ өмчлөгч гартал хөрөнгийг хэн өмчлөх вэ? , Тухайн хүнсний ногоог хэн хураан авч, газрын үр шимийг хүртэх вэ? зэрэг асуудал тулгарах болно.

Энд өмчийн эрх зүйн суурь зарчим, өмчлөх эрх үүсэх, дуусгавар болох үндэслэл болсон зохицуулалтуудийг анхаараагүй байна. Иргэний хуулийн 112 дугаар зүйлийн 112.1. дэх хэсэгт “Талууд шилжүүлж байгаа эд хөрөнгийн үнийг бүрэн төлснөөр тухайн эд хөрөнгийг өмчлөх эрх шилжинэ гэж тохиролцсон бол ийнхүү үнийг бүрэн төлснөөр өмчлөх эрх шинэ өмчлөгчид шилжинэ.” гэж заасан Иргэний хуулийн 178 дугаар зүйлийн 178.2. дах хэсэгт “Дуудлага худалдаагаар худалдсан зүйлийн үнийг бүрэн төлсөн үеэс худалдан авагч тухайн зүйлийн өмчлөгч болно.” гэсэн заалттайгаа уялдуулаагүй, өмчлөх эрхийг хязгаарласанаас дээр дурьдсан хоёр асуудал тулгарч байна.

Хоршооны тухай хуулийн 48 дугаар зүйл.

Хоршооны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1. дэх хэсэгт⁹⁾ “Хоршооны үйл ажиллагаа дуусгавар болоход хуваах боломжгүй үлдэгдэл хөрөнгийг тодорхой зориулалтаар хэрэглүүлэхээр шилжүүлэхийг хоршооны дүрэмд тусгайлан заагаагүй бол уг хөрөнгийг нийтийн хэрэгцээнд зориулан ашиглуулахаар хоршооны төв оршиж байсан нийслэл, аймаг, сум, дүүргийн өмчид шилжүүлнэ.”- гэж заасан байна.

Энэ нь Иргэний хуульд заасан өмчийн халдашгүй байдлын зарчимд нийцээгүй заалт

9) 2002 оны 12 дугаар сарын 12-ны хоршооны тухай хуульд томоохон нэмэлт өөрчлөлтүүд орсон боловч уг заалт хэвээр үлдсэн байна.

болсон байна. Хоршооны эд хөрөнгийг нийслэл, аймаг, сум, дүүргийн өмчлөлд шилжүүлэх нь хоршооны гишүүдийн өмчлөх эрхийг зөрчиж байгаа асуудал мөн.

Хоршооны хөрөнгө нь хэний хөрөнгөөс бүрддэг вэ? Энэ асуултад хариулснаар хоршооны хөрөнгийг бусдын буюу нийслэл, аймаг, сум, дүүргийн өмчид шилжүүлж болохгүй гэсэн дүгнэлтэд хүрч болно. Дээрх асуултад хариулахын тулд хоршооны ойлголт, хоршооны хөрөнгийн эс үүсвэр хоёрыг авч үзье.

Доктор Т.Мөнхжаргал Үүсгэн байгуулагчид сэтгэл санаа эд хөрөнгө, хөдөлмөрөө нэгтгэн хамтран ажиллах зорилгоор байгуулсан аж ахуй нэгж буюу хуулийн этгээдийг хоршоо гэнэ.¹⁰⁾ гэж тодорхойлсон бол,

Иргэний хуульд:

Иргэний хуулийн 36.4. –т «Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, хамтын удирдлага, хяналт бүхий дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ.» гэж заасан байна.

Хоршооны тухай хуульд:

Хоршооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, ардчилсан, хамтын удирдлага, хяналт бүхий, дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар хамтран байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ.”- гэж тус тус тодорхойлжээ.

Дээрхээс дүгнэвэл хоршоо нь сайн дурын үндсэн дээр нэгдсэн, хамтын удирдлага хяналттай, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, энэ хөрөнгө нь хоршооны гишүүдийн дундын эд хөрөнгө дээр үндэслэсэн зохион байгуулалтын нэгдэл байна. Хоршооны тухай хуульд зааснаар хоршооны эд хөрөнгө нь дараах эс үүсвэрээс бүрдэнэ.

Үүнд

1. гишүүнээс нийлүүлсэн хувь хөрөнгө;

10) Мөнхжаргал.Т., Цолмон Ц., “Бизнесийн эрх зүй” УБ.,2000 22 дахь тал

2. дүрэмд заасан бол гишүүний элсэлтийн татвар;
3. хоршооны үйл ажиллагааны орлогоос хоршооны болзошгүй алдагдлын нөөц санд хуваарилсан хөрөнгө;
4. бэлэглэсэн, хандивласан хөрөнгө
5. хоршооны өмчлөл дэх бусад хөрөнгө.

Хоршооны хөрөнгийн эх үүсвэрт юуны өмнө гишүүдээс нийлүүлсэн хувь хөрөнгө хамаарах бөгөөд энэ нь хоршоог үүсгэн байгуулах үеийн эхлэлтийн хөрөнгө байна. Харин бусад хөрөнгүүд нь хоршоог үүсгэн байгуулснаас хойш бий болох боломжтой хөрөнгүүд юм. Аливаа хуулийн этгээдийг үүсгэн байгуулахад эхлэлтийн хөрөнгө нэн чухал бөгөөд нэн ялангуяа хоршооны хувьд тодорхой үйлдвэрлэл үйл ажиллагаа явуулж гишүүдийн нийгэм эдийн засгийн нийтлэг хэрэгцээг хангахын тулд эхлэлтийн хөрөнгө хоршооны хөрөнгийн эх үүсвэрт чухал байр суурь эзэлнэ. Хоршооны эхлэлтийн хөрөнгийг хоршооны гишүүд бүрдүүлнэ.

Ийнхүү хоршооны гишүүдийн хөрөнгөөс бүрдсэн дундын хөрөнгийг хуваагдахгүй хөрөнгө гэж үзэн нийслэл, аймаг, сум, дүүргийн өмчлөлд шилжүүлэх нь гишүүдийн өмчлөх эрхэд халдсан заалт байна.

Хуваагдахгүй хөрөнгө гэж байж болох уу?

“Хоршооны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг Улсын дээд шүүхээс¹¹⁾ "хуваах боломжгүй үлдэгдэл хөрөнгө" гэдэгт хоршооны үйл ажиллагаа дуусгавар болоход түүний хөрөнгөнөөс үлдсэн мөнгөн болон биет байдлаар гишүүдэд хуваан олгох боломжгүй хөрөнгө болон эд хөрөнгийн эрх хамаарах бөгөөд түүнийг тодорхой зориулалтаар шилжүүлэх талаар хоршооны дүрэмд заагаагүй бол хоршооны төв оршиж байсан нийслэл, аймаг, сум дүүргийн /орон нутгийн/ өмчид шилжүүлэхийг хамааруулна гэж тайлбарлаж байжээ.

Хэрвээ хуваах боломжгүй хөрөнгө гэж шууд утгаар нь ойлгодог бол зөвхөн хоршооны

11) Улсын дээд шүүхийн 2000 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн дугаар 02 тогтоолын 24 дэх хэсэг, Энэ тогтоол нь 2007 онд Хоршооны тухай хуулийг тайлбарласан тогтоол гарснаар хүчингүй болсон боловч 2007 оны тогтоолоор уг заалтыг тайлбарлаагүй. Харин хоршооны тухай хуулийн 48 дугаар зүйл хүчин төгөлдөр хэвээр үйлчилж байгаа болно.

хөрөнгөөс гадна бусад хөрөнгийн зохицуулалтад ч хуваах боломжгүй хөрөнгө гэдэг ойлголт гарч ирж хүндрэл учруулах байсан.

Тухайлбал, хоршооны хөрөнгөөр барилга барьсан бол түүнийг хуваах боломжгүй гэж үзэн бусдын өмчлөлд шилжүүлэх болж байна. Ийнхүү Хоршооны тухай хуулийн 48 дугаар зүйл нь өмчлөх эрхийг хязгаарлаад зогсохгүй өмчлөх эрхэд халдсан зохицуулалт болжээ гэж дүгнэж байна.

Дээрх зохицуулалтуудыг Иргэний хуулийн 103.1 дэх «Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлана» гэж заасны дагуу хязгаарласан хязгаарлалт гэж үзэж зөвтгөж болох уу?

Хуульд заасан үндэслэлээр өмчлөх эрхийн хязгаарлах

Үндсэн хуульд заасан эрхийг баталгаатай эдэлдэг ёстой хэдий ч нийгмийн зайлшгүй хэрэгцээ шаардлагаар уг эрхийг хуулиар хязгаарлаж болно. Ийнхүү хуулиар хязгаарлах боломжийг Монгол улсын Үндсэн хуулийн 103.1 дэх «Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлана» гэж заасан нь Үндсэн хуулийн шинжтэй зохицуулалт бөгөөд Үндсэн хуулийн эрх зүйн хүрээнд нийгмийн зайлшгүй шаардлагаар хязгаарладаг. Энэ нь хувийн эрх зүйд ч хамаарах бөгөөд мөн хувийн эрх зүйд өмчлөгч хэн нэгэнтэй өмчлөлийн зүйлээ ашиглуулах талаар гэрээ байгуулах явдал нээлттэй бөгөөд үүний дүнд өмчлөгчийн өмчлөх эрх хязгаарлагдах болно.¹²⁾

Улмаар Иргэний хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх хэсэгт «Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлана.» гэж заасан нь Үндсэн хуулийн шинжтэй зохицуулалт бөгөөд Үндсэн хуулийн эрх зүйн хүрээнд нийгмийн зайлшгүй шаардлагаар хязгаарладаг. Энэ нь хувийн эрх зүйд ч хамаарах бөгөөд мөн хувийн эрх зүйд өмчлөгч хэн нэгэнтэй өмчлөлийн зүйлээ ашиглуулах талаар гэрээ байгуулах явдал нээлттэй бөгөөд үүний дүнд өмчлөгчийн өмчлөх эрх хязгаарлагдах болно.¹²⁾

Хувийн эрх зүйд өмчлөх эрхийн хязгаарлалт нь өмчлөгчийн ашиг сонирхлын үүднээс эд юмсын хязгаарлагдмал эрхийн хүрээнд бий болно. Өөрөөр хэлбэл бусдын газар дээр барилга байгууламж барих эрх, сервитут, узуфрукт, болон хөршийн эрх, барьцааны харилцаанд өмчлөгчийн эрхийг хязгаарлах боломжтой. Энэ нь өмчлөгчийн хүсэл зоригтой шууд хамааралтай буюу өмчлөгч сайн дурын үндсэн дээр өмчлөх эрхээ хязгаарлуулж байгаа юм.

Өмчлөгч нь эрхээ хэрэгжүүлэх нь бусдын өмчлөх эрхтэй хууль зүйн хувьд ямар нэгэн байдлаар хамаарах шинжтэй байдаг зайлшгүй нөхцөлийг харгалзан эрхээ хэрэгжүүлэх зорилгоор бусдын эрхийг хязгаарлах гэсэн ойлголтыг тодорхойлдог. Энэ тухай судлаач

12) Иргэний хуулийн тайлбар., 2010 он 179 дахь тал

Н.Чинбат авч үзэхдээ бусдын өмчлөх эрхийг хязгаарлаж байгаа нь эрх бүхий этгээдийн эрх, ашиг сонирхлыг хангахад чиглэгдсэн төдийгүй, өмчлөх эрх нь зайлшгүй хөндөгдөж буй этгээдийн эрх, ашиг сонирхлыг хууль зүйн хувьд баталгаажуулан хамгаалж буй эрх зүйн механизм гэж ойлгоно.

Ийнхүү хязгаарлах эрх зүйн механизм нь бусдын газар дээр барилга барих эрх, сервитут, узуфрукт, хөршийн эрхийн зохицуулалтын хүрээнд хэрэгжинэ¹³⁾ гэжээ. Иймээс хувийн эрх зүйн хууль тогтоомжоор өмчлөх эрхийг дээрхээс бусад тохиолдолд хязгаарлаж болохгүй гэж үзэхээр байна. Иймд энэхүү илтгэлд дурьдсан заалтууд нь юуны өмнө хувийн эрх зүйн хууль тогтоомжоор нийгмийн зайлшгүй хэрэгцээ шаардлага гэдгийг тодоохойлон бусдын хөрөнгөд халдаж болохгүй бөгөөд нөгөө талаас эдгээр заалтууд нь нийгмийн зайлшгүй хэрэгцээ шаардлагаар бусдын өмчлөлд шилжүүлж байгаа зүйл биш юм.

ДҮГНЭЛТ

Монгол улсад өмчлөх эрхийг хамгаалах, хувийн өмчийн талаар үзэл сэтгэлгээ төлөвшсөн боловч өнөөдрийг хүртэл Иргэний хууль тогтоомжид өмчлөгчийн эрхийг хязгаарласан өмчлөх эрхэд халдсан зохицуулалтууд байсаар байна.

Нотариатад үүргийн гүйцэтгэлийг хадгалуулах нь үүрэг дуусгавар болох нэг үндэслэл болохоор Иргэний хуульд заасан нь үүрэг гүйцэтгүүлэгчийг хамгаалсан зохицуулалт боловч үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг авахгүй 3 жил болсноор төрийн өмчлөлд шилжүүлэх үндэслэл болох нь үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчид халдсан зохицуулалт болжээ.

Шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхээр дуудлага худалдаа явуулах шийдвэр гарснаар тухайн хөрөнгийн үр шимийг хүртэх эрхийг хязгаарласан нь өмчлөх эрхийн хязгаарлалт болсон байна. Учир нь өмчлөх эрхийн агуулгаар өмчлөгч өөрөө үр шимийг нь хүртэх учиртай. Үр шимийг хүртэх эрхийг хязгаарласнаар өмчлөх эрх дуусгавар болсон эсэх нь тодорхойгүй байна. Харин Иргэний хуулийн 275 дугаар зүйлийн 275.5 дахь хэсэгт зааснаар барьцаа хөрөнгө нь орон сууц байсан бол албадан дуудлага худалдаа явуулах шийдвэр гарснаар өмчлөгч нь хөлслөгч болохоор зохицуулснаас харвал өмчлөгчийн өмчлөх эрх дуусгавар болсон гэж дүгнэж болохоор байна.

13) Чинбат Н., Иргэний эрх зүйн лекцийн товчоон ерөнхий анги 200 дахь тал

Хоршооны тухай хуулийн 48 дугаар зүйлд хөрөнгийг хуваах боломжгүй хөрөнгө гэдэг ойлголт гаргаж ирэн бусдын өмчлөлийн зүйлд халдсан, өмчлөх эрхийг нь үгүйсгэсэн зохицуулалт болжээ.

Өмчлөх эрхийн үзэл сэтгэлгээ тогтсон улсын хувьд Иргэний хууль тогтоомж нь өмчлөх эрхийг хязгаарласан, өмчлөх эрхэд халдсан зохицуулалт агуулж байгаа нь учир дутагдалтай байна.

Эцэст нь хэлэхэд иргэний хууль тогтоомж дахь дээрхи заалтуудыг өмчлөх эрхийн агуулга, өмчлөх эрх үүсэх, дуусгавар болох үндэслэл болсон зохицуулалтуудтай уялдуулан, өмчийн халдашгүй байдлын зарчимд нийцүүлэн засаж залруулах шаардлагтай байгааг онцлон тэмдэглэе.

Ашигласан эх сурвалж

Хууль тогтоомж

1. Монгол улсын Үндсэн хууль 1992 он ТМ1992 он №1
2. БНМАУ-ын Иргэний хууль 1926 он
3. БНМАУ-ын Иргэний хууль 1952 он
4. БНМАУ-ын Иргэний хууль 1963 он
5. Иргэний хууль 1994 он /Шинэчилсэн найруулга/ ТМ 1995он №1
6. Иргэний хууль 2002 он ТМ 2002 он №7 (244)
7. Хоршооны тухай хууль 1998 он, / ТМ1998 он №2/
8. Улсын дээд шүүхийн тогтоол 2000 оны 01 сарны 19-ны өдрийн №02

Ном, сурах бичиг

1. Г.Совд."Үндсэн хуулийн тайлбар УБ., 2000 он
2. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар УБ., 2010 он
3. Г.Агар-Эрдэнэ "Хувийн өмчийн онол" УБ., 2009 он
4. Дэвид Боаз. "Либертарианизм" УБ., 2008 он
5. О.Жамбалдорж., Ж.Амарсайхан.Ж.Ариунзаяа. "Монгол Улсын Иргэний эрх зүй" УБ., 2012 он
6. Н.Чинбат Иргэний эрх зүйн лекцийн товчоон (ерөнхий анги) УБ., 2014
7. Монгол дахь иргэний нийгмийн төлөвшлийн философи, улс төр, эрх зүйн асуудал УБ., 2014

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ ДАХЬ ӨМЧЛӨХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАСАН ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТ

모든 사람은 세상에서 공평하게 태어났다, 사람마다 소유할 권리가 있다.

- 존 로크

Хүн төрөлхтөнд нийтлэгээр заяасан дэлхий, ертөнц дээр хүн бүр өөрийн гэсэн өмчтэй байдаг

- Жон Локк

Товч агуулга

Энэхүү илтгэлийн хүрээнд Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй Иргэний хууль тогтоомжид өмчлөгчийн эрхийг хязгаарласан гэж үзэж буй зарим заалтуудыг гарган тавихыг зорьлоо.

Иргэний хуульд үүрэг гүйцэтгэгч үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид хүлээлгэн өгөх боломжгүй бол нотариатад шилжүүлж болно. Ийнхүү шилжүүлсэн зүйлүүдийг үүрэг гүйцэтгүүлэгч хуульд заасан хугацаанд аваагүй бол төрийн өмчлөлд шилжүүлэх, албадан дуудлага худалдаанд оруулах шүүхийн шийдвэр гарснаар өмчлөгч нь тухайн хөрөнгийн үр шимийг хүртэх эрхгүй болох, хоршоо татан буугдахад хуваагдах боломжгүй хөрөнгийг сум, дүүргийн өмчлөлд шилжүүлэх зэрэг өмчлөх эрхийг хязгаарласан зарим заалтуудыг судлан дүгнэлт хийлээ.

үлхүүр үг: Хувийн өмч, өмчлөх эрх, өмчлөх эрхийн хамгаалалт, өмчлөх эрхийн хязгаарлалт, нүцгэн эрх чөлөө

CURRICULUM VITAE



Lhagvasuren BANZRAGCH

E-mail Banzragch_1@num.edu.mn

Employment experience Lecturer, Department of Private law, NUM school of law
2014 Teaching subjects; Contract law
2007-2014 - Lecturer, Department of Humanities, Institute of Commerce and Business.
Teaching subjects; Contract law, Business law.
2006-2007 Lawyer , Anand& Batzaya LLC.

Education: Graduate School, Mongolia National University
2007

2002-2006 Mongolia National University , Law school, BA of Law.
Major: Contract law, Business law

2007-2009 Mongolia National University , Law school, MA of Law.
Major: Contract law

Affiliation: Advocate ,
Member, Association of Mongolian Advocates
Member, Mongolian Bar Association

‘몽골 민법상 소유권 제한 규정에 대한 의문’에 대한 토론문

토론자 : 국민대학교 법과대학 안경희 교수

몽골 민법상 소유권 제한 규정의 문제점에 대한 반즈락흐 교수님의 발표 잘 들었습니다. 몽골민법상 소유권 및 소유권 제한 규정에 대하여 공부할 수 있는 좋은 기회를 주신 반즈락흐 교수님께 감사드리면서 몇 가지 질문을 드리고자 합니다.

1. 부동산 소유권의 이전시기

제110조 제1항에 따르면 부동산이 계약서의 의해 한 사람에서 다른 사람에게로 이전한 경우, 본 계약서가 부동산 등기소에 등록된 후에야 비로소 당해 부동산의 소유권이 새로운 소유자에게 이전하는데, 이 규정의 해석에 대하여 궁금한 점이 있습니다.

먼저 부동산에 관한 매매 계약은 구두계약이 아니라 ‘계약서 작성’이라는 일정한 방식을 취해야만 법적인 효력이 있는지요? 아울러 이러한 계약서는 -약관과 같이- 미리 작성되어 있는 서식을 사용하나요, 아니면 일정한 방식 없이 당사자들이 서면에 계약내용을 기재하는 것으로 충분한가요?

나아가 계약서를 부동산등기소에 ‘등록’한다는 것이 어떤 의미인지도 궁금합니다. 계약서를 등록하면 공적인 장부에 그 내용을 기록하고 등록증을 교부하나요? 구체적으로 소유권은 언제 새로운 소유자에게 이전하나요? 가령 등록신청을 한 때, 공적인 장부에 기록한 때, 등록증 같은 증명서를 교부한 때 가운데 언제 소유권이 이전하는지요?

2. 제174조 제4항·제5항의 해석

제175조 제4항에 따르면 법원의 강제 매각 결정으로 소유자가 재산적 이익을 받을 권리를 상실하는 결과를 초래한다고 기술하셨는데, 이 결정은 경매개시결정을 의미하나요, 아니면 경락허가결정을 의미하나요? 이러한 절차를 통하여 부동산을 매수하는 사람은 경락허가시, 경락대금지급시, 부동산등기(등록)시 가운데 언제 소유권을 취득하나요?

제175조 제5항에 따르면 채무자가 저당목적물인 건물이나 그 일부분에 자기 또는 가족/식구들과 함께 입주하고 있는 경우에 저당권의 실행으로 임의경매를 한다는 법원의 결정이 나온 후에는 채무자는 임차인이 되고 채권자에게 차임을 시세가격으로 납부할 의무가 있는데, 이 때의 법원의 결정은 경매개시결정을 의미하나요, 아니면 경락허가결정을 의미하나요?

3. 몽골법상 경매

마지막으로 발표문에 경매, 강제경매, 임의경매, 강제매매 등의 용어가 등장하는데, 이들 용어가 동일한 의미인지, 아니면 상이한 의미인지 궁금합니다. 만일 후자라면 몽골에서도 경매가 지급명령, 화해조서 등을 집행권원으로 하는 강제경매와 담보권실행을 위한 임의경매로 구분되는지 그리고 경매절차는 어떻게 진행되는지에 대해서도 설명해 주셨으면 합니다.

이상입니다. 다시 한 번 좋은 발표문으로 몽골민법을 이해하는 데 도움을 주신 반즈락흐 교수님께 감사드립니다.



Session 1-2

몽골 부동산 담보 문제와 법률 규제

D. YANJINKHORLOO 교수 | 몽골 국립대학



몽골 부동산 담보 문제와 법률 규제

D. Yanjinkhorloo*

I. 서론

II. 연구

III. 부동산의 권리 관계에 대한 등록에 관한 기능의 역할 및 부동산등기의 법적 환경 및 이 대한 개정의 문제

- 저당권설정등기

- 국가등록의 개정

IV. 부동산 담보의 규정과 헌법상의 권리면에서 논쟁이 되고 있는 문제

V. 결론

*얀 징허틀러 몽골국립대 법대 교수/ 변호사

I. 서론

민법에서는 의무 이행을 확정시키는 방법들, 그 중에서도 부동산으로 채권의무를 시행하는 것을 확정하는 경우가 꽤나 많아지고 있다. 그만큼 법적 규정 또한 빠르게 발전하고 있는 분야라고 결론 내릴 정도이다. 이렇게 말하는 이유는 몽골 민법 개정안이 2002년 통과된 이후 부동산 담보에 대해 여러가지 변동이 생겼고, 그 때문에 부동산 담보에 맞춰 개인권리법의 몇 개 조문은 위헌법률이라고 보며 분쟁이 발생되기 때문이다. 따라서, 논쟁이 되고 있는 문제들을 국가 등기 측면에서 검토한 후 헌법재판소에서 부동산담보로 문제를 일으킨 판정과 원인을 밝히고 이 두 문제간의 귀결을 내는 것이 이 논문의 주 목적이다. 이 글을 읽고 본 주제에 대해 국제적으로 각국의 실례와 함께 의견을 나누고 본 실험 연구를 위해 방문 한국측과 해결 방안과 차후 민법 개정에 대한 견해를 나누었으면 한다.

2015년 몽골헌법재판소에서 부동산담보 관련 문제가 다루어졌다. 본 문제는 담보로 내놓은 부동산의 소유권자이자 채무자 본인의 처분권이 있는지 아니면 이런 권리능력 무효인지를 은행의 승인과 연관이 있는지에 관한 것이다. 다른 문제는 토지를 담보로 설정한 경우 채권이행이 불가할 때 금융기관이 법원을 거치지 않고 바로 경매로 넘기는 것이 타당한지, 또한 국민의 사법 재판 신청권을 거래법 상으로 사전에 막아놓는 것이 타당한지에 대한 것이다.

마지막으로, 이 글에서는 상기 분쟁을 발생하게 된 한 가지 이유는 국가등기에 관련한 문제이며 그 대한 근거를 살펴보고자 한다.

II. 연구

1. 몽골의 부동산담보거래법 조사 결과

부동산담보법 문제로 석사 논문이 많이 다루어지고 있다. 예를 들면, G. Oyuntsetseg “부동산담보법의 문제들(2009)”, J. Byambatsetseg “부동산담보법률의 이론과 실제상의 문제점(2009)”, S. Gantsetseg “부동산담보법의 문제들(2010)”, B. Ariunbayar “부동산법의 문제들(2012)”, G. Batjargal 계 “부동산담보(2012)”, 교과서 A. Batsaikhan . “몽골의 부동산법률

(2000)”, D. Yanjinkhorloo 이포텍의 풀이 사전(2008), D. Yanjinkhorloo “몽골국민법과 부동산법” 논문, 2015년도 초판 및 2016년도 제 2판 등이 있다.

기사중에는 J. Battuya “앵글로색슨족의 법률상의 담보개념과 종류, 보증”¹⁾, D. Batulzii “담보권-소지물의 권리에 대하여”²⁾ 등 다수가 있다.

외국에서 활동하는 몽골 연구원들 또한 부동산 담보문제에 대해서 연구하고 있다.

한국 전남대학교 대학원 석사학위논문 T.Burentogtokh “저당권실행과 저당권침해에 대한 구제 - 한국과 몽골 중심으로(2014)”, 1999년 바트치믹이 러시아의 에르후시의 국립대학교에서 은행담보의 주제로 논문을 저술한 바 있다.

III. 부동산의 권리 관계에 대한 등록 관한 기능의 역할 및 부동산등기의 법적 환경 및 이에 대한 개정의 문제

1. 저당권설정등기 현황

우리 나라에서는 처음 1997년도에 부동산에 대한 법이 제정된 이래 2009년도 국가 등기에 대한 법이 새로 통과되었다. 2003년에는 통과된 재산 소유권, 그와 관련된 다른 소유권의 등기 법의 저당권 등록, 모기지로 이전된 등록, 저당권의 요구 조건을 다른 요구 조건으로 바꾸게 된 등기에 관한 재정 등 자세한 조항들이 새로 추가됐다.

저당권 등기에 지켜야 할 규칙

저당권 국가 등기에 대한 정보는 공개되어야 한다.

저당권 설정 등기가 정확해야 한다.

저당권 국가 등기가 통일되어야 한다.

다른 채권자들이 우선적으로 본인 욕구를 이루기 위한 목적으로 채권자가 일정한 부동산을 담보하는 것을 저당권³⁾이라고 말한다. 저당권은 국가 등기소에 등록됨으로 생긴다. 또 저당권

1) “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2003 оны № 2 /45-53 дэх тал/

2) “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2005 оны № 1 /08/ /41-44 дэх тал/

3) Иргэний хуулийн 165 дугаар зүйлийн 165.1 дэх хэсэг

을 서류로 작성해 양쪽이 원하면 공증기관을 통해 확증 받을 수 있다는 법이 있다. 저당권을 본 담보물이 위치하는 등기소에 등록해야 한다.

재산 소유권 및 그와 관련한 등기에 대한 법에 저당권 설정등기, 저당권이 이전된 등기, 저당권의 요구 조건을 다른 조건으로 바꾼 등기 등등 자세한 조항이 있었다. 그런데 그 법의 50% 이상은 무효가 됐기 때문에 법을 새로 수정해서 국회에 상정하는 중이다.

국가 등기소에서 공공에게 알려진 통고서에서⁴⁾ 저당권의 이전된 등기 기록 조사가 하나도 없다는 것은 이러한 등기가 민법에 존재하고 있지만은 그 동안 제대로 지켜지지 않았다는 것을 보여 준다. 저당권이 이전된 기록이 없는 이유는 국가 등기법 제5조5항에 재산 소유권 국가 등기가 다음 종류로 있어야 함을 민법에서 국한했던 이유인 것 같다.

5.5.1. 소유권

5.5.2. 점유권

5.5.3. 사용권

5.5.4. 담보

5.5.5. 보증/ 질권

5.5.6. 임대

5.5.7. 지역권

5.5.8. 용익권;

5.5.9. 지상권

5.5.10. 재정 대출 계약권/금융리스권

위에 법률규정을 재산소유권 국가 등기에 관한 규칙⁵⁾에 재차 나오기 때문일 수 있다. 본 규칙에 소유권에 대한 다른 재산 소유권을 국가 등기한다.

6.1. 소유권과 관계된 나머지 재산소유권을 국가 등기소에 등기할 때 다음 조건 만족시켜야 한다.

6.1.1. 등기하려 하는 계약권은 국가등기법 제5조 5항에 얘기하는 권리들이 어느것 한 가지어야 할 것.

그러나 민법에 저당권이 이전된 자세한 규정이 있다.

4) www.registrationmongolia.com

5) www.legalinfo.mn УБЕГ-ын даргын тушаалаар 2011 онд батлагдсан, “Эд хөрөнгийн эрхийн бүртгэл хөтлөх журам”

재산 소유권 등기 규칙의 7장. 부동산 저당권을 국가에 설정등기를 한다.

7.1. 부동산 저당권을 설정등기를 할 때 민법 제166조166.2⁶⁾, 재산 소유권 및 그와 관련된 다른 권리에 대한 국가 등기법의 4장에 나오는 규정, 부동산 담보 법규정 대로 설정등기를 한다고 하지만 그 규칙이 위의 법들을 국한한 상태로 있는 것 같다.

재산 소유권 등기 기록을 할 규칙의 7.6 규정에: “저당권 및 요구 조건이 변화된 기록을 다음과 같이 등기를 한다.

7.6.1. 민법 제172조⁷⁾ 규정, 재산 소유권, 그와 관련된 다른 재산 소유권 국가 등기법 29번 규정대로 재산 소유권, 그와 관련된 다른 재산 소유권 국가 등기법 27 규정 27.2에 추가내용을 기록한다; 그럼 여기서 **저당권 이전을 추가 내용으로 아니라 독립해서 다른 등기종류로 등기를 해야 되지 않을까 라는 문제 나온다.**

재산소유권 등기 규칙 내용은 기본규정을 따라 국가 등기법에 나오는 10권리로 국한하게 만들어 그 안에 저당권을 단지 새로 생기는 담보 권리로 등기를 하게 된 것은 대립된 결과가 생기는 이유다. 거래은행들이 담보계약의 담보로 잡게 된 편의 변경 인정하지 않고, 전에 담보자의 저당권이 종결된 후 및 대출을 완전 갚고 담보에서 면제되어야 소유를 다른 사람에게 이전을 인정하는 공문서를 준다는 규칙이 있다. 여기서 보면 저당권의 이전등기를 하는 것이 아니라 저당권을 해소시켜야 새로 저당권 설정등기를 한다고 해서 규칙으로 법을 국한하는 경우 있는 것이다. 요약해서, 거래은행들이 담보권의 이전을 인정하지 않고 전 채무자가 대출을 다 갚기를 요구하는 것과 상관이 있다.

저당권의 국가등기가 통일해야 할 규칙이 권리에 대한 모든 등기를 국가등기소에 등록하는 것으로 나타낸다. 이 규칙 충분히 이뤄져 왔으며 국가등기소 및 그 부속기관이 각 도마다 운영했었다. 그러나 이번에/2016/ 조직 변경함으로 국가등기소를 통계지역에 병합하게 되었다.

부동산을 등록해 소유권을 확정할 중요성이 있다⁸⁾.

부동산을 등록함으로 부동산을 소유하는 권리가 어떠한 상황 속에서 완전 보호된다. 국가에 등록된 부동산은 어떤 상황 때문에 소유권이 위반 당하는 경우 소유자가 자기 권익을 보호할 자유가 있다.

6) 166.2. Possessor, debtor and creditor of immovable property shall make a document certifying the amount of demand secured by hypothec, its interest, and period of performing the demand. The owner and creditor of the immovable property shall have hypothec registered in conformity with procedures set forth in the law.

7) Ипотек болон шаардлага шилжих гэсэн 172-р зүйл нь барьцаанд байгаа үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч нь өөрчлөгдөх тохиолдолд банк үүргийн гүйцэтгэлийг өмнөх өмчлөгчөөс шаардах уу, эсхүл шинэ өмчлөгчөөс шаардах уу гэдэг асуултын тодорхой хариултыг агуулаагүй байгаа гэж үзэхээр байна.

8) Зундуй Д., “Монгол Улсын иргэний эрх зүй” /Ерөнхий ба тусгай анги/. УБ., (2001). 124 дэх тал

등록된 부동산은 소유자의 참여 없이 다른 사람의 소유로 되는 것이나 사용권에 이전되면 안된다.

2. 저당권 설정등기 경신 문제

법무부에서 만든 부동산 권리 등기에 대한 법안을 국회로 논의 하기 위하여 상정된 중이다. 경신된 내용들은 모두다 인정될 확률이 많으며 그안에 부동산 및 지상에 기초를 다진 모든 재물을 등록하여 통일 등기 제도를 만든 것으로 되었다. 그럼으로 이미 경신 문제 나왔으니 내용을 넓게 가지고, 원리를 따른 경신을 해야 효과적이며 몇 년 동안 다시 경신 문제가 나오지 않을 것이다. 다음 의견을 넣어주면 더욱 맞을 거라 본다. 이 법안에 국가에 등록될 권리를 가르쳐 주었다. 여기 가르친 9가지 권리는 내용적으로 겹칠 상황 일어날 수 있다. 예를 들어, 토지를 시민, 법인에게 소유와 사용권을 줄 때 시민들에게 가정용도로 아니면 마당으로 주어지고 있다면 법인에게는 도시나 중심지역에 기본적으로 건축용도로, 많지 않는 경우 농사지로 또한 다른 용도로 권리를 주고 있다. 여기서 국가 소유지를 도시나 도시 근처에 건축할 목적으로 권리가 주진다면 이것은 민법150.1에 나오는 남의 땅에 건축하는 권리와 관계 있음으로 땅 소유권으로 아니라 남/국가땅/에 건축할 권리로 등록하는 것이 본 문제를 관련해 더욱 맞으며 양편이 동시에 본 땅을 경계 유통시킬 수가 있다. 이번 법안을 보면 부동산의 국한된 권리에 추가로 땅 소유권, 땅 사용권이 생겼는데 원리의 어떤 규칙을 근거했음을 알 수 없다. 연구자 O. Jambaldorj 기록으로⁹⁾, 재물의 국한된 권리 종류에 땅을 소유하는 권리, 땅 사용권을 포함시켜도 될 것 같지만 원리 계수와 어떤 상황에 위반이 생긴다. 예를 들어, 땅을 소유하지 않고 사용할 수 없다. 공공 권리에 소유에 대해 다른 특별한 인식이 없다.¹⁰⁾ 다른 말로 등록이 잘못 된 권리를 이제 올바르게 고쳐 줄 필요가 있고, 그래야 규칙적인 경신이 될 수 있다. 그렇지 않고 땅을 소유하는 권리로 등록하게 되면 용익권, 남의 땅에 건축할 권리, 지역권 등 등록을 하게 되는데 이렇게 되면 전과 같은 상황이 반복된다.

9) Жамбалдорж О. нар., *Монгол улсын иргэний эрх зүй, эдийн баялгийн эрх, оюуны өмчийн эрх зүй II*. УБ., (2006). 118 дах тал

10) Тэмүүлэн Б., “*Иргэний хууль дахь зөрчилдөөнтэй зохицуулалтууд, анхаарах асуудал*” *Илтгэлийн эмхтгэл*, УБ., (2012). 101 дэх тал

IV. 부동산의 담보 규정과 헌법의 입장에서 쟁론되는 일부 문제

1. 민법과 부동산 담보법 논쟁되는 법 규정

몽골 헌법재판소 2015년 10월달에 다음 논쟁이 해결되었다. 민법 제171조2항 /주택대출의 소유자가 제3자와 맺은 계약이 효력이 있는지 없는지는 채권자의 **동의를** 의한다.¹¹⁾ / 부동산담보법 제27조1항/민법 제 171조대로 담보물을 오직 비담보인의 동의로 타인에게 소유로 양도할 권력이 있다.¹²⁾/제27조2항 /담보물을 담보로 인정한 조건대로 타인에게 양도할 자격이 있다./ 제30조1항 /비담보인 담보물을 대출을 갚는 동안 담보인의 **동의로** 제3자에게 임대주거나 무료로 쓰게 하거나 타인에게 소유로 양도할 수 있다./제30조3항 /담보물을 담보로 잡혀있는 기간에서 초과로 또는 다른 용도로 타인에게 남용 할 때 담보인의 **동의를** 받아야한다/제30조4항 /담보인의 **동의 없이** 본 법의 제30조1항에서 지시한 기간을 초과하고 제3자에게 권력을 허락한 계약은 효력이 없다/제33조1항 /유효있는 본 계약에 **금지되지 않았으면** 비담보인이 담보물을 타인에게 2중 담보할 권력이 있다/제56조1항 /비담보인이 땅 담보한 계약에 다르게 지시하지 않았으면 담보인의 **동의로** 담보된 땅 위에 건축 할수 있는 권력이 있고 계약 조항에 따라 건축된 건물은 담보로 잡히지 않는다 조의 규정이 헌법 제 16조3항을 위반한 것에 대한 결정이다.

2. 부동산 담보에 대한 근본 법칙

부동산담보법을 다음 근거로 증명하고 준수해야 한다¹³⁾.

- 부동산담보 /주택대출/-와 관련된 관계를 민법 제13장 제3절으로 조정했지만 지나치게 개괄적으로 되어있다는 점 법계 조정의 분명하지 않는 상태를 이루고 있음으로 부동산을 담보할 규칙을 정밀히 해주고 의무 수행을 담보로 제공할 조정의 효율을 향상시키기;
- 주택대출의 이차 시장의 발전을 시키고, 외국과 국내의 투자자들을 자본 시장에 끌어 참여시키기 위해서 부동산을 담보할 법적 환경을 만들기;
- 시민들한테 소유토지를 담보할 수 있도록 법적인 환경을 만들어 주고 개인이 자신의 소유

11) Төрийн мэдээлэл, 2002 он № 7

12) Төрийн мэдээлэл, 2009 он № 28

13) www.parl.gov.mn

토지를 담보해서 경제적인 유통을 만들 수 있도록 여건을 입법화하기;

- 은행, 재정 기관이 일을 정상적으로 운영할 수 있도록 해주고 담보물 가치가 떨어질 수 있는 위험들로부터 예방하기;
- 자본시장금융을 증가시킬 수 있도록 법리적 환경을 갖추게 하기;
- 채무자들이 대출을 청해진 기간내로 갚는 관습되기;

은행과 재정 기관들이 자본 시장에서 대출 추가 재원을 찾을 수 있는 조건을 구성하여 인해서 주택대출의 이차 시장의 발전을 시킬 수 있는 중요한 의의가 된다. 주된 목적은 주택 대출의 일차 시장이 형성되고, 주택 대출의 이차 시장을 발전시킬 우선 조건을 갖출 목적으로 본 법을 제정하였다.

시장에 어떤 생산품을 공급하고 또는 영업 업차들한테는 유통 자본을 늘리고 채무를 이행하고, 범위를 넓히기 등의 여러 이유로 대출을 받을수 밖에 없는 상황이 발생한다. 그러나 대출 이자가 적당하고 대출 조건의 유연함이 제일 중요하다. 채권은행과 재정 기관들의 제안해주는 대출 종류들 중에서 업적 필요성에 맞는 대출 종류를 선택하고, 대출 받는 일 중에 별로 관심 갖지 않고 가볍게 여기는 문제점을 일부러 밝히려고 한다. 이것은 대출과 대출담보 계약에 논쟁이 일어난 경우에 법원을 통해서 아니면 재판을 통하지 않고 문제를 풀어 나갈 2가지 방법 중에 선택해야할 문제이다. 여기서 은행과 채무자의 서로 반대된 이익에 대한 의견이 나타난다. 은행에서 기본 대출 계약과 부동산담보 계약 조항에 법원을 통하지 않고 또는 서로 논쟁하지 않고 화해원칙으로 바로 경매로 판다는 조항을 강조한다¹⁴⁾.

3. 주택 대출은 기본 계약 조건과 같이 양도 되는지 민법 172조 어떻게 실행되는가에 대하여

민법 제172조에 주택 대출 조건이 이동되는 관계를 조정했다. 주택대출과 그의 원인이 되는 조건이 같이 실행될수 밖에 없기때문에 계약 조항을 따로 따로 볼 수 없다. 법 조항에 나와 있는대로 공경 받은 주택대출 증명서를 새로운 채무자에게 넘겨주고, 이것에 대해서 등록청에 등록된 조건에 의무가 이동된 걸로 본다. 하지만 실제로 위에 결정은 법에 나와 있는 조정과 다

14) Доржготов А., “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны эрх зүйн орчин ба шинэчлэл”. Үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүйн зарим асуудал онол практикийн бага хурлын эмхтгэл. УБ., (2010). 16 дах тал “...Санхүүгийн түрэмгийлэл” гэсэн нэр томъёо дуулддаг болсон. Эдийн засгийн хямралын нэг эх сурвалж нь үүнтэй ч холбоотой гэж яригдаж байх шиг байна. Санхүүгийн байгууллагын давуу эрхтэй холбоотой ойлголт, энд давуу байдлыг хяналт тогтоох, хязгаарлах тухай асуудал европын орнуудад яригдаж байх шиг байна”

르다. 정확히 말하자면 바양주르흐구역의1구, 테니위의 거리가 있는 골등윌라동을 한국에서 투자 받는 회사가 건설했다. 건축 중에 처음에는 ‘아노프 은행’에서, 다음에는 ‘저쓰 은행’에서, 2007년도에 한국의 ‘하나은행’에서 200억원 빌렸다. 담보로 건설하고 있는 골등윌라동 전체를 아직 완공되지 않았다는 건물 증명서를 받아 각 아파트를 대출 담보로 내놓았다. 완공 되고 나서 사람들이 아파트를 사서 이사후 소유권증명서를 받으려고 했을 때 아파트가 ‘저쓰 은행’과 ‘하나 은행’에서 부동산 담보로 잡혀있고, 대출이 안 갚아졌음으로 아파트 소유증명서가 나올 수 없다는 답을 주었다. 그래서 골등윌라동의 거주자의 요청으로 학자인 저는 거주자의 소유권 증명서를 재판관을 통해 받아 냈었다. 그 후에 모든 거주자가 법적인 이런 절차를 밟아 소유권 증명서를 재판관을 통해서 /우선 민사법원을 통해서, 등록증에 소유자로 등록하기를 부여하고/ 소유권 증명서를 받고 있고, 이 일이 지금도 진행되고 있다. 민사법원 편에서 거주자가 계약대로 값을 지불하고 의무를 다 했기 때문에 소유권을 받아야한다고 본다. 아파트 예약에 대한 계약 조항을 지켰기때문에 거주자들한테 소유권을 주어야한다는 결정이 계속적으로 나온다. 여기서 ‘하나 은행’의 위임자가 행정 법원에 소송을 제기하였다. “재판을 통해 거주자를 소유자로 청하고, 등록증에 소유자로 등록하고, 소유자 증명서를 주었다. 재판 판결이 이렇게 나왔으니 민법 87조1항, 주택 대출과 소유권이 한번에 같이 넘어 원칙대로 거주자의 부동산에 부동산담보권을 같이 등록하기를 거절하는 등록청의 결정이 불법임을 밝혀 주세요” 라는 논쟁을 행정 법원에서 3단계로 확인하고, 거주자의 부동산에 건설회사 대출 부동산담보권이 넘어가지 않는다는 판결 내렸다. 여기서 결론은 부동산담보권이 넘어가야 한다고 보는 이 문제는 첫번째, 민법과 관련된 논쟁을 행정법원에서 재판했고, 두번째는, 부동산 담보에 대해서는 종료에 따라서 구별해주고 보통 부동산 담보와 주택 부동산 담보로 나눈 조정이 민법과 등록법에 매우 필요하다는 것을 다시 한번 보여준다. 이유는 법에 주택 대출권이 소유권과 같이 이동된다고 나와 있지만 민사법원과 행정법원은 위와 반대된 판결을 내렸기때문에 은행 입장에서 대출 담보가 등록청에 등록되어 있지만 담보라는 의미를 잃어버리고, 은행에서 주는 모든 대출이 법적으로 보증이 없다는 것을 보여주고 있다 등으로 보도하고 있었다¹⁵⁾.

15) www.shuukh.mn

V. 결론

그렇다면 현재 판결의 중심내용은 무엇이었나? 민법 제171조2항을 보면 전에는 은행에 담보로 맡긴 부동산을 채무자가 다른이에게 매매, 대여, 증여(선물), 임대 등의 계약을 하기위해서는 우선 채권자인 은행의 동의가 있어야 했다.

또한 은행에서 대출을 받을 때 대출 토지나 건물을 담보물 제공할 때 채무자의 등기원본을 은행에서 대출상환이전까지 소유함으로 인해 대출자는 건물이나 토지에 대해 임대나 다른 어떤 재산권을 행사할 수 없으므로 대출 원금에 비해 과도한 재산상의 권리를 은행 측이 갖게 되는 불합리한 경우가 발생하게 된다.

그러므로 헌법재판소는 다음과 같은 판결을 내렸다. 헌법 16.14에 “모든 국민은 동산, 부동산을 소유, 점유할 권리를 가진다”라고 명시되어있다. 그러나 현실에서는 은행이 대출자의 모든 재산권 행사를 제한 함으로 지나치게 은행측 편의적인 행정적 발상이라 할 수 있다.

은행은 자기들의 손해를 방지하기 위해 국가가 법적으로 보장하는 국민의 재산권 행사를 지나치게 차단하는 월권을 행사한다고 법원은 판결하였다.

그렇다면 우리 일상에서 흔히 발생하는 예를 하나 제시해보자.

20년 동안 아파트를 담보로 대출을 받은 사람이 10년 동안 원금을 상환하지 못하고 대출 이자만 겨우 갚아가고 있는 상태에 있었다. 그러다가 가정을 이루고 세명의 자녀를 두게 되어 불가피하게 더 넓은 아파트로 옮기고자 하여 동생이 형의 대출을 승계하는 조건으로 건물을 인수하고자 하였으나 은행에서는 대출자 본인이 대출원금 자체를 완전히 상환하지 않은 상태에서는 어떤 형태의 재산권 행사도 할 수 없다고 불허했다. 바꾸어 말하면 은행차원에서는 다음 사람에게 대출을 줄 때 또 10년 이자만 받고자 하는 계획을 가지고 있다. 어떻게 보았을 때 담보로 맡긴 토지에 빌라를 지을 수 있느냐 마느냐는 은행이 결정하게 되는 격이 되므로 소유자의 권리를 완전히 막아버리는 것이 된다. 토지가 국가등기에 등록되어 있는가, 토지의 소유자가 누구인가와 상관없이 은행대출을 갚지 않으면 은행은 이 토지를 경매에 부칠 권리가 있다.

헌법재판소의 최후 결론은 장기간 부동산대출 (저당권대출) (hypothec loan) 을 받은 국민은 담보에 있는 아파트나 토지 계약을(법률행위) 할 권리가 생겼고 그러나 이렇게 할 경우 은행에게 통보를 하고 은행의 담보를 매매할 권리가 그대로 있기 때문에 이 계약을 불성사시키지 못한다. 그러나 국회에서 은행의 허가를 통해서만 이 계약(법률행위)이 성사된다는 법을 예전과 같이 제정했음을 언급할 필요가 있다.

마지막으로 결론을 적자면 국가등록기관에서 처음부터 담보의 권리 의무 변동(변경)을 등기했다면 위에 언급한 저당권 8프로 이자 문제와 법원판결이 정치문제가 되지 않았을 것이다.

References

"Admire rule of law" Journal, 2003 Nr.2 /45-53/

"Admire rule of law" Journal, 2001 Nr.2 /41-44/

Civil Code of Mongolia, Paragraph 165.1

www.registrationmongolia.com

www.legalinfo.mn. 2011

Zundui D. Civil Law of Mongolia, Ulaanbaatar, 20018 page 124

Dorjgotov A. "Legal environment and renovation on Pledge of immovable Property" Conference Presentations Brochure, held at the School of Law, NUM. 2010

www.shuukh.mn

State Information Journal, 2002. Nr. 7 Civil Code of Mongolia

State Information Journal, 2009. Nr. 28 Civil Code of Mongolia

www.parl.gov.mn

Jambaldorj O. Civil Law of Mongolia, Second edition, Ulaanbaatar, 2006, page 118

Abstract

According to the provision 171.2 of the Civil Code, before, in case if the citizen-debtor intended to sell or trade or present to others or put in as the concurrent pledge and/or rent or lease or build a construction on the pledged land, the enforceability of the respective agreement would depend on the permission of the bank. There was the practice that the bank took away the original copy of the ownership right certificate of the citizen, who pledged his land or apartment, and restricts the possibility of the citizen to make any kinds of agreements with respect to his property. This has been considered extremely unfair and as the abuse of power. Such a case was reviewed by in the Constitutional Court and the decision with the following content was rendered: Provision 16.14 of the Constitution provides “a citizen has the right to own movable and immovable property...”. Commercial banks hold activity on keeping assets of others and lending them. According to the relevant legislation, banks issue loan with low risk (riskless), and the loan should be with collateral or pledge. The article aims to reveal the need to make amendments to the legislation for the enhancement of the current situation. The current legislation on registration does not provide for the registration of assignment of the right of pledge, both banks and state register require completing the previous loan refusing to register the assignment of the right of pledge. Due to this situation the assignment of the right of pledge is not available in practice. If legislators make precise amendments to the respective legislation on registration and registration procedure, the registration of the right of pledge will be duly done and legal consequences will comply with the theoretical concepts in reality.

Key words: immovable property, pledge, hypothec, registration, inseparable rights

CURRICULUM VITAE



Yanjinkhorloo Dambadarjaa

Education:

National University of Mongolia, Faculty of Law, LL.B (1995)

University of Munich, Germany, LL.M (1998)

Experience:

Lawyer, Golomt Bank, Mongolia (1995-1996)

Internship at the Bundestag, Parliament of Germany (1999)

17) 전통을 보면, 고대 독일법에서 기인하는데 부동산을 이전할 때 법원 아니면 교회에서 입증하는 방법으로 이행되었던 일이 중세시대부터, 도시 거주지역에 부동산의 이전 움직임을 기록할 별도의 책에 기록한 것이 18세기에 이르러 더 잘짜여진, 요구되는 법을 확정하는 것으로 현대에 행정기관을 통해 등기하고, 등기의 별도 요구사항을 두는 것으로 변하여 왔다.

18) Эрнандо дэ Сото “Капиталын нууц” Орч. Д.Энхзаяа, УБ, 2010, 44-р тал Суханов Е.А. О видах сделок в германском и российском гражданском праве . Вестник гражданского права. 2006. N 2. 19면

19) 베.바알락마”부동산, 그 등기” 학부 논문, 울란바토르시 2015년 18면

20) Суханов Е.А. О видах сделок в германском и российском гражданском праве . Вестник гражданского права. 2006. N 2. 19면

정부의 행정시행청 -“부동산 등기소”를 개설하여 소유물 등기 업무 개시 준비를 완료하였고, 이에 1997년 7월 8일부터 부동산권 국가등기가 시행되고 있다.²¹⁾

첫 “부동산 등기법”은 소유주가 법에 명시한 것에 따라 부동산을 국가등기소에 등기함으로써 소유권이 확고해짐을 /3.1조/, 부동산을 타인에게 소유, 점유, 사용하도록 하는 양도 계약은 국가등기소에 등기함으로써 효력이 발생하며, 해당 부동산을 계약에 근거하여 소유, 점유, 사용할 권리가 발생된다./3.2조/고 규정하였다.

법에 규정함으로써 부동산 등기상태는 첫 해에 국가로부터 사유화한 주택의 소유권을 보증 받는 등기가 대부분이었다면, 2000년부터는 경매를 통해 사들인 부동산의 소유권 등기, 자신의 재산으로 건축한 부동산의 소유권 등기 등으로 등기의 수와 종류가 점점 확대되어 왔으나, 오히려 토지와 분리된 등기가 되어져 왔고, 거래하는 당사자들의 계약이 거래에 대한 효력 유무 문제에 대해 등기가 훨씬 더 그 기능을 발휘하고 있음을 알 수 있다. 부동산에는 토지, 토지와 분리되어 사용할 수 없는 것들이 포함됨을 /1994년 민법 77조 77.2항/, 토지, 토지와 분리되면 그 용도로 사용할 수 없는 것들 /2002년 민법 84조 3항/임을 명시하였음에도 토지 로써의 부동산이 부동산성을 유지하고 있음을 간과하고, 토지에서 분리된 부동산이 존재하며 이 모든 기간 동안 존재하게 했다. 재산 소유권과 이와 관련 타 권리를 등기법 13조에 재산 소유권을 등기할 시, 국가관리등기소에 이를 증명하기 위해 첨부할 증빙 서류들:

13.5.1 당사자가 해당 부동산의 소유권을 갖고 있음을 증명할 서류;

13.5.2 토지 소유권을 등기할 시, 해당 토지의 토지대장과 몽골 국민 토지 소유법 제18조 2항에 따라 소유한 토지의 지대를 숨 또는 구의 예산기획부서에 지불한 영수증;

13.5.3 당사자에게 해당 토지를 소유할 권리를 허락 한다는 해당 기관의 결정이 명시된 증명서;

13.5.4 토지 점유, 사용 권리 계약서와 증명서 사본;

13.5.5 건물과 시설의 설계도, 4면에서 촬영한 사진; 등으로 규정하였다.

이 법의 이러한 조항은 부동산인 건물은 토지와 함께 구성됨을 한 편으로는 보여주고 있지만, 여기에는: 1/ 먼저 부동산인 건축, 시설 등기를, 2/ 소유 토지는 단독 등기를, 3/ 등기한 건축 시설이 다른 토지 즉, 국가 소유지에 위치한 경우 당사자는 획득한 점유권을 확증해주는 규정이 보여진다. 이 재산 권리 등기의 최종 단계에서 (Y)라는 부동산 대장번호가 명시된 증명서를 부여하며, 만약 토지를 등기했을 경우는 (Г)라는 토지 대장번호가 명시된 증명서를 부여한다.

21) www.burtgel.gov.mn

한 나라의 등기 시스템에는 해당 국민의 양식이 녹아져 있으며, 경제에 미치는 부동산의 영향을 확장하려는 목적의 네덜란드, 독일, 스페인의 양식과²²⁾ 예 두 가지의 영향이 모두 다 있음을 볼 수 있다. 어떤 예든지 공통점은 부동산과 그 소유권에 관한 정보의 정확도, 실제성, 법익이 보장된 등기를 하는 것과, 등기는 소유권의 변경이라는 결과를 내포하고 있다는 공통점이 있음이 보여진다. 이러한 차이가 있는 등기 시스템은 부동산의 소유권 문제가 등기 업무와 어떻게 연관되는지로 구별된다. 첫째/ 등기는 권리를 창출하는 기능이 있다. 둘째/ 일부 경우에는/ 일부 등기 시스템/ 단지 정보의 역할을 감당한다. 그러나 등기의 정보의 단순한 보관, 전달 기능은 그다지 중요성이 없으므로 등기 과정과 동시에 법적 결과를 내포한다는 점이 중요하다.

우리나라에서, 부동산이라고 인정되는 토지, 그 토지 위에 지어진 건물 시설 문제는 별도의 등기로 되어있어서 법 규정 시 부정적 조건이 되어왔다.

1. 부동산에 대한 이해는 이전에 적용 되어오던 민법에 반영, 규정되어왔으나 실제적인 의미로 적용되어 온 것은 사유화와 연관되면서부터였다. 그러나 국민들이 사유화로 토지는 없는 채 토지와 분리된 재산을 사유화한 것은 부동산을 순환에 참가, 등기, 양도 시에 토지를 고려하지 않고 단지 토지 위의 건축 시설 문제만을 논의해 왔다. 부동산의 성질을 2002년 민법에서 더 분명히 반영하였는데, 첫째로는: 부동산이라는 것에 대해 어떤 이해가 포함되는지, 둘째로는: 부동산으로 인정되는 토지와 그와 분리될 수 없이 연관되어 고정된 또는 그 토지와 분리되는 즉시 경제적 중요성을 상실하게 되는 건축 시설은 토지의 기본 구성요소 재산이 됨을, 또한 이 것으로부터 발생한 해당 구성요소 재산이 단지 법에 별도로 명시 된 경우에만 민사관계에서 독립적인 대상(물건)이 될 수 있음을 명시하였다. 부동산의 통합 형태는 라틴어의 “Solo cedit” /quicquid plantatur solo/ 즉, 토지 위에 존재하는 것들은 그 토지에 귀속된다²³⁾ 라는 원칙에 근거하며, 대부분 국가의 법체계에서 토지 소유권을 “Solo cedit” 원칙에 근거하여 생각한다.
2. 주택, 건축 시설을 사유화했다 하더라도 토지에 관한 문제는 후에, 분명히 말하자면 “몽골국 국민 개인 토지 소유에 관한 법”이 제정되어, 2003년부터 시행되어 왔으며, 이로써 몽골 국민은 토지를 소유할 권리를 가지게 되었고 국민이 토지를 소유하게 됨으로 인해 소유한 토지 위에 부동산을 건축하거나 등기 등을 통해 토지는 부동산이 되어 흐름에 들

22) Ц.Давхарбаяр “Үл хөдлөх эд хөрөнгө, тулгамдаж буй асуудал”, Хууль дээдлэх ёс сэтгүүл, УБ. 2012, №3, 104-р дахь тал

23) Black’s Law Dictionary, 6th edition, 1990, p.70

어오게 되었다. 이 상황으로 인해, 토지와 건축 구조물은 별도의 것이 되었으며, 또한 개별적으로 등기함으로 인해 건축 구조물 부동산, 토지 점유자, 소유자 간의 분쟁이 법정에서 처리되는 상황이 벌어졌고 지금도 적지 않게 발생하고 있다.

첫 부동산 등기법 규정의 내용을 보면, 등기는 주요 기능을 감당한다: 예를 들면, 소유권 이전 법률행위를 등기 함으로써 성립된 계약의 효력이 발생하며, 등기함으로써 소유자가 되는 등 많은 결과가 발생한다.

이 상태를, 물권의 내용으로 결론지어 보면, 우리는 첫 등기법으로 부동산을 등기한다고 규정했다면 이후로 이 근거는 변경되어, 물권 등기에 관해 규정해 주었을 지라도 물권과 채권에 따라 발생한 소유권을 등록/ 2003년 재산 소유권, 이와 관련 기타 권리를 등기하는 등기에 관한 법/ 업무를 국가 등기소에서 시행해 오고 있다. 자세히 말하자면, 2003년에 제정되어 시행되어 오고 있다. ‘재산 소유권, 이와 관련 재산의 기타 권리 (ЭХӨЭТХБЭБ Т)’법에 명시된 것으로는,

1. 재산 소유권, 이와 관련 재산의 기타 권리법 제1조1항, 제4조1항
2. 소유권에 대한 발생, 변경 계약, 법률행위 /재산 소유권, 이와 관련 재산의 기타 권리법 제4조2항, 제19조1항1/ 라는 두 가지 이해의 범주 안에서 등기가 진행되는 것은 한 편으로는, 등기법이 권리를 등기한다고 보는 근거가 있지만 등기소 직원이 국가등기부의 변경을 요청하는 당사자가 구비한 서류를 검토할 때, 권리를 발생, 변경, 종료시키는 계약서가 요구되며, 이를 근거로 하는 현실 즉 다른 한 편으로 법률행위를, 그 중에서도 소유행위를 내포하는 채권 법률행위를 통해 권리가 조성된다고 볼 수 있다.

현재로서는 권리등기소, 그 직원-국가등기원이 등기에 쌍방간에 체결한 계약을, 없는 경우에는 해당 권한기관-판례 유무만을 요구, 조사하게 되었다고 말할 수 있다.

이것을 또한 따라서 기타 법률에, 국민의 주체권이 발생하지 않았고, 법률행위가 성사되지 않은 상태에서, 재산권리등기법 제 19조 1항 2호에 규정한 “해당 권한기관의 결정으로 변경할 수 있다”, 제 20조에 규정한 권리국가등기에 별도의 표시를 하는 것에 대해 규정한 것은 국가 등기활동에 공법상의 제한을 두고 객관적으로 국가가 참여할 기회를 구성했다. 이것을 결론하자면, 위의 상태로 물권을 등기한 곧 변화, 제한은 사법상의 결과를 포함하는 근거가 부정되어 온다. 독일은 공법의 제한을 등기하지 않는다. 우리 등기 활동에는 사법상에서 발생하는 법률 행위 또는 공법상에 발생하는 소유권을 제한하는 모든 행위를 등기하고, 나아가 행정기관에서 등기활동에 영향을 끼치는 상황이 되는 것은 기본원칙을 위반한다고 볼 수 있다.

또한, 등기는 오직 물권으로 한정하지 않고, 물질적재산권 또는 채권으로 발생하는 소유권을

등기하는 것은 물권의 최고의 원칙, 물권을 법으로 규정해야 한다는 원칙(numerus clausus) 또는 소유권을 민법 제 101조 1항에 규정한 “소유자는 다른 사람들과 법과 계약으로 부여된 권리를 침해하지 않고, 법으로 정한 제한선 내에서 소유의 물건을 자의로 자유롭게 점유, 사용, 활용할 권리가 있다”라고 규정한 조항은 기본적으로 내용면에서 적용될 상황을 잃었다고 결론 내릴 수 있다.

VI. 결론

이와 같은 상황에 근거하여, 부동산을 다음과 같이 정의 할 수 있다.

1. 자연적 특징(불가침)에 따라 - 토지 (예를 들면 기업 및 개인이 점유, 소유하며 특정한 선을 구분으로 하여 점유자, 사용자, 소유자는 동일한 단위영역(파르셀)에 해당하는 등기번호를 가진 땅)
2. 토지와와의 관련성에 따라 - 토지의 기본적인 구성요소인 건물 등의 공작물²⁴⁾, 자본의 종합물
3. 법에 따라 부동산에 해당하는 것 - 철도, 선박/재산 소유권, 이와 관련 재산의 기타 권리 (ЭХӨЭГХБЭБт) 법 제3조1항/²⁵⁾

부동산에 토지, 이와 정착된 자본뿐만 아니라 토지에서 정착되지 않은 것들이 해당된다고 볼 수 있지만 법의 저촉될 때에 토지와 함께 규율되고 등기할 때에도 토지와 관련된 권리에 따라 등기해야 하는 것을 유념하여야 한다.

이러한 사유화의 결과로 부동산을 갖게 되었으나 부동산에 대한 고전적 정의에서 벗어나, 토지에서 분리하여 재산을 등기하며, 나아가 등기의 법적 영향이 사(私)법범위에 까지 적용되고, 각 법에 결과를 발생시킬 때까지 공법의 영향은 특정 정도까지 등기에 영향을 끼칠 기회가 조성된 것은 사법의 평등권의 “Solo cedit” 통합할 권리의 근간을 잃었다고 결론내릴수 있다. 그

24) 토지상에 있는 건물구조를 관여하지 않고 토지를 담보로 정할 수 있는 권리는 토지 사유자, 소유자에게만 있다. 이것은토지와 따로 구분하는 형태로 부동산 민간거래에 참여 할 수 있다는 것을 나타냅니다. ..작가

이것에 대해 판례를 기초하여 결론지었다. 예를 들어: 몽골은 1997년도부터 재산을 등록하기 시작하였지만 토지와 다른종류의 재산권의 등록을 따로따로 하도록 되어 있는 것은 토지사유자, 소유자와 위의 부동산 소유자 사이에 분쟁이 생길 요인이 된다. /폐.체체계, “부동산등기법률을 향상에 관한 문제” 몽골 국가법논총. 제4호, 올란바타르, 2013, 6번/ 라고 말한 것은 건축구조를 토지와 따로 구분하는 형태로 소유할 수 있다는 것을 보여주고 있다.

25) 자본의 종합물이란 공장과 같이 물질적-소유 및 점유의 토지, 건물, 설비, 생산재-, 비물질적-채권, 주식, 허가, 감찰 등 많은 소유권의 총체이기 때문에 자본의 종합물이라고 한다. 이것이 부동산이 되는 근거는 토지에 있다. 그러나 자본의 종합물 전부 존재해야 채무를 이행할 수 있기 때문에 현행법으로는 토지의 기본적인 구성요소로 본다.

러나, 유목문명에서 정착문명의 형태, 법문화, 인식이 성숙하게 자리잡는 기간을 단축하여, 자신의 것이라 할 수 있는 법을 만드는 길에서 몽골사람들이 잘못을 고치고, 수정하여 왔다. 이와 같이 부동산 관련 규정도 변화되어 신법의 법안이 만들어지고 개정으로 이끌 “부드러운 바람”이 불고있다는 것을 믿어 의심치 않는다.

참고문헌

- 베. 보양히식, “민법입문”, 올란바타르, 2012
- 배. 치메드, “헌법주의”, 올란바타르, 2012
- 페. 아가르에르덴, “사법의 물권 이론”, 올란바타르, 2009
- 데. 강호약, “부동산의 경제 및 평가”, 올란바타르, 2005
- “부동산의 법적 일부 문제점”, 국제학술회의 자료집, 올란바타르, 2010
- “토지 경영 법”, 국제학술회의 자료집, 올란바타르, 2005
- 제. 다브하르바야르, “부동산 쟁점”, Law Review. 제3호, 올란바타르, 2012
- 제. 다브하르바야르, “소유권의 토지 및 민법의 규정의 방향”, Law Review. 제4호, 올란바타르, 2013
- 페. 어츨리발, “부동산등기의 목적, 기능 및 등기제도”, 몽골 국가법논총. 제2호, 올란바타르, 2011
- 제. 어용통글락, “비교 민법”, 올란바타르, 2013 . 70-71 면
- 페. 체체게, “부동산등기법률을 향상에 관한 문제” 몽골 국가법논총. 제4호, 올란바타르, 2013
- 베. 바알락마, “부동산, 그 등기”, 학부 논문, 올란바타르, 2015년
- Marina Vaskovich “Real property processes: An explorative study of property institutions in Belarus”, Doctoral Thesis in Real Estate Planning, Stockholm, Sweden 2012
- Суханов Е.А. О видах сделок в германском и российском гражданском праве . Вестник гражданского права. 2006. N 2. 19 면
- 테. 쎅게터르쥬, 이스. 앙흐멘드 “환경법, 토지법” 올란바타르, 2015년
- Гражданское уложение Германии. Кн. 1. М.: Волтерс Клувер, 2004.
- Постатейный комментарий к Федеральному закону «О государственной регистрации прав на недвижимое имущество и сделок с ним», Спарк, Москва, 2001 г, С.43
- “몽골민법전/역사 편집/ 1926-2012년”, 올란바타르, 2012

Abstract

사유화의 결과로 부동산을 갖게 되었으나 부동산에 대한 고전적 정의에서 벗어나, 토지에서 분리하여 재산을 등기하며, 나아가 등기의 법적 영향이 사(私)법범위에 까지 적용되고, 각 법에 결과를 발생시킬 때까지 공법의 영향은 특정 정도까지 등기에 영향을 끼칠 기회가 조성된 것은 사법의 평등권의 “Solo cedit” 통합할 권리의 근간을 잃었다고 결론내릴수 있다. 그러나, 유목문명에서 정착문명의 형태, 법문화, 인식이 성숙하게 자리잡는 기간을 단축하여, 자신의 것이라 할 수 있는 법을 만드는 길에서 몽골사람들이 잘못을 고치고, 수정하여 왔다. 이와 같이 부동산 관련 규정도 변화되어 신법의 법안이 만들어지고 개정으로 이끌 “부드러운 바람”이 불고있다는 것을 믿어 의심치 않는다.

Abstract

The real property have been become the main object of the legal relation and it used as material and nonmaterial legal relations but there are many problems related with real property and many cases have been decided in courts. For instance only the buildings regarded as a real property, or after becoming ownership of the real property arises problem on location, or real property and land became separately a collateral, in cases of non-performance of contract the real property transfers to another person then that person wants to have the land which real property locates. There is need of to study what exactly means the real property, how Mongolians privatized the real property, how goes the registration. It is silent that real property considers inseparable part of land, whether real property is separate part of land from the theoretical aspect in Mongolia.

This article will examine the legal regulation of the real property, which form after privatization and it will be compared with other countries legal regulation.

Key words: privatization, pink ticket end blue ticket, property, land ownership, property rights

CURRICULUM VITAE

Personal information



First name: DAVKHARBAYAR

Last name: Tseveensuren

Education

1988 School of Law, NUM

1999 M.A at Law, School of Law, NUM

Profession Lecturer, Attorney at Law

Experience

Judge, First Instance Court, Khentii Aimag;

Specialist for Legal Policy, Legal Policy Department, Ministry of Justice;

Head for Legal Department, “Bileg” Law Institute.

Present position

Senior Lecturer at Private Law Department, School of Law

National University of Mongolia

Research works

- Textbooks and Handbooks
 - Social Welfare Law /Textbook/ , 2010
 - Contract Law-1 /Team publication, handbook/ 2006

- Contract Law-2 /Team publication, handbook/2006
- Citizens' Legal Guide /Students handbook & Teachers handbook /, 2007
- Legal Guide /Handbook/
- Children's' Right: Children's Protection /Team publication, textbook/, 2011
- Social Welfare Law Syllabus, Handbook /Team publication/, 2013
- "Your Legal Guide" /Manual for Citizens/, 2012
- "Immovable Property Issues" /Handbook/, 2013

- Articles
 - "Contractual Law Issues", "Rule of Law" journal, 2007
 - "Immovable Property Issues", "Rule of Law" journal, 2012
 - "Withdrawal from a Contract", "State Law" journal, 2006
 - "Consequences of Invalidity of Contract", "Rule of Law" journal, 2009, No.2
 - "Possession and Consequences", "Advocate" journal, 2010, No.4
 - "Legitimate Rights Protection", "Advocate" journal, 2011, No.3
 - "Immovable Property Issues", ", "Rule of Law" journal, 2012
 - "Neighboring Rights Regulations & Points ", "Rule of Law" journal, 2015
 - "Judgment opinions on Possession", "Law" journal, 2015
 - "Issues on Transfer of Immovable Property Ownership Basing on Transactions", "Law" journal, 2015
 - "Public and Private Law Relationship Impacting to Material Rights", "Brochure of Articles for 55 year Anniversary of School of Law"
 - "Nature of Ownership", Workshop, Private Law Department, 2015

Өмч хувьчлал: Өмчийн харилцаанд оруулсан өөрчлөлт шинэчлэл, үр дагавар

МУИС-ийн ХЗС Хувийн эрх
зүйн тэнхмийн багш Ц.Давхарбаяр

Түлхүүр үг: өмч хувьчлал, ягаан болон цэнхэр тасалбар, үл хөдлөх хөрөнгө, газар өмчлөл, хөрөнгийн эрхийн бүртгэл

Товч агуулга: Үл хөдлөх хөрөнгө эрх зүйн харилцааны объект болж, иргэний эрх зүйн болон эдийн засгийн гүйлгээнд чөлөөтэй хэрэглэх болсон боловч үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой маргаан цөөнгүй гарч, шүүхээр шийдвэрлэгдэж байна. Үүнийг харвал, зөвхөн барилга байгууламжыг үл хөдлөх хөрөнгө гэж үзсэн байх, эсвэл барилгын өмчлөгчөөр тогтоолгосны дараа тухайн үл хөдлөх хөрөнгө оршин байгаа газрын талаар маргах, мөн барилга байгууламж болон газраа тус тусад нь барьцааны зүйл болгох, үндсэн үүргээ биелүүлээгүйн улмаас барилгын өмчлөл бусдад шилжихэд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан этгээд газраа дараа нь шаардах, хамтад шилжүүлэх ёстой гэж үзэх зэргээр газар, түүний дээрх барилга байгууламжтай холбоотой маргаан олон байдлаар /хувилбараар/ гарч байна. Үүний үндэс нь үл хөдлөх хөрөнгө гэж юуг үзэх вэ, монголчууд хувьчлалаар үл хөдлөх хөрөнгийг хэрхэн хувьчлан авсан бэ, улмаар бүртгэл яаж явагдаж байгааг судлахгүйгээр дээрх маргааныг шийдвэрлэхэд ч хүндрэлтэй ба онолын хувьд газрын бүрдэл байж үл хөдлөх хөрөнгө гэж үзэх үү, эсвэл газраас салангид байдлаар үзэх үү гэдэг нь тодорхойгүй байгаа нь харагдана Иймээс хувьчлалын үр дүнд бий болсон үл хөдлөх хөрөнгө, түүний эрх зүйн зохицуулалтыг бусад улс орны зохицуулалттай харьцуулан судлаж дүгнэлт өгөхийг зорилго болголоо.

Abstract: *The real property have been become the main object of the legal relation and it used as material and nonmaterial legal relations but there are many problems related with real property and many cases have been decided in courts. For instance only the buildings regarded as a real property, or after becoming ownership of the real property arises problem on location, or real*

property and land became separately a collateral, in cases of non-performance of contract the real property transfers to another person then that person wants to have the land which real property locates. There is need of to study what exactly means the real property, how Mongolians privatized the real property, how goes the registration. It is silent that real property considers inseparable part of land, whether real property is separate part of land from the theoretical aspect in Mongolia.

This article will examine the legal regulation of the real property, which form after privatization and it will be compared with other countries legal regulation.

Удиртгал:

Шүүхэд нэгэн үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой маргаан шийдвэрлэгджээ. Үйлдвэрийн зориулалттай үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч байсан нэхэмжлэгч үйлдвэрийн зориулалттай барилга, тоног төхөөрөмж болон үйлдвэрийн барилгад хамаарах газар нь бүрдэл хөрөнгө болохыг тогтоолгох шаардлага гаргасан бол тухайн үйлдвэрийн газрыг одоогоор эзэмшин үйл ажиллагаа явуулж байгаа хариуцагч нь тоног төхөөрөмж болон газрын эзэмшигч болохоо тогтоолгох /учир нь нэхэмжлэгч үйлдвэрийн барилгын өмчлөгч болохоо өмнө хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр тогтоолгон, улсын бүртгэлээс өмчлөгч гэсэн гэрчилгээ авсантай холбоотой бусад хөрөнгийн өмчлөгч, эзэмшигч болохыг шаардсан болов уу/, улмаар өөрийнх эзэмшлийн газар дээр байгаа нэхэмжлэгчийн үйлдвэрийн барилгыг буулган газраа чөлөөлүүлэх сөрөг шаардлага бүхий маргаан гарсан байдаг. Өнөөгийн байдлаар үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой шүүхээр шийдвэрлэгдэж байгаа маргаан төдийгүй иргэний эрх зүйд, холбогдох хуулиудын зохицуулалт ч энэ талаарх асуудлыг бүрэн шийдвэрлэсэн гэж үзэх боломжгүй болох нь харагддаг.

Энэхүү маргаанаас үүдэн үл хөдлөх хөрөнгийн ойлголт, түүний талаарх зохицуулалтаас

1. Газрын дээр байгаа барилга байгууламж газрын хамтаар үл хөдлөх хөрөнгөнд тооцогдож чадаж байна уу
2. Эсвэл газар, мөн дээрх барилга байгууламж нь тус тусдаа өмчлөлийн зүйл болж, тэдгээр бие даасан субъектив эрхтэй этгээдүүд өөрийн үзэмжээр эрхээ хэрэгжүүлж байна уу
3. Мөн газар өмчлөгч эрхээ хэрэгжүүлэхдээ, газрын дээрх барилгын буулгахаар шаардах уу, харин easement гэж нэрийдэх “газрын өмчлөгчид “хувьд нь давуу байдал” (personal advantage)¹⁾ олгох бус) ноёрхогч, газар өмчлөгчийн эрх оршин байгаа гэдэг утгаар нь

ямар нэг ашигтай зүйл бий болгох” ёстой гэсэн нийтлэг ойлголт буюу “газар өмчлөгч хувь этгээдэд нь ашигтай” (benefit the landowner personally)²⁾ байх үүднээс газрыг эзэмших, өмчлөхтэй холбоотой дагалт /газартайгаа дагалдуулах/ үүрэг газрын дээрх объектын эзэнд ногдуулах уу

гэсэн асуудал хөндөгдөн гарч судлаач миний сонирхлыг татсан болно.

Үл хөдлөх хөрөнгийн талаар авч үзэхдээ, бусад улс оронтой нэгэн жишгээр үл хөдлөх хөрөнгийг газартай холбон авч үзэх нь зайлшгүй байгаа тохиолдолд холбогдох эрх зүйн зохицуулалт, онол-практикийг хөндөн авч үзэхээс гадна социалист тоталитар тогтолцоос ардчилсан, зах зээлийн эдийн засагт нийгмийг сонгон шилжсэн үйл явцад нь хувийн өмч хөрөнгө, түүнээс монголчууд үл хөдлөх хөрөнгөтэй болсон түүхийг сөхөн үзэх, түүнтэй холбоотой холбогдох хуулийн зохицуулалтыг ч судлах шаардлагыг бий болгосон юм. Иймд өгүүллээ

1. Улсын өмчийг хувьчлах үеийн онцлог
2. Үл хөдлөх хөрөнгийн зохицуулалт
3. Газар, газар өмчлөлийн асуудал
4. улсын бүртгэл, түүний зохицуулалт гэсэн бүлэг, дэд хэсгүүдэд ангилан бичсэн болно.

Эдгээр бүтцээр, хэрхэн улсын өмч хувьчлах үйл ажиллагаа явагдан, хувийн өмчгүй байсан, хувьдаа үл хөдлөх хөрөнгөгүй байсан иргэд өмч хөрөнгөтэй болсон процесс болон хувийн өмч- үл хөдлөх хөрөнгөө анхны бүртгэлийн хуулийн дагуу бүртгүүлэхэд гарсан асуудал, энэ нь эрх зүйн догм онолтой нийцэж байгааг дүгнэлт өгөхийг зорьлоо. Улмаар үл хөдлөх хөрөнгийн үндэс болох газар, түүнийг өмчлүүлсэн байдал нь “газар, газраас салгамагц шинж чанараа алддаг” үл хөдлөх хөрөнгийн хамгийн гол шинж болох чанарыг хангах боломжийг бүрдүүлж чадаж эсэхийг, мөн одоогоор улсын бүртгэлд үл хөдлөх хөрөнгийг бүртгэх онцлогийг хөндсэн нь эрх зүйн тогтолцоо төдийгүй МУ-ын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Иргэний хууль, Газрын тухай хууль, Эд хөрөнгийн өмчлөх эрх ба

1) Sir Robert Megarry, Sir William Wade & Charles Harpum, The Law of Real Property (6th ed. 2000), §18-045.

2) Peter Sparkes, A New Land Law (1999), 574

түүнтэй холбоотой бусад эрхийн бүртгэлийн тухай хуулийн зохицуулалт хоорондоо нийцэж байгаа эсэхийг судлан дүгнэх зорилгыг тавьсан болно.

I.

Хувьчлал: Улсын, хоршооллын, амины өмчөөс бүрдэх боловч дийлэнх хэсгийг нь улсын өмч бүрдүүлж байсан 1990 оны эхлэлд МУ зах зээлийн чөлөөт эдийн засгийг сонгосноор улсын өмчийг хувьчлах нэг гол үндэс болсон юм. Өмч хувьчлал нь нийгэм, эдийн засаг төдийгүй эдийн засгийн олон секторт өөрчлөлт, давуу байдал, эсрэгээрээ сөрөг үр дагавар ч авчрах эрсдэл ихтэй ихээхэн төвөгтэй асуудал байдаг. Уг үр дагаврыг өмчийн эрх зүйн чиг хандлага талаас нь тодорхойлбол:

1. Үндсэн хөрөнгийн дахин хуваарилалт байдаг тул нийгмийн орлогын байдалд өөрчлөлт оруулна.
2. Өмчлөгч этгээд өөрчлөгдсөнөөр өмчийн үүрэг зориулалт өөрчлөгдөхийн хэрээр өмчлөгчийн хүлээх хариуцлага ч өөрчлөгдөж болно.

Эдийн засгийн шинэчлэлийн “цочроох эмчилгээ” нь богино хугацаанд хуучныг шинэ тогтолцоонд шилжүүлэхэд чиглэж байсан ба Монгол улсын нийт өмчийн 75 хувийг эзэмшиж байсан төр 1991 оны 5 сарын 31-ээс өмнө төрсөн бүх иргэдэд улсын жижиг, хоршооллын хөрөнгийг худалдаж авах эрхийг олгосон ягаан тасалбар³⁾ -аар бага хувьчлалд оролцох боломжийг олгосон бол 1991 оны 10 сараас 1992 оны 7 сарын хооронд цэнхэр тасалбараар⁴⁾ /ваучер/ их хувьчлалд оролцох эрхийг⁵⁾ олгожээ.

3) Ягаан тасалбар нь худалдаа, үйлчилгээ, бусад салбарын жижиг үйлдвэрийн газар /50-ш доош хүн ажилладаг/, томоохон үйлдвэрийг газрын үйлдвэрлэлийн нэгжийн бие даасан салбар, нэгжийн эд хөрөнгийн хувьчлалд оролцохыг /бага хувьчлалд оролцох эрх/ гэрчлэх эрх. Энэ нь нэг нь 1000 төгрөгтэй тэнцэх 3 ширхэг тасалбар байв. Энэхүү тасалбар буюу эрх нь хөдлөх хөрөнгийг хувьчлан авах төдийгүй мөн өмнө явуулж байсан үйл ажиллагаа – худалдаа, үйлчилгээ зэргийг өөрсдийн байгуулсан хоршоо, нөхөрлөл зэрэг хувийн хэвшлийн хуулийн этгээдээрээ дамжуулан үргэлжлүүлэн явуулах боломжийг бүрдүүлсэн байна.

4) Цэнхэр тасалбар гэдэг нь 7000 төгрөгөөр үнэлэгдэх нэг эрхийн бичиг байх ба үүгээр улсын том үйлдвэрийн хувьцааг худалдан авах зориулалттай, бусдад худалдахгүй, харин өөрөө биечлэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд төлөөллөөр дамжуулах эрхтэй.

5) Тасалбар, ваучерыг тараах, хөрөнгө оруулалтын сан, эсвэл хувьцаат компанийн хувьцааг хуваарилах нь хувьчлал явуулах хэлбэр байж болох юм. Чех, Словак, Румын, Польш, Орост энэ загварын хувилбарыг

ХААН-ийн хувьчлал: Үүний зэрэгцээ мал, ХААН-н нэгдэл, орон сууцыг хувьчлах үйл ажиллагаа явагдсан. Хязгаарлагдмал тооны цөөн малтай, илүүг нь нийгэмчлэн зохион байгуулалтын нэгж болох нэгдэл байгуулан хөдөлмөр хөрөнгөө нэгтгэх байдлаар ажиллаж байсан бол 1992 онд хөдөө аж ахуйн нэгдлийг /хөрөнгийг/ хувьчлал явагдан, анх нэгдэл, хоршоолол байгуулагдах үед хөрөнгөө нийгэмчлэсэн иргэд, мөн хувьчлах үед ажиллаж байсан иргэд хувьчлалд оролцсоноор нэгдэлд ажиллаагүй боловч мал хувьчлан авах боломжийг бүрдүүлсэн нь малыг зөвхөн малчдад хувьчлах боломж хязгаарлагдан, сөрөг үр дүн гарсан байдаг.

Орон сууцны хувьчлал: Улсын, хоршооны, аж ахуйн газрын өмч байсан орон сууцыг 1996 онд УИХ-аас хувьчлах эрх зүйн баримт бичгийг батлан гаргаж^{б)}, 1997 оны 5 сараас эхлэн оршин суугчдад нь үнэгүй хувьчлах үйл ажиллагаа явагджээ. Ингэснээр дийлэнх төв суурин газрын иргэд өөрийн гэх орон сууцтай, мөн их бага хувьчлалаас өмнө улсын байсан хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг хувьчлан авснаар хувийн өмч, хувь этгээдийн үл хөдлөх хөрөнгө үүсэн бий болсон байна. Үүний дараа, 1997 онд Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн тухай хууль батлагджээ.

Энэхүү хувьчлалыг дүгнэвэл, нийт өмчийн 75 хувийг эзэмшиж байсан төрийн стратегийн ач холбогдол бүхий хөрөнгийг улсын мэдлээс хувийн секторт шилжүүлсэн нь плюрализмыг дэмжигч либерал зах зээлийн эдийг засгийг төлөвшүүлэх эхлэл суурийг тавьсан бөгөөд МУ-ын Үндсэн хуулийн “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэсэн заалт өөрийн үндсэн утгаар хэрэгжих нөхцөл бүрдэж, улмаар бусад шинэ хуулиуд батлагдан гарах, хуучин мөрдөж байсан хуульд өөрчлөлт орох нөхцөл бүрдсэн болно.

ашигласан ба гэнэтийн хувьчлал явуулан, удирдах албан тушаалын хүмүүс аж ахуйгаа хувьчлан авсан байдаг. Орос зэрэг оронд үйлдвэр, аж ахуйн газрууд өөрсдөө хувьчлалыг санаачлан, мэдээллийг зөвхөн өөрсдийн хүрээнд давуу эрхтэйгээр хүртэж байсан нь гэнэтийн хувьчлал явагдах нөхцлийг бүрдүүлсэн гэж Лавигне Марие “Шилжилтийн үеийн эдийн засаг: Социализмаас зах зээлийн эдийн засагт” бүтээлдээ дурьдсан байдаг. Үүнтэй нэг ижилээр, монголд явагдсан хувьчлал ч мэдээлэл муутай, нээлттэй, өрсөлдөөнтэй байх нөхцлийг бүрдүүлж чадаагүй гэж хэлж болно...зохиогчоос

б) 1996 онд Орон сууц хувьчлах тухай хууль батлагдсан

II.

Үл хөдлөх хөрөнгө: Хувийн өмч, тэр тусмаа хувийн өмчийн үл хөдлөх хөрөнгө хувьчлалаар бий болж, суурь нь тавигдсанаар, эрх зүйн шинжлэх ухаанд томъёоллын төдийгүй зохицуулалтын талаарх асуудал тулгарсан байна.

Монголчууд үл хөдлөх хөрөнгө гэж юуг үзэж байсан түүхийг эргэн харъя.

Дээр дурьдсанаар, Улсын Бага хурал 1991 онд өмч хувьчлах тухай хууль гаргаж, нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг зөвшөөрч, зах зээлийн эдийн засагт шилжихтэй холбогдсон бусад суурь хуулиудыг гаргаж мөрдүүлсэн нь иргэний эдийн засгийн эрхийг тал бүрээр хангах анхны алхам болсон юм. Ингэж Монгол Улсын иргэд хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр ижил гарааны зарчмаар хувийн өмчтэй болох эхлэл тавигдсан түүхтэй болно⁷⁾. Хувьчлалын дүнд, өөрийн гэх орон сууц, мал ахуйтай болсоноор үл хөдлөх хөрөнгө гэдэг ойлголтыг бид эхлээд, орон сууц, барилга, байгууламж гэж хүлээн авч, бүртгэлийн байгууллага үл хөдлөх хөрөнгө гэж үзэж буй барилгыг, цаашилбал, орон сууцаа худалдах, бэлэглэх зэргээр захиран зарцуулж нэгээс нөгөөд шилжүүлэх төдийгүй бусдад түрээслэх барьцаалах зэрэг өмчлөх эрхийн эзэмших, ашиглах эрхийн хүрээнд хэрэгжүүлж байгаа бүхий л үйл явц, хийгдэж байгаа гэрээ, хэлцлийг ч бүртгэж ирсэн байна. Энэ үеийн үл хөдлөх хөрөнгө гэдэг нь газраас салангид байгаа орон сууц, барилга болох нь харагдана.

Анхны, Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн хуульд /1997 он/ Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа төрийн болон орон нутгийн нийтийн зориулалттай өмчид хамаарахаас бусад газар, газраас салгамагц зориулалт, эдийн засгийн агуулгаа алдах барилга байгууламж, хөлөг онгоц, тарьц суулгац, олон наст ургамал зэрэг бодит болон хийсвэр аргаар хэмжиж болохуйц, тодорхой хил хязгаартай эд хөрөнгийг улсын бүртгэлд бүртгэхээр заасан. Тухайн хуулийн агуулгаар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгөөс бусдыг бүртгэх, хэдийгээр хуульд газар үл хөдлөх хөрөнгийг тодорхойлогч ойлголт байхаар тусгагдсан ч газрын хамтаар барилга байгууламжаа бүртгээгүй байна.

Дээрхээс дүгнэвэл, газраас үл хөдлөх хөрөнгө салангид байх нь газрийн өмчлөл хэнд хамаарагдаж байгаа, өмчлөгч хэн байхтай холбоотой. Газрын бүрдэл хэсэг түүний салшгүй

7) <https://burtgel.gov.mn/>

хэсэг гэж тооцдог superficies solo cedit зарчмыг нийтлэг байдлаар дийлэнх улс орон хүлээн зөвшөөрдөг хэдий ч зарим улсад хуулиараа газар болон түүний дээрх объектын өмчлөлийн асуудлыг тусдаа байхаар зохицуулсан байдаг нь дээрх зарчмаас гажих нөхцлийг бүрдүүлдэг бол Европын эрх зүйн системд “in rem” барилгын түрээс /building lease/⁸⁾ гэх хязгаарлагдмал эрхээр газар өмчлөгчөөс тусдаа газрын дээрх болох дорх барилга байгууламжыг өмчлөх боломжийг олгодог хэлбэрийг бий болгож, мөн дээрх зарчмыг “дүрмээс гадуур” хэрэглэх нөхцөл бүрдүүлсэн байдаг байна. Манай улсын хувьд газар төрийн өмч байгаа нөхцөлд иргэний хувийн өмчлөлийн барилга, байгууламжийг газраас тусад нь бүртгэх шаардлага бий болсон⁹⁾ учраас нэгдмэл бус салангид байдлаар бүртгэх бүртгэл бий болсон юм. Үүний шалтгаан хувьчлал, бүртгэл зэрэг ойлголтыг анх бий болгохдоо системтэй, эрх зүйн зохицуулалтын үндэслэл, нөхцлийг бүрдүүлж чадаагүйтэй холбоотой.

Гэхдээ, үл хөдлөх эд хөрөнгө гэдэгт газар, түүнээс салган хэрэглэж үл болох зүйл хамаарахыг /1994 оны Иргэний хууль, 77-р зүйлийн 77.2/, газар, түүнээс салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох эд юмс /2002 оны Иргэний хууль, 84-р зүйлийн 3/ хамаарна гэж газаргүйгээр үл хөдлөх хөрөнгө гэсэн ойлголт байж болохгүйгээр тусгасан нь нэгд, үл хөдлөх хөрөнгөд тооцогдох газар, түүнтэй салшгүй холбоотой бэхлэгдсэн, түүнээс салгамагц эдийн засгийн ач холбогдлоо алдаж байдаг барилга, байгууламж нь газрын үндсэн бүрдэл хөрөнгө болохыг /ИХ-ийн 85.2/ зохицуулсанаараа газар байж үл хөдлөх хөрөнгө болохыг тогтоосон бол хоёрт/ тухайн бүрдэл хөрөнгө зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд л иргэний эрх зүйн харилцааны бие даасан объект болохыг /Их-ийн 85.1/ тусгаснаар материаллаг буюу хувийн эрх зүйн суурь хууль болох Иргэний хуульдаа газраас салангид байж болохыг хүлээн зөвшөөрч болох мэт ойлголт оруулсан онолын хувьд эргэлзээ бий болгоод¹⁰⁾ байгаа болно.

8) Н.Баярмаа “Газарба газартай холбоотой хязгаарлагдмал эрхүүд” Шүүх эрх мэдэл сэтгүүл., 2015 он. №2, 14 дахь тал

9) Ж.Оюунтунгалаг “Үл хөдлөх эд хөрөнгөд хамаарах газрын эрх”, Нийтийн болон хувийн өмчийн эрх зүйн тулгамдсан асуудал, УБ, 2012 он. 82-р тал

10) Хуулийн зүйл заалт, томъёоллыг бий болгоход зайлшгүй баримтлавал зохих нэгэн бичигдээгүй дүрмийн дагуу төсөл боловсруулагч эхэн хэсэгт үндсэн дүрмийг тогтоон, түүнээс хойшхи хэсэгт үндсэн дүрмээс гажих тусгай тохиолдлуудыг дурддаг. Энэ үүднээс хөрсөнд бэхлэгдсэн зүйл хөрсөндөө үлдэх үндсэн /solo cedit/ зарчмыг Иргэний хуульд суулгахдаа, тус дүрмээс гажсан онцгой зохицуулалтын дараа буюу хоёрдугаарт нь тусгасан нь төдийлөн зөв алхам байсангүй гэж судлаач Н.Баярмаа дурьдсан байдаг. Тиймээс ч дээрх дурьдсан, Иргэний хуулийн 85-р зүйлийн зохицуулалт газар нь үл хөдлөх хөрөнгөө тодорхойлогч гэж үзэх боломжийг үгүйсгэх шалтгаан болдог юм.

Харин, эх газрын тогтолцоотой улс орнууд, тэр дундаа Германы иргэний хуульд, эд юмс хэмээх ойлголтыг хуульчлахдаа материаллаг зүйл “**Sachen im Sinne des Gesetzes sind nur körperliche Gegenstände**” /Германы ИХ 90-р зүйл/ болох талаас нь тодорхойлж, улмаар үл хөдлөх хөрөнгийг газартай /эдэлбэр газар/ холбон, түүнээс хамааралтай бусад эрх үүсч болохыг /ГИХ 96-р зүйл/, өөрөөр хэлбэл газарт холбогдох бүрдэл хөрөнгийг зохицуулалтыг бий болгосон байдаг.¹¹⁾

Гэтэл бидний хувьд эхлээд орон сууц, барилгыг хувийн өмчлөлийн зүйл болгохдоо газрын хамтад хувьчлаагүй учраас үл хөдлөх хөрөнгийг хөдөлшгүй байх шинжийг ч алдагдуулан гэж болохоор зөвхөн газрын дээр орших барилга, байгууламжаа үл хөдлөх хөрөнгөнд тооцож байсан байна. Энэ байдалд эрх зүйн сэтгэлгээ ч нөлөөлсөн байх үндэстэй. Монголчуудын хувьд өмчлөх эрхийн үзэл, сэтгэлгээ монгол үндэстэн бүрэлдэж, монгол төр ёсон тогтсон тэр цагаас азийн үйлдвэрлэлийн аргын нөлөө, нүүдлийн соёл иргэншлийн онцлог, нүүдлийн мал аж ахуй, технологи, түүнийг нөхцөлдүүлсэн байгалийн хүчин зүйл, өмчлөгчгүй нийгэмд тогтдог төрийн дэглэм зэргийн нөлөөгөөр хувийн өмчийн үзэл сэтгэлгээ хэрэг дээрээ төдөвшөөгүй шахам¹²⁾ байсан гэж судлаач дүгнэсэн байдаг юм. Одоогийн үйлчилж байгаа иргэний хуульд газар байж үл хөдлөх хөрөнгө гэсэн ойлголт байхаар тусгагдсан хэдий ч газрыг хэрхэн өмчлөсөн, өмчлөх газраа иргэний гүйлгээнд оруулж байгаа байдал, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг бүртгэж байгаа байдал зэргийг судлахгүйгээр энэ асуудалд бүрэн хариулт өгөх боломжгүй юм. Иймд эдгээр ойлголтыг авч үзье.

III.

Газар: Үл хөдлөх хөрөнгийн үндэс нь газартай салшгүй холбоотой. Европын улс орнуудын эд юмсын эрх хэмээх ойлголтын цөм нь газар байсаар ирсэн нь нэгдүгээрт: өмч хөрөнгийн гол үндэс гэж үзэх, хоёрдугаарт: улмаар хөдлөшгүй учраас үл хөдлөх хөрөнгө гэж үзэх хандлага бий болсон байдаг. Тухайлбал: Германы иргэний эрх зүйд газрыг /тодорхой

11) А.В. Томсинова. Понятия вещи и права собственности ИКД «Зерцало-М» 2012 г., 361

12) Н.Лүндэндорж “Монголсуудын өмчлөх эрхийн үзэл сэтгэлгээний уламжлал, шинэчлэл” Шихихутуг сэтгүүл, 2004 он, №1, 62 дахь тал

хэмжээс бүхий газрыг/ үл хөдлөх хөрөнгө гэж үзнэ.

Манай улсын хувьд, нүүдлийн мал аж ахуй эрхэлж ирсэн нь газрыг бэлчээрийн хэлбэрээр ашиглах, түүний эдийн засгийн талаас нь бус харин газар нутаг нь ард түмэн, хүмүүстэйгээ эрх мэдэл бүхий этгээдэд хамрагдаж, захирагдаж байх гэсэн утгаар газар эзэмшлийн зүйл болж байсан¹³⁾ учраас өмчлөлийн зүйл болсон нь хожуу юм.

Суурьшмал болон нүүдлийн ахуй аль нь ч байсан газар эд юмсын харилцааны үндэс, өмчлөлийн зүйлийн суурь болж ирсэн нь “улс орны эдийн засаг, үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын чадварийг нэмэгдүүлж, иргэдийн амьжиргааны түвшинг сайжруулах”¹⁴⁾-д гол түлхэц болдог учраас газартай байж улс үндэстэн, соёл иргэншил оршин тогтнож, мөн хэн нэг этгээдийн гэх өмч хөрөнгө ч бий болно.

Газар өмчлөлийн зүйл болохдоо өөрийн гэсэн онцлогийг илэрхийлж байдаг. Энэ нь:

- Газар нь зориулалттай байх, зориулалтаас шалтгаалан, өмчлөгчийн хэрэгжүүлэх эрх хэмжээ тогтоогдох
- Байгалийн үнэт зүйл учраас өмчлөхэрхээ хэрэгжүүлэхэд байгаль орчинд сөрөг үр дагавар үзүүлэхгүй байх үүрэг дагалддаг болно.

Иймд: нэгдүгээрт, газар өмчлөлийн объект болохын тулд зориулалттай байх ба МУ-ын Газрын тухай хуулийн 5-р зүйлийн 5.1-д “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар төрийн өмч” болох ба 5-р зүйлийн 5.2-д зааснаар “бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно” гэж заасан байдаг.

Хоёрдугаарт, газар нь онцгой объект учраас өмчлөгч эрх үүргээ хэрэгжүүлэхдээ байгаль орчинд сөрөг үр нөлөө үзүүлэхгүй байх үүднээс газрын төлөв байдал, чанарыг дордуулахгүй байх, өмчийнхөө газрыг ашиглах явцад барилгын, экологийн, ариун цэврийн, эрүүл ахуйн, галын аюулгүй байдлын болон бусад холбогдох стандарт, дүрэм, журам, шаардлагыг сахиж мөрдөх, өмчийн газрынхаа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг өөрийн зардлаар 5 жил тутамд эрх бүхий байгууллагаар хийлгүүлж байх, газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч бусад этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хохироох,

13) Ц.Давхарбаяр “Өмчлөлийн зүйл болох газар- иргэний эрх зүйн зохицуулалтын хандлага” Эрх зүй сэтгүүл 2013 он, №4., 22-р тал

14) Ш.Батсүх. Монгол улс дахь газар өмчлөлийн явц байдал, цаашдын чиг хандлага. Газар, удирдлага, эрх зүй/Эрдэмшинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл/. УБ., 2005.6 дахь тал

өмчийн газар дээрээ хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөх аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх зэрэг үүрэг хүлээдэг байна.

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль батлагдсан нь монголчууд анх удаа эрх зүйн хэм хэмжээгээр баталгаажсан, а/ гэр бүлийн хэрэгцээ болон б/ аж ахуйн зориулалтаар газар өмчлөх субъектив эрхтэй болсон юм. Энэхүү эрх хэрэгжиж эхлэхдээ гэр бүлийн хэрэгцээний газрыг¹⁵⁾ өмчлүүлэх ажлаар эхэлсэн энэ нь ч хараахан дуусаагүй байгаа учраас аж ахуйн зориулалтаар газар өмчлүүлээгүй байгаа билээ.

Хувийн өмчийн газартай болсон хэдий ч гэр бүлийн хэрэгцээний – хашааны зориулалттай байсан нь орон сууц, улсын жижиг болон томоохон үйлдвэрийг хувьчлан авсан хүмүүсийн хувьд газар өмчлөлийн асуудал шийдвэрлэгдсэн гэж үзэх боломжгүй юм. Хувийн өмчийн газраа шинээр барилга байшин барьснаар газрын хамтаар барилгаа өмчлөх эрх үүсч байгаа бол төрийн барилгыг өмчилж авсан газрын өмчлөх эрх төрдөө оршин байсаар байгаа гэж хэлж болно.

Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд /1999 онд батлагдсан/ "эдлэн газар" гэж Газрын тухай хуулийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд эзэмшүүлэх, ашиглуулах зорилгоор олгосон газрыг; "нэгж талбар" (парсель) гэж хилээр хязгаарлагдсан, ашиглалтын зориулалт адил, эзэмшигч, ашиглагч, өмчлөгч нь нэг, оноосон дугаартай, кадастрт тусгавал зохих эдлэн газар, объект буюу түүний хэсгийг хэлэх талаар заасан нь өмчлөгч этгээдийн мэдлийн эдлэн газар, ялангуяа үл хөдлөх хөрөнгийн байрлах /орших/ газар бусдаас ялгагдах тусгаарлагдсан орон зай гэдгийг /тодорхой хэмжээсээр тогтоож, нэгж талбарын дугаар олгосон байх ойлголт гэж үзэх үндэслэл бүхий байна/ тус хуулиар зохицуулсан. Иргэнд газар өмчлүүлэх хууль гарч хэрэгжсэнээр хамгийн түрүүнд, хот суурин газруудад амьдарч байгаа иргэд эхлэн гэр бүлийн хэрэгцээний, нэг ижил хэмжээгээр баталгаажсан газраа өмчилж авчээ. Газраа өмчлөсөнөөр, газрын бүртгэл хэрхэн хийгдсэн бол.

15) Иргэдэд газар өмчлүүлэхэд олон асуудал тулгаран гарч байсныг Монгол улсын иргэдэд газар өмчлүүлэх тухай хуулиар шийдвэрлэсэн. Энэ талаар доктор О.Амархүү бичихдээ "газар өмчлөлд хийсэн шинэчлэлийн нэг чухал тал нь өмчлүүлэх газрын байршлыг сонгоход онцгой анхаарал тавьж хуульчилсан. Газар өмчлөн авах иргэний оршин суугаа засаг захиргааны харьяаллыг уг иргэний " газар" хэмээх өмчөө байршуулах нутаг дэвсгэрийг сонгон авах эрхтэй хутган ойлгож болохгүй" гэсэн байдаг /О.Амархүү "Монгол улсад газар өмчлөх эрхийн уламжлал, шинэчлэлийн асуудал" Шихихутуг сэтгүүл., 2005 он. №2/. Өмчлөх газраа сонгох доо оршин суугаа газраа төдийгүй өөр нутаг дэвсгэрт ч сонгох боломжийг олгосон нь өмчлөх газрын дээр байгаа үл хөдлөх хөрөнгөө даган өмчлөх газраа сонгох, мөн ирээдүйд ашиглах, зориулалтаа ч харгалзан өмчлөх газраа сонгох боломжийг уг хууль бүрдүүлсэн юм.

Төрийн данс бүртгэлийн нэг хэлбэрээр газар зохион байгуулалтын хүрээнд хийгдэх бүртгэл бол газрын төлөв байдал, тоо чанар, эзэмшил ашиглалт, хамгаалалт хуваарилалт зэргийг харуулах газрын нэгдмэл сангийн бүртгэл¹⁶⁾ байдаг. Ийнхүү газрын мэдээлэл бүртгэлийн санд, үүнд: эзэмшиж байгаа, өмчлөлийн, түүнчлэн ашиглах эрх бүхий газрын бүртгэл хийгдэж байгаа ч газрын бүртгэлийг газрын алба хариуцах, хөрөнгийн эрхийн бүртгэлд зөвхөн хөрөнгө – нөгөө л барилга, байгууламж л бүртгэгдэх үндэс болж байгаа нь харагдана. Газрыг өмчлөж байгаа ч энэ нь засаг захиргааны байгууллагын эрхлэх ажил үүрэгт хамаарагдаж, үүнийгээ даган бүртгэл нь ч тухайн захиргаанд байгаа нь үл хөдлөх хөрөнгийг тодорхойлогч нь газар байх ойлголт төлөвшиж тогтнохгүй байгаа нэг шалтгаан гэж үзэх үндэс байж мэдэх юм.

IV.

Бүртгэл: Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн нэгдсэн систем бий болох процесс урт удаа хугацаанд үргэлжилсэн байдаг¹⁷⁾. Жишээлбэл: Герман Улсад өмчийн албан ёсны бүртгэл XII дугаар зуунд эхэлсэн¹⁸⁾ боловч 1896 онд Газрын хэлэлцээрийг бүртгэх албан ёсны тогтолцоо бий болжээ. Япон Улсад фермерүүдийн өмчийг албан ёсны болгох үндэсний компанит ажил XIX зууны сүүлээр эхэлж, 1940 оны эцсээр дуусжээ.¹⁹⁾ Эртний Ромын эрх зүйгээс үүдэн, эх газрын эрх зүйд уламжлагдан ирсэн эд юмсын эрхийн суурь нь газар, тухайн этгээдийн эзэмшилд байгаа, өмчлөж байгаа газар байсан бөгөөд газраас улбаалан бусад эрхүүд үүсэх, улмаар эд хөрөнгийг бүртгэхдээ ч газрыг нь бүртгэх зохицуулалт үүсчээ.

Иргэний эрх зүйн харилцаанд хөрөнгийн бүртгэл /улсын бүртгэлийн эрх/ бие даасан

16) Т.Сэнгэдорж, С.Энхмэнд, С.Энхсаруул “Экологийн эрх зүй, газрын эрх зүй” УБ, 2015 он 308 дахь тал

17) Уламжлалыг авч үзвэл, эртний Германы эрх зүйгээс улбаатай үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэхдээ шүүх, эсвэл сүмд баталгаажуулах байдлаар хийгддэг байсан ажиллагаа дундад зууны үеэс, хот суурин газарт үл хөдлөх эд хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг тэмдэглэл тусгай номд бүртгэгдэж байсан нь 18-р зуунаас илүү боловсронгуй болох, шаардагдах хуулиудыг батлах зэргээр өнөөгийн үед нийтийн захиргааны байгууллагаар дамжин бүртгэгдэх, бүртгэлийн тусгай шаардлага тавих зэргээр өөрчлөгдөн хөгжиж иржээ. / Ц.Давхарбаяр “Үл хөдлөх эд хөрөнгө, тулгамдаж буй асуудал”, Хууль дээдлэх ёс сэтгүүл, УБ, 2012, №2, 105-р тал/

18) Эрнандо дэ Сото “Капиталын нууц” Орч. Д.Энхзаяа, УБ, 2010, 44-р тал

19) Б.Баялагмаа “Үл хөдлөх хөрөнгө, түүний бүртгэл” бакалаврын дипломын ажил, УБ, 2015 он, 18 дахь тал

институт болох нь эрх зүйн хөгжлийн өнөөгийн шатанд эргэлзээгүй ба харин ингэж бие даасан институт болохын тулд иргэний эрх зүйн хууль тогтоомжийн хүрээнд тухайн улс үндэстний онцлог, нийгэм эдийн засаг, түүхэн хөгжлийн онцлогт тулгуурлан үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрх шилжих болон түүний бүртгэлтэй холбогдсон хууль тогтоомж бүрдэж бий болсон байдаг²⁰⁾. Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 42 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – “Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар”-ыг байгуулж эд хөрөнгийн бүртгэлийн үйл ажиллагаа эхлэх бэлтгэл ажил хангагдсаны үндсэн дээр 1997 оны 7 дугаар сарын 8-нд анхны үл хөдлөх хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хийгдсэн байна.²¹⁾

Анхны “Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн тухай хууль” нь өмчлөгч хуульд заасны дагуу **үл хөдлөх эд хөрөнгөө улсын бүртгэлд бүртгүүлснээр түүний өмчлөх эрх баталгаажихыг /3.1-дэх заалт/, үл хөдлөх эд хөрөнгийг бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад шилжүүлэх гэрээ нь улсын бүртгэлд бүртгэгдсэнээр хүчин төгөлдөр болж тухайн үл хөдлөх эд хөрөнгийг гэрээний үндсэн дээр өмчлөх, эзэмших, ашиглах эрх үүсдэг /3.2 дахь заалт/ талаар зааж зохицуулсан байна. Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн анхны хуулийн зохицуулалтын агуулгаас харвал, бүртгэлийн үүрэг эрх зүйн ач холбогдол бүхий болох нь: тухайлбал өмчлөх эрх шилжүүлэх хэлцлийг бүртгүүлснээр гэрээ хүчин төгөлдөр болох, бүртгүүлснээр өмчлөгч болох зэрэг олон үр дагавар үүсч байгаагаар тодорхойлогдож байна.**

Хуульд зааснаар үл хөдлөх хөрөнгөө бүртгүүлэх байдал нь эхний жилүүдэд төрөөс хувьчилсан орон сууцны өмчлөх эрхийг баталгаажуулах бүртгэл зонхилж байсан бол 2000 оноос дуудлага худалдаагаар худалдан авсан үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн бүртгэл, өөрийн хөрөнгөөр барьж бий болгосон үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн бүртгэл зэргээр бүртгэлийн тоо, төрөл улам өргөн хүрээтэй болж ирсэн хэдий ч газраас салангид бүртгэл хийгдэж байсан ба харин хэлцэл хийгч талуудын гэрээ хэлцэл хүчинтэй эсэх асуудалд л бүртгэл илүүтэй үүрэг гүйцэтгэж байсан нь харагдана. Энэ байдал хуулийн зохицуулалтаас тодорхой харагддаг. Эд хөрөнгийн өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийг бүртгэх хуулийн 13-р зүйлд эд хөрөнгийн өмчлөх эрхийг бүртгүүлэхдээ

20) Суханов Е.А. О видах сделок в германском и российском гражданском праве . Вестник гражданского права. 2006. N 2. 19 дэх тал

21) www.burtgel.gov.mn

эрхийн улсын бүртгэлийн байгууллагад мэдүүлэг гаргах ба мэдүүлэгтээ хавсаргах баримт бичигт:

13.5.1. тухайн этгээд уг үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхтэйг нотолсон баримт бичиг;

13.5.2. газар өмчлөх эрхийг бүртгүүлэхэд тухайн газрын кадастрын зураг болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 18.2-т заасны дагуу өмчилж авсан газрын үнийг сум, дүүргийн төсөвт төлсөн тухай баримт;

13.5.3. тухайн газрыг уг этгээдэд өмчлүүлсэн тухай эрх бүхий байгууллагын шийдвэр болон түүнээс олгосон гэрчилгээ;

13.5.4. газар эзэмших, ашиглах эрхийн гэрээ болон гэрчилгээний хуулбар;

13.5.5. барилга байгууламжийн план зураг, дөрвөн талаас нь бүтэн харуулсан гэрэл зураг; гэх зэргээр заасан байна.

Уг хуулийн эдгээр заалт нь үл хөдлөх хөрөнгө болох барилгыг бүртгэхдээ тус хөрөнгө оршин байгаа газрын мэдээлэл байхыг харуулж байгаа ба энэ нь: 1/ эхэлж үл хөдлөх хөрөнгө болох барилга байгууламжаа бүртгэхийг, 2/ өмчлөлийн газраа дангаар бүртгүүлэхийг, 3/бүртгүүлж байгаа барилга байгууламж нь бусдын газар дээр буюу төрийн өмчийн газар байгаа нөхцөлд тухайн этгээд эзэмших эрх олж авсан эсэх мэдээлэл бүртгэлийн санд байхыг тусгажээ. Уг хөрөнгийн эрхийн бүртгэлийн эцэст (Ү) буюу үл хөдлөх хөрөнгийн гэсэн дугаар бүхий гэрчилгээ олгогдох ба харин өмчлөлийн газар бүртгэгдсэн бол (Г) буюу газрын дугаар бүхий гэрчилгээ олгогдож байгаа нь газар, барилга байгууламж тусдаа бүртгэгддэгийн илрэл болно.

Манай улсын бүртгэлийн системд тухайн үндэстний хэв маягийг шингээсэн, эдийн засагт үл хөдлөх хөрөнгийн үзүүлэх нөлөөг баталгаажуулах зорилго бүхий Голланд, Герман, Испанийн хэв загварын²²⁾ аль алиных нь нөлөө байгаа гэж үзэж болохоор байна. Аль ч загвар байсан нийтлэг байгаа зүйл нь үл хөдлөх хөрөнгө болон түүний өмчлөгчийн талаарх мэдээллийг үнэн зөв, бодитой, түүний хууль ёсны эрх ашгийг хамгаалсан бүртгэлийг хийх, бүртгэл нь өмчлөх эрхэд өөрчлөлт оруулах үр дагавар агуулах зэрэг нийтлэг шинжтэй байгаа харагддаг. Эдгээр ялгамжтай бүртгэлийн систем үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн асуудал бүртгэлийн үйл ажиллагаатай хэрхэн уялдаж байгаагаараа ялгагддаг. Нэгд/ бүртгэл

22) Ц.Давхарбаяр “Үл хөдлөх хөрөнгө-тулгамдаж байгаа асуудал” Хууль дээдлэх ёс сэтгүүл. 2012 он., №3 104 дахь тал

эрх бүтээх шинж чанартай байдаг бол хоёрт/ зарим тохиолдолд /зарим бүртгэлийн систем/ зөвхөн мэдээллийн үүрэг гүйцэтгэнэ. Гэхдээ бүртгэл зөвхөн мэдээллийг хадгалах, түгээх шинжтэй байх нь төдийлөн ач холбогдолгүй учраас бүртгэх үйл явцтай зэрэгцэн эрх зүйн үр дагавар агуулсан байх нь чухал.

Манайд, үл хөдлөх хөрөнгө гэж үзэж буй газар, түүнд сууриласан барилга байгууламжийн асуудал салангид бүртгэлтэй байх эрх зүйн үндэс нь дээр авч үзсэн хувьчлал, газар өмчлөлийн асуудал зэрэгтэй холбогдох нь гарцаагүй ба үүнийг товчоор дүгнэвэл:

1. Үл хөдлөх хөрөнгийн ойлголт өмнө үйлчилж байсан Иргэний хуульд тусгагдан зохицуулагдаж байсан боловч бодит утгаар хэрэгжсэн нь хувьчлалтай холбогдон гарч ирсэн. Гэхдээ хувьчлалаар иргэд газаргүйгээр, түүнээс салангид хөрөнгө хувьчлан авсан нь үл хөдлөх хөрөнгөө эргэлтэнд оруулах, бүртгүүлэх, бусдад шилжүүлэх зэрэгт газрыг тооцохгүйгээр зөвхөн газрын дээрх барилга байгууламжын асуудал л яригдаж байв. Үл хөдлөх эд хөрөнгийн нэгдмэл хэлбэр нь латины “Solo cedit” /quicquid plantatur solo/ буюу газар дээр оршин байгаа зүйлс газарт харьяалагдах²³⁾ зарчимд үндэслэдэг, манай улс үүнийг хуулиараа хүлээн зөвшөөрсөн боловч газраас тусдаа дээрх хөрөнгийг бүртгэлд бүртгэдэг.
2. Орон сууц, барилга байгууламжаа хувьчласан хэдий ч газрын тухай асуудал нь хожим, тодруулбал “Монгол улс иргэнд газар өмчлүүлэх тухай хууль” батлагдан, 2003 оноос хэрэгжсэнээр Монгол улсын иргэд газар өмчлөх эрхтэй болсон бөгөөд иргэд газар өмчлөх улмаар өмчлөлийн газартаа үл хөдлөх хөрөнгө барих, бүртгүүлэх зэргээр газар үл хөдлөх хөрөнгө болж хөдөлгөөнд орсон байдаг. Энэ байдлаас болж, газар ба барилга байгууламж нь тусдаа байх, бүртгэлд ч тус тусдаа бүртгэгдэх, үүнээс барилга байгууламж болох үл хөдлөх хөрөнгө, газрын эзэмшигч, өмчлөгч нарын хоорондын маргаан шүүхээр шийдвэрлэгдэх байдал байсаар байгаа ба одоог ч хүртэл тасраагүй байна.

Бүртгэл нь зөвхөн эд юмсын эрх гэж хязгаарлаагүй, эдийн баялгийн эрх төдийгүй үүргийн эрхийн аль алинаар үүсч байгаа өмчлөх эрхийг бүртгэдэг нь эд юмсын эрхийн туйлын байх зарчим, эд юмсын эрхийг хуулиар бүтээх зарчим /numerus clausus/ болон

23) Black's Law Dictionary, 6th edition, 1990, p.70

өмчлөх эрхийг ИХ-ийн 101-р зүйлийн 101.1-д зааснаар “Өмчлөгч нь бусад этгээдэд хууль буюу гэрээгээр олгогдсон эрхийг зөрчихгүйгээр, хуулиар тогтоосон хэмжээ, хязгаарын дотор өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах ...эрхтэй” гэж заасан заалт үндсэн агуулгаараа хэрэгжих нөхцөл алдагдсан гэж дүгнэх үндэстэй байна.

Иймд бид үүнийг засч залруулах, өөрөөр хэлбэл үл хөдлөх хөрөнгө гэдэгт газрын мэдээллийн санд орсон нэгж талбарын дугаар бүхий газар байж түүнийгээ бүртгэх, үүнтэй цуг газартай бэхлэгдсэн барилга байгууламжаа бүртгэдэг байх нь зүйд нийцнэ

Дүгнэлт: Эдгээр нөхцөл байдалд үндэслэн, үл хөдлөх хөрөнгийг дараахь байдлаар томъёолон үзэж болохуйц байна. Үүнд:

Гадаадын хөрөнгө оруулалтын үр дүнд хөрөнгө оруулалтыг хүлээн авагч улсад хөрөнгө, шинэ техник технологи, нөү хау болон боловсрол, зэргийг олж авах боломжийг олгож байдаг. Тийм ч учраас хөгжиж буй орнуудын эдийн засагт гадаадын хөрөнгө оруулалт нь дэлхийн эдийн засагт хөл тавих нэг томоохон боломж юм. Монгол улсын хувьд томоохон бүтээн байгуулалт, тухайлбал онгоцны буудал, цахилгаан станц, зам гүүрийн байгууламж, харилцаа холбооны салбар, ашигт малтмал эрдсийг хайх олборлох, боловсруулах зэрэг олон салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлогыг баримталж ирсэн бөгөөд сүүлийн 3 жил эрх зүйн зохицуулалтын тогтворгүй байдлаас улбаалан гадаадын хөрөнгө оруулалт их хэмжээгээр буурсан үзүүлэлт харагдаж байна. Тухайлбал, 1990 оноос хойш 2013 оныг хүртэл Монгол Улсад дэлхийн 112 оны 12118 аж ахуйн нэгж бүртгэгдэж, нийт 14 тэрбум орчим ам.долларын өртөг бүхий гадаадын хөрөнгө оруулалт хийгдээд байна.¹⁾ Энэхүү хөрөнгө оруулалтын дийлэнх хэсэг нь буюу 74 хувь нь геологи, уул уурхайн салбарт хийгдсэн нь дан ганц уул уурхайн салбараас шууд хамаарал бүхий эдийн засгийн бүтцийг бий болгож, бусад салбарын тухайд өрсөлдөх чадвар нь сулрах, тэдгээр салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэхгүй байх, салбарын хөгжил саарах зэрэг сөрөг үр дагаварууд ажиглагдаж эхэлсэн. 2012 оны 5 сарын 17-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай” хуулийг баталсан үеэс эхлэн хөрөнгө оруулалтын хэмжээ багасах хандлага тодорхой ажиглагдаж эхэлсэн. Судалгаанаас харахад 2013 оны эхний хагас жилд орж ирсэн гадаадын хөрөнгө оруулалт нь өмнөх оныхтой харьцуулахад 42 хувиар буурсан

1) http://investmongolia.gov.mn/?page_id=881

үзүүлэлттэй байв. Иймээс гадаадын хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн тогтвортой бөгөөд, алсын хараатай зохицуулалт шаардагдах болсон юм.

Дээрхээс гадна, хөрөнгө оруулагч болон хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн өмчлөх эрхийн асуудал, өмчлөх эрхийн хязгаарлалт, өмчийг шууд ба шууд бусаар хураан авахтай холбогдсон эрх зүйн зохицуулалтын асуудал судлаачдын анхаарлыг ихээхэн татаж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд Монгол Улсын Засгийн газарт хамаарах хэд хэдэн маргаан олон улсын томоохон арбитраг хэлэлцэж шийдвэрлэгдсэн²⁾ нь энэхүү асуудал улам ч чухлаар тавигдаж буйн илрэл юм.

1. Хөрөнгө оруулалтын тухай Монгол Улсын хууль

1990 онд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжин орсны дараахан, 1993 онд Монгол Улс анх Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг батлан мөрдөж эхэлсэн. Гадаадын хөрөнгө оруулалтыг идэвхитэй татахын тулд тус хуулийн дагуу аль салбарт хөрөнгө оруулж буйгаас хамааран тодорхой хугацаанд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт олгох бодлогыг баримталж байсан бөгөөд 2013 оныг хүртэл 20 жилийн хугацаанд энэхүү хуулиар хөрөнгө оруулалтад холбогдох бүхий л харилцааг зохицуулж байв. Харин 2012-2013 оны хугацаанд Хөрөнгө оруулалтад холбогдох хууль тогтоомж хэд хэдэн удаа, богино хугацаанд өөрчлөгдөж байсан³⁾ нь гадаадын шууд хөрөнгө оруулалт буурах⁴⁾ нэг гол шалтгаан болсон.

Гадаадын хөрөнгө оруулалтад хамаарах асуудлыг бүрэн зохицуулсан, түүнчлэн хөрөнгө оруулалтын эрх зүйн тогтвортой нөхцлийг бий болгох зорилгоор “Хөрөнгө оруулалтын тухай” хуулийн төслийг боловсруулан Монгол Улсын Их Хурлаар 2013 оны 10 сарын 3-ны

2) <http://www.italaw.com/sites/default/files/case-documents/ita0622.pdf>, <http://www.italaw.com/cases/604>

3) Монгол Улсын Их Хурал нь 2012 оны 05 сарын 17-нд “Стратегийн ач холбогдол бүхий салбарт аугаахуйн үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдэд гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай” хуулийг батлан гаргасан бөгөөд энэхүү хуулийн гол зорилго нь гадаадын төрийн сонирхлыг стратегийн ач холбогдол бүхий салбарт хязгаарлах явдал байв. Гэвч дан ганц төрийн бус, хувийн хэвшлийн хуулийн этгээдийн хөрөнгө оруулалт хийхэд ч тодорхой хязгаарлалт тавьсан ба энэхүү алдааг мөн оныхоо 12 сард дахин залруулж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг чөлөөтэй, хязгааргүй болгон нэмэлт өөрчлөлт оруулсан. 2013 оны 10 сард “Хөрөнгө оруулалтын тухай” хуулийг шинээр баталснаар өмнөх хуулиуд бүгд хүчингүй болж, шинээр батлагдсан хууль хүчин төгөлдөр үйлчлэх болсон ч үндсэндээ нэг жил хагасын дотор 4 удаа хуульд өөрчлөлт орсон нь эрх зүйн зохицуулалтын ихээхэн тогтворгүй байдлыг илэрхийлж байв.

4) http://investmongolia.gov.mn/?page_id=881

өдөр баталсан ба өдгөө энэхүү хууль хүчин төгөлдөр үйлчилж байна. Энэхүү хууль нь өмнө үйлчилж байсан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль болон “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай” хуулийн⁵⁾ зарим зохицуулалтыг нэгтгэсэн, гадаадын хөрөнгө оруулагчаас гадна бизнесийн үйл ажиллагаа эрхлэх асуудлыг зохицуулах зорилготой юм.

2. Эрх зүйн бусад эх сурвалж

1993 онд УИХ-аас батлан гаргасан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль өдгөө хүчин төгөлдөр үйлчилж байгаа болно. Гадаадын хөрөнгө оруулалтын бүртгэх, зөвшөөрөл олгох, гадаадын хөрөнгө оруулагчийн эрх үүрэг, энэ талаар төрийн байгууллагын эдлэх эрх, хүлээх үүрэг зэргийг бүхэлд нь энэ хуулиар зохицуулсан гэж хэлж болно. Энэ хуулиас гадна, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Компанийн тухай зэрэг хуулиуд гадаадын хөрөнгө оруулалттай холбогдон үүсэх эрх зүйн харилцаанд үйлчилнэ.

3. Хөрөнгө оруулалтын ангилал, хэлбэр

Хөрөнгө оруулалт гэдгийг тус хуульд “Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг” хэлнэ хэмээн тодорхойлсон байна.

Хөрөнгө оруулагчийн ангилал болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үндсэн тодорхойлолтын хувьд өмнөх Гадаадын хөрөнгө оруулалтын тухай⁶⁾ хуулиас төдийлөн өөрчлөгдөөгүй.

Хөрөнгө оруулалт хийх хэлбэрийг дараахь байдлаар 6 ангилж тусгасан:

- Хөрөнгө оруулагч дангаараа болон бусад хөрөнгө оруулагчтай хамтран аж ахуйн нэгж байгуулах
- хөрөнгө оруулагч хувьцаа, өрийн бичиг, бусад төрлийн үнэт цаасыг худалдан авах
- компанийг нэгтгэх, нийлүүлэх замаар хөрөнгө оруулалт хийх

5) 2012.05 сарын 17-нд батлагдсан энэ хууль нь 2013 оны 10 сарын 03-наас эхлэн хүчингүй болсон.

6) Анхны “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай” хууль нь 1993 оны 5 сарын 10-нд батлагдан 20 жилийн хугацаанд харьцангуй тогтвортой үйлчилж байсан ба 2013.10.03-ны өдөр хүчингүй болсон юм.

- концесс, бүтээгдэхүүн хуваах, маркетинг, менежментийн болон бусад гэрээ байгуулах
- санхүүгийн түрээсийн болон франчайзийн хэлбэрийн хөрөнгө оруулалт хий
- хуулиар хориглоогүй бусад хөрөнгө оруулалтын хэлбэр

Эдгээрээс Монгол Улсад хамгийн түгээмэл хэрэглэгддэг хэлбэр нь хөрөнгө оруулагч дангаараа болон хамтарсан компани байгуулах, дотоодын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн үнэт цаас, хувьцааг худалдан авах замаар хөрөнгө оруулах, концесс болон бүтээгдэхүүн хуваах, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах явдал юм.

4. Хөрөнгө оруулалттай хуулийн этгээд байгуулах журам, онцлог

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байхыг шаарддаг. Гадаадын хөрөнгө оруулагчийн оруулах хөрөнгийн доод хязгаар нь 100 000 ам.доллартай тэнцэх⁷⁾ ба, нэг аж ахуйн нэгжид 2 гадаадын хөрөнгө оруулагч хөрөнгө оруулах тохиолдолд тус бүр 100 мянган ам.долларын хөрөнгө оруулсан байх шаардлагатай /3,1,5/. Гэхдээ энэхүү зохицуулалт нь нэг талаас хөрөнгө оруулагчийн оруулах хөрөнгийн босго хэмжээг тогтоож байгаа ч нөгөө талаас гадаадын хөрөнгө оруулагчтай хамтран ажиллахаар зорьж буй дотоодын хөрөнгө оруулагчийг бас багагүй хөрөнгөтэй байхыг шаардсан нь харагдаж байгаа юм. Энэ нь нэг талаас дотоодын хөрөнгө оруулагчийг гадаадын хөрөнгө оруулагчтай хамтран ажиллаж хуулийн этгээд байгуулах боломжийг нэлээд хязгаарлаж байгаа нь практикт харагдаж байна. Ялангуяа өөрийн нэр дээр төдийлөн үнэлэгдэх хөрөнгө буюу үнэлж болохуйц тусгай зөвшөөрөлгүй дотоодын компанийн хувьд энэхүү шалгуур нь ихээхэн хүнд тусаж байна.

Тухайлбал, Улаанбаатар хотод бүртгэлтэй У ХХкомпанийн хувьцааны 50 хувийг Канадын К компани худалдан авах замаар хөрөнгө оруулахыг хүсчээ. Хөрөнгө оруулалтын тухай

7) 1993 онд батлагдсан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиар хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн дүрмийн сангийн босго хэмжээг 10 000 ам.доллар байхаар тогтоож өгсөн бөгөөд 10 гаруй жилийн хугацаанд энэхүү журам үйлчилж байсан. Гэхдээ дүрмийн сангийг босго хэмжээ доогуур байснаас үүдэн хэт олон хуулийн этгээд бүртгэгдэж, эдгээрийн нэлээд хэсэг нь үр дүнгүй, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахуйц үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулахгүй байснаас үүдэн 200.. оноос эхлэн 100 000 ам.долларын босго хэмжээг хуульд нэмэлт өөрчлөлт оруулан мөрдөж байсан ба энэ нь шинээр батлагдсан Хөрөнгө оруулалтын тухай хуульд хэвээр тусгагдсан болно.

хуулийн 3,1,5-д заасны дагуу К компани нь 100,000 ам.долларын хөрөнгийг дор хаяж оруулах ёстой ба хувьцааны 50 хувийг эзэмшигчийн оруулсан хөрөнгө 100 мянган ам доллар бол У компани ч мөн адил 100 мянган ам долларыг оруулах үүрэгтэй болно. Гэтэл дотоодын хөрөнгө оруулагчид тэр бүр их хэмжээний мөнгийг дүрмийн сандаа байршуулах хөрөнгийн чадавхигүй байх нь түгээмэл бөгөөд үүнээс үүдэн дотоодын олон компани гадаадын хөрөнгө оруулалтыг татаж чадахгүйд хүрч байгаа юм.

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь аль улсын иргэн, хуулийн этгээд хөрөнгө оруулснаас үл хамааран улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөсөө эхлэн монголын аж ахуйн нэгж хэмээн тооцогддог бөгөөд тухайн хуулийн этгээд нь Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлж үйл ажиллагаагаа явуулах үүрэгтэй болно.

5. Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн үйл ажиллагаа болон өмчлөх эрхийн хязгаарлалт

Гадаадын хөрөнгө оруулалт нь хууль тогтоомжид заасан бүхий л хяналтад байх бөгөөд түүнийг МУ-ын нутаг дэвсгэр дээр хураан авахыг хориглодог /ХОТХ 6.3, 6.4/. Түүнчлэн бусад улсын засгийн газартай байгуулсан “Гадаадын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай” хоёр талт хэлэлцээрүүдэд ч хөрөнгө оруулалтыг хамгаалах тухай заалтууд тусгагдсан байдаг.

Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хувьд үйл ажиллагааны болон өмчлөх эрхийн хязгаарлалтыг л авч үзэж болно.

а/ Үйл ажиллагааны хувьд тавих хязгаарлалт. Монгол улсад хуулиар хориглосноос бусад бүх төрлийн үйл ажиллагааг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж эрхлэх боломжтой. Харин зарим төрлийн үйл ажиллагааг эрхлэхэд хуульд заасны дагуу тусгай зөвшөөрлийг авах ёстой байдаг. Чухам ямар төрлийн үйл ажиллагаа явуулахад тусгай зөвшөөрөл авах шаардлагатай байдаг талаар Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд нарийвчлан зааж өгсөн болно.

Дараах төрлийн үйл ажиллагааг явуулахыг хуулиар хориглосон. Үүнд:

- Хар тамхи, хуульд өөрөөр заагаагүй бол мансууруулах бодис үйлдвэрлэх, импортлох, худалдах,

- Садар самуун явдлыг зохион байгуулах, түүнийг аливаа хэлбэрээр сурталчлах, дэмжих,
- Казиногийн үйл ажиллагаа эрхлэх,
- Олон шатлалт маркетинг буюу пирамид тогтолцооны замаар хууран мэхэлж ашиг хонжоо олох үйл ажиллагаа.

Эдгээр үйл ажиллагаа нь гагцхүү хөрөнгө оруулалттай хуулийн этгээдэд ч бус, дотоодын бүхий л аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд хамаарах зохицуулалт бөгөөд эрхлэх үйл ажиллагааны хувьд үндэсний дэглэм үйлчилдэг.

б/ Өмчлөх эрхийн хязгаарлалт

Хэдийгээр гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд нь байгуулагдсан үеэсээ эхлэн Монгол Улсын хуулийн этгээд хэмээн тооцогдох ч өмчлөх эрхийн хувьд хуульд заасан дараахь хязгаарлалт үйлчилдэг.

1/ Газар өмчлөх эрхийн хязгаарлалт. Монгол Улсын Үндсэн хууль, Газрын тухай хуульд заасны дагуу гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь газрыг өмчлөх, эзэмших эрхгүй бөгөөд гагцхүү тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашиглах эрх олж авах боломжтой тухай зохицуулалт тусгагдсан байдаг. Харин шинээр батлагдсан Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12.1.1 дүгээр зүйлд хөрөнгө оруулалтад үзүүлэх дэмжлэгийн нэг нь газар эзэмших эрхийг олгох тухай заасан бөгөөд хугацааны хувьд 60-100 жил байхаар зохицуулжээ.

Хөрөнгө оруулагч ба хөрөнгө оруулалттай хуулийн этгээд нь газраас бусад барилга байшин, орон сууц зэрэг бүх төрлийн эд хөрөнгийг өмчлөх эрхтэй. Барилга байшин, орон сууцны хувьд хэдийгээр газартай салшгүй холбогдсон эд хөрөнгө боловч, барилга, орон сууцыг өмчлөх эрх олж авснаар тэдгээрийн доорхи газрыг өмчлөх эрх давхар үүсдэггүй бөгөөд үл хөдлөх эд хөрөнгө болох байшин барилга, газрын өмчлөх эрх нь тусдаа тодорхойлогдоно. Дотоодын аж ахуйн нэгжийн хувьд барилга байшин өмчлөх эрх олж авснаар тодорхой тохиолдолд газар эзэмших эрх үүсэж болох бол гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид ийм эрх үүсэхгүй юм.

2/ Ашигт малтмалын салбарт компанийн хувьцаа эзэмших эрхийн хязгаарлалт. Ашигт малтмалын салбар, цөмийн энергийн салбарт тодорхой тохиолдолд компанийн хувьцаа эзэмших эрхийг хязгаарласан байдаг. Тухайлбал, улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашиглавал төрийн оролцооны хэмжээ нь 50 хүртэл

хувьтай байж болох бөгөөд энэ хэмжээг нь төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг нь харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлох юм /АМТХ 5.3/.

Харин тухайн орд газар нь стратегийн ач холбогдол бүхий бөгөөд улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр эзэмшиж болох бөгөөд энэхүү хэмжээг нь төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг нь харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлдог /АМТХ 5.4/.

Тухайн орд газрыг эзэмшиж буй хуулийн этгээдийн нийт хувьцааны хэдэн хувийн төр эзэмших тухай асуудлыг парламентаар хэлэлцэн тодорхойлох бөгөөд заавал төр эзэмших тухай хатуу зохицуулалт биш юм.

3/ Цөмийн энергийн салбарт компанийн хувьцаа эзэмших эрхийн хязгаарлалт. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон цацраг идэвхит ашигт малтмалын ордыг бусадтай хамтран ашиглах тохиолдолд түүнтэй хамтран байгуулах компанийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг төр үнэ төлбөргүй, шууд эзэмшинэ /ЦЭХ 5.2/. Харин улсын төсвийн хөрөнгийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоон улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн орд газарт цацраг идэвхит ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хувьцааны 34-өөс доошгүй хувийг төр үнэ төлбөргүй шууд эзэмшихээр заасан байна /ЦЭХ 5.3/. Энэ нь цөмийн эрчим хүчний салбарт хөрөнгө оруулсан этгээд нь хуульд заасан тохиолдолд компанийхаа хувьцааг эзэмших эрх нь хуулийн дагуу шууд хязгаарлагдах нөхцөлтэйг тодорхой харуулж байна.

6. Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн хөрөнгийг шууд ба шууд бусаар хураан авахтай холбогдох эрх зүйн зохицуулалт

Хөрөнгө оруулагчдийн хамгийн их болгоомжилдог эрсдлийн нэг бол хөрөнгө оруулалтыг хүлээн авагч улсаас хөрөнгийг шууд болон шууд бусаар хураан авах явдал бөгөөд үүний эсрэг эрх зүйн хамгаалалт эдлэх боломжийг байнга эрэлхийлж байдаг нь ч илт юм. Олон улсын хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх төвд шийдэгдэж буй хэргийн нэлээд хэсгийг ч хөрөнгө хураан авсантай холбоотой маргаан эзэлж байгаа нь тэдгээрээс нийтлэн гаргадаг шийдвэрүүдээс тодорхой харагдана.

Хөрөнгө оруулалтыг хүлээн авагч улсад ч нийгэм, улс төр, эдийн засгийн чиг хандлага, бодлого өөрчлөгдөхтэй холбогдон гадаадын хөрөнгө оруулалтад хандах хандлага өөрчлөгдөх нь түгээмэл тохиолдоно. Ялангуяа байгалийн баялгийг эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны явцад гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн хөрөнгийг хураан авч улсын мэдэлд оруулах, хөрөнгө оруулалтыг хязгаарлах эрхийг эдэлдэг бөгөөд үүний үндэслэл нь “Байгалийн баялгийн хувьд эдлэх улсын бүрэн эрхийн зарчим”⁸⁾-д үндэслэн хэрэгждэг. Аливаа улс орон бүрэн эрхийнхээ дагуу өөрийн орны нутаг дэвсгэр, ард түмний хүрээнд хууль болон бодлогоо чөлөөтэй тогтоох, хэрэгжүүлэх хийгээд өөрийн улсын улс төр, нийгэм, эдийн засгийн тогтолцоог чөлөөтэй сонгохыг хүлээн зөвшөөрдөг.⁹⁾

“Expropriation” буюу хуучин социалист орнуудад “нийгэмчлэх” хэмээх нэрээр хэрэглэгддэг нэр томъёонд хамаарах эрх зүйн ойлголт нь нэг талаас олон улсын нийтийн эрх зүйгээр зохицуулагдах бөгөөд нөгөө талаас хөрөнгө оруулалтыг хүлээн авагч улсын үндэсний эрх зүйгээр зохицуулагддаг. Аливаа улсын зүгээс хувийн өмч, тэр дотроо гадаадын иргэн, хуулийн этгээдийн өмчийг хураан авах нь “төрийн бүрэн эрх” хэмээн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын эрх зүйн зарчмаас урган гардаг.¹⁰⁾ Гэсэн хэдий ч хөрөнгө оруулалтыг хураан авах нь:

- Нийгмийн нийтлэг эрх ашгийн төлөө
- гагцхүү хөрөнгө хүлээн авагч улсад хүчин төгөлдөр үйлчлэх хууль ёсны дагуу
- үл ялгаварлах гадуурхах зарчмын үндсэн дээр
- шуурхай, үр нөлөөтэй, ижил тэнцүү нөхөн төлбөрийн үндсэн дээр

хийгдэж байгаа тохиолдолд л хүлээн зөвшөөрөгдөх ёстой гэдгийг Европын сэргээн босголт, хөгжлийн банкнаас гаргасан “Хөрөнгө оруулалтад хамаарах зохицуулалтын талаархи удирдамж”-д тусгасан бөгөөд улс гүрнүүд Засгийн газар хоорондын Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрт ч энэхүү зарчим тусгалаа олсон байдаг.

Монгол Улсын хувьд гадаадын хөрөнгө оруулалтыг хураан авахтай холбогдсон эрх зүйн зохицуулалт Хөрөнгө оруулалтын тухай хуульд тусгалаа олсон байх бөгөөд эдгээрээс гадна

8) http://legal.un.org/avl/ha/ga_1803/ga_1803.html

9) Art.2/1/, Charter of the UN, 24.Oct 1945, 1 UNTS 26; UNGA Res.2625 /XXV/; Declaration on Principles of International law concerning Friendly Relations and Co-Operation among states in accordance with the Charter of UN.

10) М. М. Богуславский. Олон улсын хувийн эрх зүй, УБ 2006. 161 дүгээр тал.

Эрчим хүчний харти¹¹⁾, Монгол Улсаас бусад улстай байгуулсан Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрт тусгалаа олсон юм.¹²⁾

а/ Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 6.3-т Хөрөнгө оруулагчийн хөрөнгийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хууль бусаар хураан авахыг хориглосон бөгөөд харин гагцхүү нийтийн ашиг сонирхлын үүднээс, зөвхөн хуульд заасан журмын дагуу бүрэн хэмжээгээр нөхөн төлөх нөхцлөөр дайлан авч болохыг заажээ /Хөрөнгө оруулалтын тухай хууль 6.4/. Эндээс харахад Еуропын Сэргээн босголт, хөгжлийн банкны удирдамжид заасан шалгуурууд үндсэндээ тусгагдсан ч дайчлан авах, хураан авах хэмээх тусдаа эрх зүйн үр дагавар бүхий хоёр ойлголтын алинд нь хэрэглэгдэх нь төдийлөн тодорхой бус байна. Угтаа дайчлан гаргуулах, хураан авах нь өөр өөр шалтгаантай байх нь түгээмэл бөгөөд дээрх шалгуурыг аль ч тохиолдолд хэрэглэж болохоор тусгах нь илүү зүйтэй болов уу.

б/ Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр дэх зохицуулалт. Дээр дурьдсаны дагуу өдгөө Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй 37 хэлэлцээрт хөрөнгө оруулагчийн хөрөнгийг хураан авах, түүний эрх зүйн үр дагаварыг товчхон байдлаар тусгасан байдаг. Тухайлбал Монгол Улс, БНСУ-ын хооронд 1991 оны 3 сарын 28-нд батлагдаж, тус оны 4 сарын 30-наас эхлэн хүчин төгөлдөр үйлчилж буй хэлэлцээрийн 5 дугаар зүйлийн 1-г

“Хэлэлцэн тохирогч аль нэг талын хөрөнгө оруулагчаас хийсэн хөрөнгө оруулалтыг бүх нийтийн зорилгоос бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч нөгөө нэг Талын нутаг дэвсгэр пээр улсын өмч болгох, албадан хураах буюу тэдгээртэй адилтгах арга хэмжээ /цаашид албадан хураах гэж нэрлэх/ авахгүй. Албадан хураалт нь ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын үндсэн дээр хууль зүйн ёс журмын дагуу явагдах бөгөөд тэр нь нөхөн төлөгдөнө”

Хэмээн заажээ. Энд мөн л дээр дурьдсан үндсэн шалгуур бүгд тусгагдсан бөгөөд зохих ёсны, үр ашигтай, бүрэн нөхөн төлбөрийг хэрэгжүүлэхээр тохиролцжээ. Ерөнхийдөө энэ төрлийн хэлэлцээрт тусгасан зарчим, зохицуулалт нь хоорондоо төдийлөн ялгаагүй бөгөөд

11) Монгол Улс 1999 оны 7 сарын 21-ны өдөр Эрчим хүчний хартид нэгдэн орсон болно.

12) Монгол Улс 1990 оноос хойш нийт 43 улстай Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрийг байгуулсан ба өдгөө 37 улстай байгуулсан хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчилж байна. Эдгээрт, Австри, АНУ, Беларусь, БНСВьетнам Улс, Бельги Люксембургийн эдийн засгийн холбоо, ХБНГУ, АБНЕгипет, Израйль, Индонез, Их Британи, Казакстан, Куба, Кувейт, Литва, Малайз, ОХУ, Польш, Румын, БНСУ, Тажикстан, Турк, Украин, Унгар, Филиппин, Финлянд, Франц, БНХАУ, Чех, Швейцарь, Энэтхэг, Япон улсууд орно.

нөхөн төлбөрийн аль зарчмыг баримталж байна вэ гэдэг дээр зарим нэг ялгаа ажиглагддаг.

Ийнхүү хураан авах явдлыг дотор нь шууд хураан авалт ба шууд бус хураан авалт хэмээн ангилдгийг бид мэдэх билээ. Өмчийг шууд хураан авах үед хөрөнгө оруулагчийн хувийн өмчлөлтэй хууль ёсоор хамааралтай эрхийг Засгийн газар шууд хяналтдаа авдаг бол шууд бусаар хөрөнгө хураах үед хөрөнгө оруулагчийн өмчлөх эрхэд хяналт тогтоодоггүй харин хөрөнгөө ашиглахад нь хөндлөнгөөс оролцох үйлдлийг хийдэг.¹³⁾Засгийн газраас гадаадын хөрөнгө оруулагчтай хуулийн этгээдийн хөрөнгийг хураан авах¹⁴⁾ нь тухайн улсын хууль тогтоомжийг үндэслэн гаргасан актын үндсэн дээр хэрэгжих ба энд хууль ёсны байх гэдэг шалгуурыг дээд зэргээр хангаж, нотолсон байх нь хожим үүсэх эрсдлээс засгийн газрыг хамгаалах үндэслэл болно. Ялангуяа хөрөнгө оруулагч улсын судлаачид гол төлөв хөрөнгө оруулалтыг хүлээн авагч улсын хууль бус хураан авалт, түүний үр дагаварыг судалдаг бол нөгөө талаас хөрөнгө оруулагчийн хууль бус үйлдэл, хөрөнгө оруулалтын гэрээг зөрчих зэрэг үйлдлээс үүдсэн хураан авалтын үед ямар бодлого баримтлах талаар төдийлөн дурьддаггүй нь нууц биш юм.

Хөрөнгө оруулагчийн хөрөнгийг шууд бусаар хураан авснаас үүдэн хөрөнгө оруулагчийн гаргасан нэхэмжлэлийн үндсэн дээр Монгол Улсын Засгийн газар хариуцагчаар татагдсан томоохон маргаан үүсэж, 5 жил орчим арбитра хэлэлцээний үндсэн дээр нэхэмжлэгч талын ялалтаар дууссан билээ.

Хан Ресурсес хэрэг: 2009 онд Монгол Улс нь цөмийн эрчим хүчний салбарт хийх шинэтгэлийн хүрээнд Цөмийн энергийн тухай хуулийг батлан гаргасан бөгөөд Цөмийн энергийн газрыг байгуулсан юм. 2009 оны 10 сард тус газраас Дорнод төслийн хүрээнд хамаарах ураны хайгуулын болон олборлолтын 2 тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн бөгөөд 2010 оны 4 сард тус зөвшөөрлүүдийг хүчингүй болгожээ. Ийнхүү хүчингүй болгох аливаа шалтгаан буюу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зүгээс Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл байгаагүй гэж нэхэмжлэгч дурьдсан байдаг.

2011 онд нэхэмжлэгч арбитра нэхэмжлэл гаргасан бөгөөд ингэхдээ дараахь 3 зүйлийг үндэс болгосон: 1/ Нэхэмжлэгчийн эзэмшиж байсан тусгай зөвшөөрлийг цуцалснаар хөрөнгө

13) Series on issues in international investment agreements. Taking Property. UNCTAD, 2000. P4.

14) Энэхүү ойлголтыг зарим улс оронд taking property, nationalization хэмээн нэрлэдэг бол барууны улс орнууд гол төлөв expropriation буюу англи хэлнээ өмчлөх эрхийг түдгэлзүүлэх, шилжүүлэн авах, хураан авах гэсэн утгаар хэрэглэгддэг.

оруулалтыг шууд бусаар хураан авсан, 2/ Монголын засгийн газар хөрөнгө оруулагчтай байгуулсан үүсгэн байгуулах гэрээг зөрчсөн, 3/ Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын зан заншлын хэм хэмжээг зөрчсөн. Түүнчлэн нэхэмжлэгч нь Эрчим хүчний хартигаар хүлээсэн үүргээ зөрчсөн хэмээн нэхэмжлэгчдийн нэг болох Хан Недерланд компани үзжээ.

Арбитрын бүрэлдэхүүний дүгнэлтийн томоохон хэсгийг дээр дурьдсан хууль бус шууд бус хураан авалтын тухай асуудал эзэлж байсан юм. Нэхэмжлэгчийн эзэмшиж байсан тусгай зөвшөөрлийг дахин бүртгэхээс татгалзаж, хүчингүй болгосон нь Гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол Улсын хуулийг зөрчсөн, хууль бус үйлдэл хэмээн нэхэмжлэгч үндэслэсэн байна.

Хан Недерландын дурьдсаны дагуу арбитрын бүрэлдэхүүн Монгол Улсын Засгийн газар Эрчим хүчний Хартийн umbrella clause-ийг зөрчсөн гэж үзжээ. “Монгол Улс нь Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиар хүлээсэн үүргээ зөрчсөн нь Эрчим хүчний хартийн 3 дугаар бүлэгт заасан нөхцлийг зөрчсөнөөр үндэслэж байна” хэмээн бүрэлдэхүүн тус маргааны харьяаллын талаархи шийдвэртээ дурьдсан байна.¹⁵⁾

Энэхүү хууль бус, шууд бус хураан авалтын улмаас хариуцагч болох Монгол Улс нь нийт 100 сая ам.долларын хохирлын нөхөн төлбөрийг нэхэмжлэгчид төлөхөөр арбитрын шийдвэр гарсан юм.

Аливаа гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн хөрөнгийг хураан авсантай холбогдуулан үүсэх өмчлөх эрхийн асуудал, түүнчлэн хууль ёсны эсэх асуудал нь хураан авалт хийсэн улсын дотоодын хуулиар зохицуулагдах нь зүйтэй юм. Өөрөөр хэлбэл олон улсын хувийн эрх зүйн *lex rei sitae* зарчмыг хэрэглэх нь зүйтэй гэж судлаачид үздэг.¹⁶⁾ Монгол Улсын зөрчилдөөний эрх зүйд ч энэхүү зарчим тусгагдсан бөгөөд өмчлөх эрхийг тухайн эд хөрөнгө оршин байгаа улсын хуулиар тодорхойлохоор Иргэний хуулийн 547.1.1-д тусгасан.

Нөгөө талаас гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн өмч хөрөнгийг улсын мэдэлд хураан авснаас үүдэн гарах эрх зүйн үр дагавар нь олон улсын нийтийн эрх зүйгээр ч зохицуулагдах асуудал юм. Ихэнхдээ хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн хөрөнгийг хураан авахтай холбоотой асуудлыг олон улсын эдийн засгийн эрх зүйн дэд салбар болон

15) <http://www.italaw.com/sites/default/files/case-documents/italaw4268.pdf>, Decision on Jurisdiction, para. 438.

16) М.М. Богуславский. Олон улсын хувийн эрх зүй. УБ 2006, 164 дүгээр тал.

олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйд хамааруулж судалдаг нь энэ талаархи ном, сурах бичиг болон судалгааны ажлаас тодорхой харагддаг. Цөөн зарим судлаач, тухайлбал ОХУ-ын олон улсын хувийн эрх зүй судлаачдын томоохон төлөөлөгч болох М. М. Богуславский энэхүү асуудлыг өмчийн эрх зүйд хамаарахыг тэмдэглэж, өөрийн бүтээлийнхээ нэг бүлгийг зориулсан байдаг. Хууль зүйн хувьд хөрөнгө оруулагчийн өмчийг шууд ба шууд бусаар хураан авах нь нэг талаас хувийн эрх зүйн зохицуулалт /өмчлөх эрх үүсэх, өөрчлөгдөх, дуусгавах болох зэрэг/, нөгөө талаас захиргааны болон олон улсын нийтийн эрх зүйн зохицуулалт шаардагдах холимог шинжийг агуулсан харилцаа юм.

Дүгнэлт

Дээр дурьдсан асуудлыг нэгтгэн авч үзэхэд гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн эрх зүйн байдал, тэр тусмаа түүний өмчлөх эрхийн асуудал Монгол Улсын эрх зүйд зайлшгүй гүнзгийрүүлэн судалж, үүнийхээ үндсэн дээр одоо байгаа үндэсний хууль тогтоомж болон олон улсын гэрээн дэхь зохицуулалтыг улам боловсронгуй болгох шаардлага тавигдаж байгаа юм. Ялангуяа гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн хөрөнгийг шууд бусаар хураан авсантай холбогдон үүсэх хууль зүйн хүндхэн үр дагавар, өндөр хэмжээний нөхөн төлбөрийн асуудал нь хөгжиж буй улс гүрэнд төдийлөн таатай зүйл биш билээ. Иймээс дараахь арга хэмжээг авах шаардлага зүй ёсоор тавигдаж байна:

1. Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд байгуулахад тавигдах шаардлагыг өөрчлөн найруулж, ингэснээр дотоодын бизнес эрхлэгч, хуулийн этгээд гадаадын хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах өргөн боломжийг нээж өгөх
2. Газрын тухай хууль болон Хөрөнгө оруулалтын тухай хууль дахь газар эзэмших, газар ашиглах хэмээх ялгаатай ойлголтын аль нь цаашид хэрэглэгдэхийг тодорхой болгох, өөрөөр хэлбэл хууль тогтоомж дахь нэр томъёог жигдрүүлэх
3. Гадаадын хөрөнгө оруулагчийн хууль бус үйлдлээс үүдэн хөрөнгийг шууд ба шууд бус хураан авах үед баримтлах нөхөн төлбөрийн ялгаатай бодлогыг боловсруулж, хууль болон олон улсын гэрээнд тусгах

Эцэст нь дүгнэхэд, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн эрх зүйн байдал, өмчлөх эрхийн асуудал нь нэг талаас үндэсний эрх зүй /иргэний болон захиргааны эрх зүй/, нөгөө талаас олон улсын нийтийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах холимог

шинжийг агуулсан харилцаа болно. Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн эрхийг тэгш хангах, ялгаварлан гадуурхахгүй байх, хууль бусаар өмчлөх эрхэд халдахгүй байх, тогтвортой эрх зүйн зохицуулалтыг бий болгож мөрдүүлэх нь онолын болон практикийн чухал ач холбогдолтой бөгөөд хүлээн авагч улсын гол үүрэг юм. Эдгээр нөхцлийг хангаснаар эдийн засагт эерэг үр нөлөө бүхий хөрөнгө оруулалтыг татах гол нөхцөлд болох билээ.

Түлхүүр үг: өмч, хөрөнгө оруулалт, шууд ба шууд бус хураан авалт, гадаадын хөрөнгө оруулалт, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд, өмчлөх эрхийн хязгаарлалт, олон улсын нийтийн эрх зүй, хувийн эрх зүй, хөрөнгө оруулалтын тухай хууль.

CURRICULUM VITAE



BAIGAL Enkh-Amgalan

Education:

June 1996	General school ¹ 31
June 2000	International Law (B.A.) School of Law National University of law
January 2002	Master of Arts in Law, International law Department, School of law, National University of Mongolia
Oct.2004- to April 2006	Magister legume student on the Civil law, Magister legum program, Bayreuth University, Germany
December 2007- present	Doctoral student at the Law School, National University of Mongolia, aimed Dissertation topic “Legal problems of the Investment Contract”

Working experience:

Senior Lecturer of School of law, NUM since 2002, teaching Private International Law, International Business Law and International Investment Law. Main topic of the legal research is International Investment law and dispute settlement.

Professional qualification:

since 2003 licensed by the Ministry of Justice and Home Affairs of Mongolia as an attorney at law to give legal advice on Mongolian law and to represent clients in the courts of Mongolia. Member of the Mongolian Bar Association.

Languages: Native Mongolian, fluent German, English and basic knowledge of Russian.

List of publication

1. General part of Civil law /handbook/. Ulaanbaatar 2009., 1st edition.
2. General part of Civil law /handbook/. Ulaanbaatar 2011., 2nd edition.
3. Private International Law /digest of documentary/. Ulaanbaatar 2011. 2nd Edition
4. Private International Law /handbook/. Ulaanbaatar 2012. 1st edition.
5. Private International Law /digest of documentary/. Ulaanbaatar 2011. 3rd Edition
6. Private International Law /handbook/. Ulaanbaatar 2016. 2nd edition.
7. Feature and System of Investment dispute settlement between the state and investor of other states. N2013/3
8. Legal problem of jurisdiction at International Investment Arbitration. 2013/3 Law Journal.
9. International Investment Arbitration- definition of Investor. 2015/3 Journal Measurement of Justice.
10. Some problem of legal regulation of International Investment Treaty. Conference book of “National Security of Mongolia and International Treaty” 2015/5.

‘몽골 해외투자 기업의 법적 지위 및 소유권 관련 법적 규정’에 대한 토론문

김재희

1. Baigal 교수님의 발표에 감사드립니다. 몽골의 투자법 등 해외투자에 관한 관련 법과 현황을 접하게 되어 아주 배우는 바가 많았습니다. 변호사로 로펌에서 근무할 당시 해외투자자들이 한국에 투자하는 것과 관련한 법률자문업무를 하며 한국의 외국인투자촉진법을 접하여 왔기에 이번 한몽국제학술대회에서 양국간의 법제를 비교하여 볼 수 있는 기회가 주어져서 개인적으로 아주 반갑게 생각하였습니다. 발표의 방향과 구체적인 내용에 대하여 특별히 반론을 제기하거나 할 부분은 없으며, 이번 발표를 통하여 몽골의 외국인투자에 대한 현황 및 관련 법제를 접하고 배울 수 있는 계기가 되었으므로 이에 대응하는 한국의 외국인투자 관련 법제의 해당 부분들을 간략히 소개하는 것으로 토론에 갈음하고자 합니다.
2. 발표자께서는 몽골의 경우 해외투자 형태는 여섯 가지 종류가 있다고 하셨습니다. 한국의 경우 외국인투자촉진법에서 외국인투자에 관한 전반적인 사항을 규율하고 있는바, 그에 따른 외국인투자는 다음과 같은 유형이 있습니다.
 - 국내기업의 주식 또는 지분의 취득
 - 장기차관
 - 비영리법인에 대한 출연(과학기술분야에서 독립된 연구시설을 갖추고 일정 요건에 해당)
 - 기타 비영리법인에 대한 출연으로 외국인투자위원회가 외국인투자로 인정하는 경우
3. 발표자께서는 몽골헌법과 토지법에 의거하여 해외투자자는 몽골의 토지소유권이 없다고 하셨습니다. 한국의 경우 1961년 최초로 제정된 외국인토지법은 외국인의 토지취득을 엄격히 제한하는 허가제를 채택하였으나 선진국들의 토지시장 개방흐름과 IMF 외환위기 이후 외국자본 유치의 필요성에 따라 1998년에 외국인토지취득 제한을 철폐하고, 외국인의 토지취득을 허가제에서 신고제¹⁾로 전환하는 한편, 토지매매자금의 반출, 반입 허용을 통해 국내 부동산 시장을 외국인에게도 개방하였습니다. 다만 상호주의의 원칙에 따라 자국

안의 토지의 취득 또는 양도를 금지하거나 제한하는 국가에 소속된 외국인에 대하여는 한국 안의 토지의 취득 또는 양도를 금지하거나 제한할 수 있습니다.

4. 발표자께서는 몽골에서 해외투자가 집중되어 있는 광물분야의 경우, 전략적으로 중요한 광물광산의 채광시 투자법인의 일정 지분을 국회의 의결을 통하여 국가가 소유할 수 있으며, 특히 원자력 분야 즉 방사선 광물의 경우에는 직접적으로 법으로 기업의 주식 소유권을 한정하고 있다고 하셨습니다. 한국의 경우 광업을 영위하기 위하여는 반드시 광업권이 있어야 하는바, 과거에는 외국인이나 외국법인에 대하여는 광업권을 설정할 수 없도록 제한을 하였으나 1999. 7. 1. 광업법의 개정으로 그러한 제한을 폐지하고, 2011. 2. 28.자 개정된 광업법은 상호주의 원칙에 따라 외국인이나 외국법인의 국내 광업권 설정을 가능하게 하고 있습니다²⁾. 다만 석유에 대한 광업권은 정부만이 가질 수 있는 것으로 제한하고 있습니다.³⁾

1) 외국인토지법 4조 제4조(계약에 따른 토지취득의 신고 등) ① 외국인, 외국정부 또는 대통령령으로 정하는 국제기구(이하 "외국인등"이라 한다)가 대한민국 안의 토지를 취득하는 계약(이하 "토지취득계약"이라 한다)을 체결하였을 때에는 계약체결일부터 60일 이내에 대통령령으로 정하는 바에 따라 시장(구가 설치되지 아니한 시의 시장과 「제주특별자치도 설치 및 국제자유도시 조성을 위한 특별법」 제11조에 따른 시장을 말한다. 이하 같다)·군수 또는 구청장에게 신고하여야 한다.

FOREIGNER'S LAND ACQUISITION ACT Article 4 (Report of Land Acquisition by Contract)(1) In cases where a foreigner, a foreign government, or an international organization prescribed by Presidential Decree (hereinafter referred to as "foreigner, etc.") has concluded a contract for land acquisition in the territory of the Republic of Korea (hereinafter referred to as a "contract for land acquisition"), the foreigner, etc. shall make a report of the land acquisition to the head of Si (referring to the head of Si where a Gu is not established and the head of Si under Article 17 of the Special Act on the Establishment of Jeju Special Self-Governing Province and the Development of Free International City; hereinafter the same shall apply)/Gun/Gu within 60 days from the conclusion date of the contract as prescribed by Presidential Decree

2) 광업법 제10조의2(외국인의 권리능력) ① 외국인은 다음 각 호의 어느 하나에 해당하는 경우에만 광업권을 가질 수 있다.
1. 그 외국인이 속하는 국가에서 대한민국 국민에 대하여 그 국가의 국민과 동일한 조건으로 광업권을 갖는 것을 인정하는 경우
2. 대한민국이 그 외국인에 대하여 광업권을 갖는 것을 인정하는 경우에는 그 외국인이 속하는 국가에서도 대한민국 국민에 대하여 그 국가의 국민과 동일한 조건으로 광업권을 갖는 것을 인정하는 경우
3. 조약 및 이에 준하는 것에서 광업권을 갖는 것을 인정하고 있는 경우

MINING INDUSTRY ACT Article 10-2 (Capacity of Enjoyment of Rights for Foreigners)(1) Foreigners shall be allowed to have the rights to mine only in any one of the following cases:

1. Where the nation of the foreigner shall admit that the national of Korea has the right to mine in the same condition as his/her own national in the nation he/she belongs to;
2. Where Korea admits the foreigner to have the right to mine, and the nation of the foreigner admits that the national of Korea has the right to mine in the same condition as his/her own national;
3. Where the right to mine shall be admitted in the treaty and its equivalent.

3) 광업법 제9조(석유에 관한 광업권에 대한 특례) ① 석유에 관한 광업권은 정부만이 가질 수 있다.

MINING INDUSTRY ACT Article 9 (Special Case for Petroleum Mining Rights)(1) Mining rights for petroleum may be

5. 발표자께서는 해외 투자법인의 권리를 차별하지 않고 공평하게 대우하며 불법 소유권을 근절하는 것이 중요한 과제라고 하셨는데, 현재 그리고 앞으로 어떤 식으로 관련법제에 반영하여 나갈 것인지 그 동향이 궁금합니다. 참고로 한국의 외국인투자촉진법에서는, 외국인은 법률에 특별한 규정이 있는 경우 외에는 제한을 받지 않고 한국내에서 외국인투자업무를 수행할 수 있는 것으로 규정하고 있으며, 외국인직접투자의 경우 투자보호수준을 간접투자보다 보호하여 지원하고 있습니다. 가령 외국투자가가 취득한 주식 등의 매각 대금에 대하여는 대외송금이 보장되며, 외국인투자촉진법에서 정하는 외국인투자에 대하여는 외국환거래법상의 외국환거래의 정지(safeguard)조항의 적용이 배제되고, 또한 외국인투자기업은 원칙적으로 영업이나 조세감면에 관하여 대한민국 국민 또는 법인과 같은 대우를 받습니다.
6. 과거 한국에서는 대내외 경제여건의 변화에 부응하여 경제, 산업정책과 연계된 외자도입 정책이 추진되어 왔으며 그에 따라 지속적인 고도성장을 달성할 수 있었습니다. 한국의 외자 및 외국인투자 관련 법제의 발전과정을 보면, 외자 및 외국인투자의 도입과 유치 그 자체보다는 활용에 주안점을 두었으며, 외자의 활용에 있어 정부중앙부처의 주도적인 역할이 두드러졌고 정부에 막대한 권한과 기능이 집중되어 있었습니다. 외국인투자촉진법은 외국인투자를 유치하되 법과 정책을 통하여 그로 인한 부작용과 피해를 최소화하는 것에 목표를 두고 수시로 개정되어 왔습니다. 이러한 한국의 외자도입법 및 외국인투자촉진법의 변천 양상은 몽골의 향후 해외투자유치를 위한 관련법제의 정비 및 발전방향에도 참고가 될 수 있지 않을까 감히 생각하여 봅니다.

발표에 다시 한 번 감사드립니다.



종합토론

〈“한몽 민사법의 쟁점”에 대한 종합 토론문〉

토론자 : 국회사무처 박찬수 이사관

발표문을 통해 몽골이 1990년부터 사회주의체제에서 시장경제체제로 전환되면서 이에 맞추어 민사법제를 지속적으로 정비해 오고 있지만, 아직도 논쟁의 소지가 많은 규정들이 현행 법제에 산재하고 있다는 것을 알게 되었습니다.

이처럼 몽골의 현행 민사법제에 논쟁의 소지가 많은 규정들이 산재하고 있는 것은 체제전환 과정에서 제한된 시간 내에 새로운 제도를 도입하는데 따른 불가피한 측면이 있었겠지만, 그 근본 원인은 국민과 전문가들의 의견을 충분히 수렴해서 입법에 반영하지 못한 입법과정의 부실에 있지 않았을까 하는 생각을 해 보았습니다.

이와 관련하여 네 분의 몽골국립대학교수님들께 질문을 드리겠습니다.

1. 몽골 현행 민사법제에 논쟁의 소지가 많은 규정들이 산재하고 있는 주요 원인은 무엇이라고 생각하시는지?
2. 교수님들께서 오늘 발표문에서 문제를 제기하신 내용들이 만약 입법과정에서 국민과 전문가들의 의견을 충분히 수렴해서 입법에 반영했었다면 현행 법제와 같이 규정되지 않았을 것이라고 생각하시는지?
3. 몽골의 입법과정에 국민이나 전문가들이 참여해서 입법의견을 개진할 수 있는 공식적인 통로가 마련되어 있는지?

※ 참고로, 우리나라 입법과정에서는 법률안 입안단계에서부터 입법전문기관과 전문가의 지원을 받을 수 있도록 되어 있고, 국회의 법률안 심의과정에서도 입법예고, 공청회 등을 통하여 국민과 전문가들의 의견을 수렴해서 입법에 반영하는 시스템이 구축되어 있음.

4. 몽골 입법과정에서 시급하게 개선할 점이 있다면, 무엇이라고 생각하시는지?

〈지정토론〉

토론자 : 국민대학교 법과대학 김민섭 교수

오늘 학술세미나의 주제는 “몽골민법의 개정과 한국민법”입니다. 이러한 주제 하에 발표된 논문들을 보면, 주로 몽골에서의 재산의 사유화와 그 과정에서 나타난 문제점들을 지적하는 내용으로 보입니다. 특히 Lhagvasuren BANZRAGCH 교수님의 논문은 사유화를 위한 민법의 개정과 그러한 민법에 근거한 몽골 국민들의 소유권 및 재산권의 구체화 과정에서 나타난 권리의 충돌 혹은 내용적 모순 등을 지적하고 있습니다.

아시다시피 몽골은 과거 사회주의체제를 유지하다가 1992년의 헌법개정으로 사회주의체제에서 자유시장경제체제로 전환한 이른바 ‘체제전환국’입니다. 따라서 몽골의 경우는 종래의 사회주의적인 재산권 시스템을 어떻게 사유화과정에서 자유시장경제체제에서의 재산권 시스템으로 연착륙시키는가가 주된 관심사가 될 것으로 보입니다. 반면 한국의 경우에는 부동산 투기의 억제나 토지의 효율적 이용 등을 이유로 점점 그 제한이 강화되어 가는 것으로 볼 수 있습니다. 특히 토지 행정에 있어서 계획에 의한 행정의 확립은 토지소유권에 대한 제한을 더욱 강화시키고 있습니다. 따라서 한국의 경우에는 재산권이 헌법상 보장되는 기본권의 하나라는 점과 그 재산권이 갖는 강한 사회성·공공성의 특성을 어떻게 조정하는가가 주된 관심사라 할 것입니다. 따라서 양 국의 재산권을 바라보는 시각 및 그에 따른 관심의 방향은 큰 차이가 있다고 보여 집니다.

따라서 이하에서는 오늘 논의에서의 배경이 될 수 있는 한국에서의 재산권, 특히 토지재산권의 제한에 관한 간단하게 말씀드리고 발표자에 대한 간단한 질문을 하면서 마무리 하고자 합니다.

대한민국 헌법상의 재산권

근대 초기에 재산권은 전국가적이고 천부적인 인권으로 보았고, 이는 재산권의 절대성과 계약의 자유로서 법적 보장을 받게 되었다. 이렇듯 재산권을 천부적 권리로 파악한 것은 서양 중세국가의 봉건적 신분관계에서 인간을 자유롭게 하는데 있어서 사유재산을 보장함으로써 재산적 힘으로 신분적 예속을 해소할 필요가 있었던 것이 가장 큰 이유가 될 것이다.

그러나 자본주의와 시장경제의 발달과 더불어 자본의 집중, 공업사회의 도래에 따른 계급분

화, 계층 간의 갈등, 시장의 실패 등이 심화되면서 점차 재산권과 계약의 자유가 가지는 절대성은 약화되고 그 수정을 요하게 되었다. 그래서 오늘날 국가에서는 재산권도 다른 기본권과 마찬가지로 상대적인 권리로 되었고 법률에 의한 제한이 가능한 것으로 보고 있다.

우리 헌법도 재산권에 대해서 이러한 태도를 취하고 있다. 우리 헌법은 제23조 제1항 1문에서 “모든 국민의 재산권은 보장된다”고 규정하여 대한민국 국민의 재산권이 헌법상의 기본권으로 보장됨을 선언하고 있다. 그러나 제2문에서는 “그 내용과 한계는 법률로 정한다”고 규정하여 헌법상 보장되는 재산권의 내용을 입법자에게 맡기고 있고 동조 제2항에서는 “재산권의 행사는 공공복리에 적합하도록 하여야 한다”고 규정하여 다른 방어적 기본권보다 더 강한 사회적 기속을 받는 권리로 규정하고 있다. 이러한 재산권의 사회적 기속 또는 사회적 제약은 ‘입법자가 장래에 있어서 재산권자의 권리와 의무를 일반적·추상적 형식으로 확정’함으로써 나타나는, 즉 재산권에 내재되어 있는 것으로서 국민은 그에 따른 재산권의 제한을 수인해야 할 의무를 부담하게 된다. 더 나아가 동조 제3항은 “공공필요에 의한 재산권의 수용·사용 또는 제한 및 그에 대한 보상은 법률로써 하되, 정당한 보상을 지급하여야 한다”고 규정하여 헌법과 법률에 의해 보호되는 재산권이라 할지라도 공공필요에 의한 경우 국가가 재산권을 침해(공용침해)할 수 있는 근거를 마련해 두고 있다. 다만 이 경우에 헌법은 보상을 하도록 명령하고 있는 바, 보상이 필요한 공용침해는 ‘국가가 구체적인 공적 과제의 이행을 위하여 이미 형성된 구체적인 재산권적 지위를 전면적 또는 부분적으로 박탈하는 것’으로 보고 있다.

요컨대 한국의 재산권은 비록 헌법상의 자유로 보장되고는 있으나 다른 자유권에 비하여 더 강한 제한을 받을 수 있음을 예정하고 있으며 그러한 제한이 사회적 기속에 머무르는 한 보상도 이루어지지 않는다.

토지재산권과 토지공개념

앞서 우리 헌법상의 재산권의 한계와 제한에 관해서 이야기 했지만 토지재산권에 있어서의 제한은 더욱 강력한 것으로 보인다. 토지재산권에 관한 규정은 헌법 제23조 이외에도 제9장 ‘경제’의 장에서도 규정하고 있는데, 제120조 제2항에서는 “국토와 자원은 국가의 보호를 받으며, 국가는 그 균형 있는 개발과 이용을 위하여 필요한 계획을 수립한다”고 하여 토지이용계획에 따른 제한을 예정하고 있고, 제121조에서는 경자유전의 원칙을, 또 제122조에서는 “국가는 국민 모두의 생산 및 생활의 기반이 되는 국토의 효율적이고 균형있는 이용·개발과 보전을 위하여 법률이 정하는 바에 의하여 그에 관한 필요한 제한과 의무를 과할 수 있다”고 하여 국토의 이용과 개발과 보전을 위하여 광범위한 제한가능성을 예정하고 있다.

과거 한국의 경우 토지에 관한 집착이 심하여 토지가 가장 유리한 자산으로 인식되었으며, 개발시대를 거치면서는 그 효율적 이용보다는 가격 상승을 통한 부의 축적 대상이 되어 왔던 것이 사실이다. 이에 토지문제의 해결은 우리 사회의 가장 큰 과제로 등장하였고 그에 따라 이른바 '토지공개념'이라는 사회적 용어가 탄생하기에 이르렀다. 토지공개념은 ① 자연적으로 존재하는 토지는 공기와 물과 같이 천부의 것으로 인간의 노동에 의한 생산물이 아니고, ② 새롭게 만들어 낼 수 없는 유한한 것이며, ③ 현재를 살아가고 미래를 살아갈 인간의 생존에 필수적인 것으로 토지에 인간이 살아간다는 것은 천부의 인권에 해당하므로 강한 사회성·공공성을 가질 수밖에 없다는 관념에서 성립했다.

이러한 토지공개념에 기초한 여러 가지 토지 정책들이 나타나게 되는데, 그 이용과 관련해서는 토지이용계획에 의하여 강력한 제한을 가하고 있으며(「국토의 이용 및 계획에 관한 법률」이 이러한 내용을 규정하고 있다), 그 소유의 제한에 있어서는 종합부동산세나 양도소득세의 증과세 등 여러 조세정책들로 그 소유를 실질적으로 제한을 가하고 있다. 또한 처분에 있어서도 토지거래계약허가제 등을 통하여 제한을 가하고 있다.

요컨대 상대적으로 많은 제약을 받는 재산권 중에서도 토지재산권은 가장 강력한 제약을 받는 재산권의 하나로 꼽히고 있고, 이러한 추세는 앞으로도 계속될 것으로 보인다.

이상으로 우리 헌법상의 재산권 및 토지재산권의 제한에 관한 간략한 내용을 살펴보았습니다. 토론문의 내용이 다소 오늘의 주제와 동떨어진 면이 없지 않으나 오늘 논의할 주제의 대상인 재산권에 관한 기본적인 내용으로 이해해주시면 감사하겠습니다.

다음으로는 발표자에 대한 질문을 하도록 하겠습니다.

우선 Lhagvasuren BANZRAGCH 교수님께 질문하고자 합니다. 민법상의 소유권 관념과 그 실현은 헌법상의 재산권 보장과 밀접한 관련이 있다고 생각되어집니다. 몽골 헌법상의 재산권 보장 규정은 구체적으로 어떠한 내용을 담고 있는지 설명해 주시면 감사하겠습니다.

다음으로 Davkharbayar. Ts 교수님께 질문하고자 합니다. 다른 문헌 등을 읽어보면 몽골에서는 국가 등이 소유하고 있는 토지를 사유화하는 과정에서 토지소유 또는 토지의 점유 등을 위한 허가제를 운영한 것으로 보입니다. 이러한 제도를 실시하게 된 배경 및 그 요건 등에 관하여 설명해 주시면 감사하겠습니다.

〈지정토론〉

토론자 : 국민대학교 법과대학 김수정 교수

몽골의 민법상 소유권은, 1990년 대 이후 자유시장경제의 채택으로 인해 현재와 같은 형태로 발전된 것으로 생각됩니다. 현재 몽골 민법의 소유권 보장의 형태는 대략적으로 대륙법 체계를 따른 것으로 보입니다. 25년여년 만에 사적 소유권 체계를 발전시키는 과정에서 생기는 여러가지 흥미로운 문제들을 접하게 해 주신 점에 대해 감사드립니다.

1. Lhagvasuren BANZRAGCH 교수님은 현재 몽골의 소유권 보장이 충분하지 않다고 보고 있고 그 구체적인 예로 몽골 민법 제 237조 9항, 민법 제 175 조 제4, 5항, 협동조합법 제 48조를 들고 있는 것으로 보입니다. 그 외에도 몽골의 소유권 보호가 아직은 충분하지 않은 다른 예를 좀 더 소개해주실 수 있으실까요?
2. Yanjinkhorloo 교수님의 발표에 따르면, 몽골 헌법재판소 판결이 있기 전에는 부동산에 일단 저당권이 설정되면 그 채권자의 동의가 없이는 저당권이 설정된 부동산을 양도할 수 없게 되는데. 이는 저당권이 일단 설정되면 저당권설정자 즉 소유자는 사실상 부동산을 처분할 수 없게 되어 경제적으로 양도담보와 큰 차이가 없었을 것이라고 추측합니다. 몽골 헌법재판소 판결이 있기 전까지, 저당권과 부동산 양도담보 중 어느 것이 거래계에서 더 많이 사용되었는지 말씀해 주실 수 있을까요?
3. BAIGAL E 교수님의 발표에 따르면, 해외의 기업이 몽골에 투자를 할 경우 그 기업이 몽골에 취득한 소유권이 상당한 제한을 받고 있는 것을 보입니다. 발표자 스스로도 이 문제 때문에 해외 기업의 몽골에 대한 투자를 활성화하기 위해서는 법률을 명확히 해서 해외투자자의 불법행위로 인한 직접적 또는 간접적 몰수에 관련된 배상정책을 개정할 필요가 있다고 강조하고 있습니다.

발표자도 강조하다시피 해외투자를 활성화하기 위해서는 해외투자자들로 하여금 자신의 투자가 특별한 사정이 없는 한 그 나라의 정부에 의해 보호될 것이라는 점은 매우 중요한 요소일 것이라고 생각합니다. 발표자가 생각하시기에, 현재 몽골에서 외국인투자자가

강력하게 보호를 받지 못하고 있다면, 이는 몽골에서 아직 소유권 전반에 대한 보호가 충분하지 않은 이유가 더 크게 작용한다고 보시는지요? 아니면 외국인 투자자에 대한 보호가, 몽골 자국민에 대한 소유권 보호 정도에 미치지 못한다고 생각하시는지요?

4. 마지막으로, 이렇게 몽골 교수님 여러분들이 준비하신 발표문을 보면, 몽골의 민법 체계상 소유권 보호에는 과거 사회주의적 경향이나 유목 문명의 특징 등의 영향을 미쳐, 우리나라 몽골 민법이 모델로 삼은 대륙법계 유럽 국가들만큼 소유권이 전반적으로 강하게 보호되지는 않는다는 인상을 받았습니다. 발표자 여러분들은, 몽골 민법의 소유권이 대륙법 체계의 그것과 동일하게 보장되어야 한다고 보시는지요? 아니면 지금보다는 보호를 강화하되, 몽골 사회의 전통적인 특징도 고려되어야 한다고 보시는지요?

유익한 발표에 대해, 그리고 답변해 주실 것에 대해 미리 감사드립니다.



행사동정





